



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ, ХАМГААЛАХ,
ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ҮНДЭСНИЙ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН
ГЭРЭЭНД НИЙЦҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЗАРИМ ХУУЛЬД ХИЙСЭН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

2024 он

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

4 сар

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн
ухааны доктор

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Энх-
Амгалан

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хүний
эрх, олон улсын эрх зүйн секторын эрхлэгч

Р.Хатансайхан

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Нийтийн эрх зүйн секторын эрдэм
шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

М.Ганди

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хувийн
эрх зүйн секторын эрдэм шинжилгээний
ажилтан

Х.Санчир

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрүүгийн эрх зүйн секторын эрдэм
шинжилгээний ажилтан

Б.Баярмаа

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Нийтийн эрх зүйн секторын эрдэм
шинжилгээний ажилтан

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	6
УДИРТГАЛ	7
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	8
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь.....	8
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох.....	9
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох.....	10
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох.....	10
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох.....	11
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	14
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	15
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	16
3.1.Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	16
3.1.1. Зорилгод хүрсэн түвшин 16	
Хэсгийн дүгнэлт 17	
3.2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	17
3.2.1. Зорилгод хүрсэн түвшин 17	
3.2.2. Практикт нийцэж байгаа байдал 18	
Явцын дүгнэлт 20	
3.3.Цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар.....	20
3.3.1. Зорилгод хүрсэн түвшин 20	
3.3.2. Практикт нийцэж байгаа байдал 21	
Явцын дүгнэлт 22	
3.4.1. Зорилгод хүрсэн түвшин 23	
Явцын дүгнэлт 25	
3.5.Өмгөөлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	25
3.5.1. Зорилгод хүрсэн түвшин 26	
3.5.2. Практикт нийцэж байгаа байдал 27	
Явцын дүгнэлт 28	
3.6.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	28
3.6.1. Зорилгод хүрсэн түвшин 29	
Явцын дүгнэлт 37	
3.7.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	38
3.7.1. Зорилгод хүрсэн түвшин 38	
Явцын дүгнэлт 39	
3.8.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	39
3.8.1. Зорилгод хүрсэн түвшин 40	
Явцын дүгнэлт 40	
3.9.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	40
3.9.1. Зорилгод хүрсэн түвшин 41	
3.9.2. Практикт нийцэж байгаа байдал 43	

Явцын дүгнэлт	44
3.10.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАР	44
3.10.1. Зорилгод хүрсэн түвшин	44
3.10.2. Практикт нийцэж байгаа байдал	46
Явцын дүгнэлт	47
3.11.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар.....	47
3.11.1. Зорилгод хүрсэн түвшин	48
3.11.2. Практикт нийцэж байгаа байдал	48
Явцын дүгнэлт	50
3.12.Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	50
3.12.1. Зорилгод хүрсэн түвшин	50
Явцын дүгнэлт	51
3.13.Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагавар	51
3.13.1. Зорилгод хүрсэн түвшин	51
3.13.2. Практикт нийцэж байгаа байдал	54
Явцын дүгнэлт	60
3.14.Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	60
3.14.1. Зорилгод хүрсэн түвшин	61
3.14.2. Практикт нийцэж байгаа байдал	62
Явцын дүгнэлт	63
3.15.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар ...	63
3.15.1. Зорилгод хүрсэн түвшин	63
3.15.2. Практикт нийцэж байгаа байдал	64
Явцын дүгнэлт	68
3.16.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар Хатанаа /4/	69
3.16.1. Зорилгод хүрсэн түвшин	69
3.16.2. Практикт нийцэж байгаа байдал	70
Явцын дүгнэлт	71
3.17.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар.....	71
3.17.1. Зорилгод хүрсэн түвшин	72
Зорилгод хүрсэн түвшин	72
Явцын дүгнэлт	76
3.18.Агаарын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагавар	77
3.18.1. Зорилгод хүрсэн түвшин	77
Явцын дүгнэлт	78
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	79
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ	85

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
МУҮндХ	Монгол Улсын Үндсэн хууль
МУҮндХЦтХ	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
МУ	Монгол Улс
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТБАНтХ	Төрийн болон албаны нууцын тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УБ	Улаанбаатар
ҮХЦтХ	Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
ХХтХ	Харилцаа холбооны тухай хууль
ХК	Хувьцаат компани

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХЗГ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХХТтХ	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЭЗБтХ	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	11
Хүснэгт 2. Хуульч, өмгөөлөгчдийн төлж буй татвар, хураамж (2024 он)	28
Хүснэгт 3. Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын зохицуулалт	33
Хүснэгт 4. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн	53
Хүснэгт 5. Эрүүгийн хуульд заасан хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн бүрэлдэхүүн.	53
Хүснэгт 6. Монгол Улсын Эрүүгийн хууль болон НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжийг хангасан байдал	54
Хүснэгт 7. Хохирогчийг тодорхойлсон тодорхойлолтууд	74

УДИРТГАЛ

Монгол Улс 1961 оноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болсноос хойш Нэгдсэн Үндэстний байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд, үүнээс хүний эрхийн 18 суурь гэрээний 17-д нэгдэн ороод байна. Монгол Улсад шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хангах, зөрчигдсэн эрхийг сэргээх, хүн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн бие даасан 590 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

2020 оноос хойшхи хугацаанд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хүний эрхийг хангах чиглэлээр эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, авлигатай тэмцэх цогц бодлого, шүүх эрх мэдлийн шинэтгэл, мэдээллийн ил тод байдлыг хангах, хүний мэдэх эрхийг хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, төрийн үйл ажиллагааны шуурхай байдлыг хангахад чиглэсэн цахимын багц хуулиуд, боловсролын багц хуулиуд, нийгмийн даатгал, халамжийн багц хуулиуд, хөдөлмөрлөх эрх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр холбогдох хуулиудын шинэчилсэн найруулгыг боловсруулж, Улсын Их Хурлаас баталж, хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаанд тодорхой дэвшил гарган ажиллаж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолоор дээр дурдсан илтгэл, тайланг хэлэлцээд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр анхаарах асуудлыг тодруулж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.¹

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.5-т төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нөхцөл, байдал үүссэн гэж үзэхээр заасан.²

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагад үндэслэн, хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэстний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

¹Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759532085661>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.15.

²Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338&showType=1>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.15.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Их Хурлын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулах авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолд тусгасан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр анхаарах асуудалд үндэслэн, ХЗДХЯ-наас холбогдох хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг даалгасан. Уг ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийсэн. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэн, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийнхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр баталсан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолоор хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр дараах асуудалд анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүнд³:

1/Халдашгүй чөлөөтэй байх эрхийн талаар:

а/сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэн боловсронгуй болгох талаар санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б/сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах шийдвэр бүрийн үндэслэл, шалтгааныг хэлэлцдэг шүүхийн хэлэлцүүлгийг бий болгох, хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг судалгааг тогтмол гаргаж холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг байх, тухайн

³ Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759532085661>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.15.

хүн өөрийг нь баривчилсантай холбоотой баримт материалыг холбогдох байгууллагаас гаргуулан авах эрх зүйн зохицуулалтын талаар санал боловсруулах;
в/цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах нийтлэг журам, цагдан хорих үндсэн болон сунгах хугацаа, өсвөр насны яллагдагчийг цагдан хорих тусгай журам, цагдан хорих үндэслэлд хамаарах хэт ерөнхий болон өргөжүүлсэн зохицуулалт, шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн шатанд таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх асуудлыг нарийвчлан зохицуулах хууль тогтоомжийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
г/цагдан хорих байранд гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах хүрээг хязгаарлаж, хүний эрхийн зарчимд нийцүүлэн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, танилцуулах;
д/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд таслан сэргийлэх арга хэмжээний зөвшөөрлийг шуурхай шийдвэрлэх чиг үүрэг бүхий зөвшөөрлийн шүүх бий болгох асуудлыг судалж, танилцуулах;
е/бүх насаар хорих ялыг хорих ялаас тусдаа ялын төрөл болгон хуульчлах асуудлыг судлан үзэж, ял эдлүүлэх дэглэм, зохион байгуулалт, сургалт, хөдөлмөрийн стандартыг шинээр тогтоох, түүнчлэн хорих ял эдлүүлэх дэглэмийн зэрэглэл хүндрүүлэн ганцаарчлан хорьж байгаа тохиолдлыг таслан зогсоох;
ё/эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэл, эрх зүйн зохицуулалтыг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх саналыг боловсруулж танилцуулах;
ж/зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах санал боловсруулж танилцуулах;
з/үндэсний аюулгүй байдлыг хангах болон шүүхэд нотлох баримтаар үнэлэгдэх зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2/Хүүхдийн эрхийн талаар:

а/ерөнхий боловсролын сургуулийн стандартын шаардлага хангахгүй байгаа дотуур байрыг шинэчлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг шийдвэрлэх;
б/Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэргийн холбогдогч, хохирогч, гэрч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх;
в/хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүнд хяналт тавих, сурч боловсрох эрхийг нь хангах журмыг нарийвчлан зохицуулах.

3/Ахмад настны эрхийн хэрэгжилтийн талаар:

а/ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
б/ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийг татварын болон бусад бодлогоор дэмжих;
в/ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

4/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн зүйлчлэлд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл байдалд тооцохоор зааж тодорхойгүй байдал үүсгэж байгаа зохицуулалтыг өөрчлөх талаар болон эрүү шүүлт тулгаж авсан мэдүүлгээс бусад нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлэх агуулга хэвээр байгааг залруулах талаар хуулийн төсөл боловсруулах;

б/эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах.

5/Бусад асуудлын талаар:

а/Монгол Улсын Үндсэн хууль, иргэний үндсэн эрхийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

б/Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдмэл байдлаар тодорхойлох, цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

в/хоригдлын хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, байнгын ажлын байраар хангахад чиглэсэн салбар дундын нэгдсэн бодлого, хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ "Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж, санхүүжилтийг шийдвэрлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

Дээр дурдсан хүрээнд холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр хууль зүйн бодлогын үндэслэлийг тодорхойлохын тулд, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасанчлан хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа юун түрүүнд тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай.

Түүнчлэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.5-т төрөөс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах талаарх үүргээ биелүүлэхгүй байгаа буюу Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж байгаа бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх нөхцөл, байдал үүссэн гэж үзэхээр заасан.⁴

Иймд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн зарим хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаанууд (өмнө тодорхойлсон)-тай харилцан уялдаа, хамааралтайгаар хийх ажиллагаа бөгөөд эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ. Тухайлбал, тухайн хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоох шаардлагатай. Мөн үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” , Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338&showType=1> , Сүүлд үзсэн огноо: 2024.04.15.

байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзнэ. Ингэснээр хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Энэхүү судалгаагаар, Монгол Улсын Их Хурлын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр анхаарах асуудлыг зааж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасныг үндэслэн ХЗДХЯ-наас ирүүлсэн судалгааны захиалгын дагуу дараах хуулиудын холбогдох зүйл, заалтыг сонгон судалж, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр тогтов. Үүнд:

1. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг;
2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг;
3. Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг;
4. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг;
5. Өмгөөллийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт, 14.1 дүгээр зүйлийн 14.1.15 дахь заалт;
6. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт;
7. Монгол Улсын иргэд гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйл;
8. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27 дахь заалт;
9. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.8 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалт;
10. Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт;
11. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсэг;
12. Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь заалт;
13. Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4, 13.13 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.12 дахь хэсэг;
14. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг;
15. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг;
16. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт;
17. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 1 дүгээр зүйл;
18. Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.4-т хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан. Уг аргачлалын дагуу хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт нь харьцангуй хийсвэр мэт боловч хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй. Иймд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэхэд уг шалгуур үзүүлэлтийг тохиромжтой гэж үзлээ.

II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор судалж буй хуулиудын холбогдох зохицуулалтын практик хэрэгжилт, түүний эерэг, сөрөг үр дагавар болон хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохын тулд “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Сонгон судалж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгох учиртай. Иймд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.5.3-т заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрээс “байх ёстой ба одоо байгаа” болон “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг сонгох нь энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэв.

“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор сонгосон хууль тогтоомжийг хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн онол, зарчим, хэм хэмжээ болон холбогдох бусад хууль тогтоомжид заасантай харьцуулах хэлбэрээр тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор сонгосон хуулийн зүйл, хэсэг, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Дээр дурдсан харьцуулах хэлбэрүүдийг сонгож судлах нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзлээ.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” хүрээнд, сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг. Үүний дагуу тус үнэлгээнд хамаарч буй эрх зүйн зохицуулалтыг “Зорилгод хүрсэн эсэх”, “Практикт хэрхэн хэрэгжиж байна вэ, хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх” гэсэн томьёоллын хүрээнд судалж дүгнэе.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
------------------	----------------------------	-------------------

	Зорилгод хүрсэн түвшин	Практикт нийцэж байгаа байдал	
1.Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль	Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянах зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр, хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
2.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт болон 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
3.Цагдаагийн албаны тухай хууль	Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтын зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн

		хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
4.Харилцаа холбооны тухай хууль	Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Тухайн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
5.Өмгөөллийн тухай хууль	Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Өмгөөллийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 14.1.15 дахь заалт нь өмгөөлөгчдийн Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хөндөж буй эсэх, тус зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
6.Төрийн болон албаны нууцийн тухай хууль	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 -д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Тухайн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ

			“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
7.Монгол Улсын иргэнд гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хууль	Монгол Улсын иргэнд гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Тухайн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
8.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27 -д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Тухайн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
9.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, хуульд заасан харьяаллын дагуу явуулах зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
10.Зөрчлийн тухай хууль	Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.7.4 -д	Шүүх баривчлах шийтгэлийг жирэмсэн	“Байх ёстой ба одоо байгаа”

	заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй гэх зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	харьцуулалтын хэлбэрийг ашиглан тухайн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
11.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн	Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсгийн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх хэсгийн зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
12.Дайчилгааны тухай хууль	Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8-д заасан зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8-д заасан зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
13. Эрүүгийн хууль	Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 21 дүгээр зүйлийн 21.12 -д заасан зохицуулалт	Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 13 дугаар зүйлийн 13.13 –д заасан зохицуулалт практикт нийцэж байгаа	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Эрүүгийн хуулийн 7 дугаар

	хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	зүйлийн 7.4, 13 дугаар зүйлийн 13.13 –д заасан зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
14.Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль	Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 -д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно гэх зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
15.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 -д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Тус зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.

16.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 -д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	“Байх ёстой ба одоо байгаа” харьцуулалтын хэлбэрээр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
17.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.
18. Агаарын тухай хууль	Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 15 дугаар 15.7 -д заасан зохицуулалт хуулийн зорилтыг хангаж буй эсэхийг тогтооно.	Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 15 дугаар 15.7 -д заасан зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх, хэрэгжүүлснээр сөрөг үр дагавар гарч байгаа эсэхийг судалж, салбарын судлаач, мэргэжилтнүүд хэрхэн үзэж байгааг судалж тодруулна.	Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 15 дугаар 15.7 -д заасан зохицуулалт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг судлах, ингэхдээ “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг мөн ашиглана.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Мэдээлэл цуглуулах аргын хувьд тус үнэлгээнд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгов. Ингэхдээ үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсэг, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр бичсэн ном, судалгааны тайлан, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, статистикийн тоо баримт, мэдээллийн хэрэгслийн эх сурвалжаас түүвэрлэж судлах зорилт тавьсан. Мөн баримт бичиг судлахаас гадна цахимаар хайлт хийж эх сурвалж цуглуулах, холбогдох байгууллагаас мэдээлэл, лавлагаа, судалгаа гаргуулах зэрэг аргыг ашиглах нь тохиромжтой гэж үзсэн.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ эх сурвалж судлах, холбогдох субъектээс мэдээлэл, лавлагаа авах аргаар мэдээлэл цуглуулж, үнэлгээ хийхэд ашигласан. Үүнд, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжоос гадна сурах бичиг, эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, гарын авлага, судалгааны тайлан, эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэл зэрэг эх сурвалж багтана.

Тус судалгаанд ашигласан эх сурвалжийн жагсаалтыг Тайлангийн тавдугаар бүлгээс үзнэ үү.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор дараах хууль тогтоомжийн холбогдох зохицуулалтын хэрэгжилтийг “Зорилгод хүрсэн түвшин”, “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу боловсруулсан томъёоллын дагуу үнэлэв.

3.1.Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур
1	21 дүгээр зүйл.Захидал, харилцаа	Зорилгод хүрсэн түвшин

3.1.1. Зорилгод хүрсэн түвшин

21 дүгээр зүйл.Захидал, харилцаа
21.2.Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянаана. Гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад болохуйц утгатай нууц үг хэллэг, шифртэй, төрийн болон хуулиар хамгаалагдсан бусад нууцтай холбоотой захидал, цахилгааныг хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд шилжүүлнэ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13-т “Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж тусгажээ.

Энэхүү эрхийн цогцолборыг дараах байдлаар ангилан харуулж болно:⁵ (1) Эрх чөлөөтэй байх эрх; (2) Бие махбодын халдашгүй эрх; (3) Орон байрны халдашгүй эрх; (4) Нууцын халдашгүй байх эрх; (5) Нэр төрийн халдашгүй байх эрх (6) Өмчийн халдашгүй байх эрх (7) Захидал харилцааны халдашгүй байх эрх хэмээн үзсэн. Үүнээс гадна олон улсын түвшинд хүний эрхийн ойлголтуудаас тодорхойлоход хамгийн бэрхшээлтэй ойлголт нь халдашгүй, чөлөөтэй байх эрх гэж үзэж⁶ (1) Мэдээллийн халдашгүй байх эрх; (2) Бие махбодын халдашгүй байх эрх; (3) Харилцаа холбооны халдашгүй байх эрх; (4) Орон зайн халдашгүй байх эрх хэмээн ангилсан.

Академич С.Нарангэрэл хувийн нууцын эрхийг дараах төрөлтэй байна гэж үзсэн:⁷ (1) Гэр бүлийн нууц: бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээлэл; (2) Захидал харилцааны нууц: Захидал, цахилгаан, илгээмж, өргөдөл зэрэг шуудан холбооны хэрэгслээр бусад хүн байгууллагатай солилцож буй мэдээ, баримт бичиг, биет зүйл; (3) Эд хөрөнгийн нууц:

⁵ Х.Эрдэнэбат, Хувь хүний халдашгүй эрх, (УБ:Адмон принт 2002 он), 27 дахь тал.

⁶ Simon Davies “Big brother: Britains web of surveillance and the new technological order”, Pan, (London:1996), 23.

⁷ С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг, (анхны хэвлэл), (УБ:Адмон принт 2007 он), 538 дахь тал.

Зөвхөн эд хөрөнгө, оюуны өмч, эрхийн эзэмшигч, эсхүл түүний итгэмжлэгдсэн хүмүүс мэдэх, түүнчлэн эрх бүхий байгууллага албан тушаалтны албан үүргийнхээ дагуу олж мэдсэн мэдээ, баримт бичиг, тоо гэрээ, хэлцэл, биет зүйл; (4) Эрүүл мэндийн нууц: тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог, зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээлэл; (5) Хуулиар тогтоосон бусад нууц: үүнд хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон нууц хамаарна.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 1.1-д “Тус хуулийн зорилт нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэжээ. Гэвч тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянана...” гэж хуульчилсан нь хүний захидал, харилцааны нууцад шууд халдсан буюу хүний хувийн нууцад шалтгаангүй халдах нөхцлийг бүрдүүлсэн байна. Иймд сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “... заавал хянана” гэж хатуу заасныг өөрчлөн, шаардлагатай тохиолдолд хянаж болох агуулгаар тусгах нь зүйтэй.

3.2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур
1	55 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Зорилгод хүрсэн түвшин
2	11.1 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт	Практикт нийцэж байгаа байдал

3.2.1. Зорилгод хүрсэн түвшин

55 дугаар зүйл.Хуульчийн сургалт зохион байгуулах хугацаа
55.1.Хуульчийн үргэлжилсэн болон ёс зүйн сургалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь хуульчийн эрх зүйн байдал, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоо, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршино.” гэж заасан.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн хүрээг “Хуульчийн сургалт зохион байгуулах хугацаа” хэмээн хумьж, 55.1-д зөвхөн сургалтын хугацааг заасан нь хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах ерөнхий чиглэлийг тусгаагүй, сургалтын агуулгыг тодорхойлоогүй байдлыг үүсгэсэн байна. Харин Монголын Хуульчдын Холбооны зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тогтоох журмын 1.1 дэх зүйлийн 2 дахь хэсэгт “Үргэлжилсэн сургалтын зорилго нь хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх мэдлийн байгууллагын

хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бус ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.” гэж заасан байна.⁸

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 55 дугаар зүйлийг зөвхөн сургалтын хугацаа гэж хязгаарлалгүй, “Хуульчийн сургалт” эсхүл “Хуульчийн сургалт зохион байгуулах” хэмээн ерөнхий байдлаар томъёолж, Хуульчдын Холбооны зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журамд заасан сургалтын төрөл, зорилго, сургалтын ерөнхий агуулгыг хуульчлах, үүний үндсэн дээр тухайн сургалтыг зохион байгуулах давтамж, тоо хэмжээг тусгах нь зүйтэй.

3.2.2. Практикт нийцэж байгаа байдал

11.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан “Хуульчийн мэргэжлийн дадлага” гэдэгт дараах ажил, албан тушаал хамаарна:

11.1.1.прокурор, нотариатч, өмгөөлөгчийн туслах;

11.1.2.Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах;

11.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хуулийн зөвлөх, хуулийн асуудал хариуцсан ажилтан;

11.1.4.хууль зүйн сургуулийн багш, туслах багш, төрийн болон төрийн бус байгууллагын эрх зүйн судалгааны ажилтан.

ХЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт хуульчийн мэргэжлийн дадлагад хамаарах ажил, албан тушаалыг хуульчилсан нь хуульд заасан тодорхой болзол, шалгуурыг хангасан иргэн хуульчийн шалгалтад орох эрх үүсэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ байна. Үүнд зааснаас үзэхэд, “хуульчийн мэргэжлийн дадлага” гэдэгт хууль зүйн чиглэлийн туслах ажлыг хамруулжээ. Гэхдээ шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахын албан тушаалыг хуульчийн мэргэжлийн дадлагад хамруулаагүй байна.

2021 оноос өмнө **шүүгчийн туслах нь** эрх зүйч байх шалгуурыг тавьдаг байсан бол 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 89 дүгээр зүйлийн 89.1-д “Шүүгч туслахтай байх бөгөөд шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй, **хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.**” гэж заасан. Тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болохоос өмнө шүүхэд ажиллаж байгаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй шүүгчийн туслах Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 89.1-д заасан шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш **хоёр жилийн хугацаанд** хангана.” гэж заасан байна.

Гэвч Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойшхи 2 жилийн хугацаанд Монголын Хуульчдын холбооноос хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалтыг 2 удаа зохион байгуулсан боловч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй 230 шүүгчийн туслахын 89 буюу 39% нь 1-2 удаа,

⁸ Монголын Хуульчдын Холбооны зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тогтоох журмын 1.1 дэх зүйлийн 2 дахь хэсэг.

38 буюу 7% нь 3-4 удаа, 6 буюу 3% нь 5-7 удаа тус тус шалгалтад хамрагдаж байсан бол 94 буюу 41% нь шалгалт өгөөгүй эрх зүйчид байна.⁹

Улмаар Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй шүүгчийн туслахууд Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хугацаа буюу 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан шаардлага хангах боломжгүй болсон тул Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд **“хоёр жилийн хугацаанд хангана”** гэж заасныг **“гурван жил”** болгож хугацааг дахин нэг жилээр хойшлуулах зохицуулалтыг хуульчилжээ. Мөн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй шүүгчийн туслахуудыг ажлаас чөлөөлсөн тохиолдолд шүүхэд шүүгчийн туслахын хүний нөөцийн хомсдол үүсэж, улмаар шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөл алдагдахад хүрнэ.¹⁰

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслахын эрх зүйн байдал ба хуульчийн мэргэжлийн холбоо хамаарлыг гадаад орнууд хэрхэн тодорхойлж байгааг авч үзвэл:

АНУ-д шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгчийн туслах нь хуульчийн шалгалт өгөх шаардлагагүй. Тэд хууль зүйн үр дагавар шууд үүсгэх үйл ажиллагаа явуулахаас илүүтэйгээр шүүхийн тогтолцооны хүрээнд захиргааны шинжтэй болон холбогдох бусад дэмжлэгийг үзүүлэх үүрэгтэй. АНУ-д шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож мэтгэлцэх, үйлчлүүлэгчдэд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд хуульчийн мэргэжлийн шалгалт өгч хуульч болох шаардлага тавигддаг байна.

ХБНГУ-д арай өөр байдалтай буюу "шүүгчийн туслах" (үнэлгээч) цол нь улсын хоёр дахь шалгалтаа (АНУ-д хуульчийн шалгалтанд тэнцсэнтэй дүйцэхүйц) өгсөн хүмүүсийг хэлнэ. Энэ шалгалтыг өгсний дараа "Volljurist" (бүрэн мэргэшсэн хуульч) цолыг эзэмшиж, шүүгч, улсын яллагч, өмгөөлөгчөөр ажиллах боломжтой. Энэхүү шалгалт нь Германд янз бүрийн албан тушаалд, тэр дундаа шүүгчийн албан тушаалд хуульч мэргэжлээр ажиллахад чухал байр суурийг эзэлдэг.

Япон улсын хувьд, хуульч болох этгээд эхлээд хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцэж, дараа нь хуульчийн мэргэжлийн дадлага хийж (Шүүхийн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), улмаар шүүхийн заавал хамрагдах сургалтуудад хамрагдах шаардлагатай (Шүүхийн хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг). Хуульчийн улсын төгсөлтийн шалгалтад тэнцэж, сургалтад хамрагдсан хүмүүс шүүгчийн туслах, улсын яллагч, дадлагажигч өмгөөлөгч болох болзол хангана.¹¹

Монгол Улсын хувьд дээр дурдсанчлан 2021 оноос шүүгчийн туслахын албан тушаалд хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрөл авсан этгээд ажиллах шинэ зохицуулалт орсон ч 2023 оны байдлаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй буюу эрх зүйч шүүгчийн туслахын тоо олон байгаа бөгөөд ажлаас

⁹ Инфографик: Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн танилцуулга, Монгол Улсын Их Хурал, Нийтэлсэн: 2023.03.17, Холбоос: <https://www.parliament.mn/nn/29700/>, Сүүлд үзсэн огноо: 2024.05.06.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Япон улсын Шүүхийн цахим хуудас, Холбоос: https://www.courts.go.jp/english/institute_01/institute/index.html, Сүүлд үзсэн огноо: 2024.05.06.

чөлөөлсөн тохиолдолд шүүхэд шүүгчийн туслахын хүний нөөцийн хомсдол үүсэж, улмаар шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөл алдагдахад хүрэхээр байгаа; хууль зүйн үр дагавар шууд үүсгэх мэргэжлийн үйл ажиллагааг явуулахаас илүүтэйгээр шүүхийн тогтолцооны хүрээнд захиргааны шинжтэй ажил эрхэлж, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гэж үзэн шүүгчийн туслахыг хуульчийн мэргэжлийн хүрээнд оруулдаггүй гадаад орны туршлага зэргийг харгалзан энэхүү албан тушаалд заавал хуульч байх шаардлага тавихгүй байж болох юм. Иймд дээр дурдсан өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан шүүгчийн туслахын албан тушаалд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардахгүй байх, улмаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан “Хуульчийн мэргэжлийн дадлага”-д хамаарах албан тушаалд нь тооцох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан Шүүхийн тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

“Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга”-ыг 2013 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийг тайлбарласан Улсын Дээд Шүүхийн 08 дугаар тогтоолд **“хуульч мэргэжлээрээ ажилласан хугацаа гэдэгт”** эрх зүйч мэргэжлээр хууль зүйн дунд болон дээд боловсрол эзэмшсэн хүн зайлшгүй ажиллавал зохих дараах ажил, албан тушаалд ажилласан хугацааг тооцно гээд, үүнд “Бүх шатны шүүхийн нарийн бичгийн дарга” нарыг хамааруулахаар тайлбарласан байдаг. Мөн 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаартай Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлтэд шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажилласан этгээд Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн **“мэргэжлээрээ ажилласан”** гэдэгт хамаарна хэмээн тайлбарлажээ. Үүнээс үзвэл шүүгч болоход тавигдах шалгуур буюу Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “мэргэжлээрээ ажилласан” гэдэгт шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажилласан хугацааг тооцож байв. Гэтэл ХЭЗБТХ-ийн 11.1 дүгээр зүйлд заасан “хуульчийн мэргэжлийн дадлага”-д шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаал хамаарахгүй байгаа нь хууль эрх зүйн зөрчил, хийдэл болон тодорхойгүй байдлыг үүсгэж байна.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуультай холбоотой маргааныг шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 11 шийдвэр байх ба үүний 1 маргаан нь ХЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгтэй хамааралтай байна. Мөн 2019 онд иргэн Э.Мөнхдаваа нар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг бүхэлдээ Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг хянан хэлэлцжээ. Үүнд “хууль зүйн их, дээд сургууль төгссөн хүн хоёр жил мэргэжлээрээ ажилласан тохиолдолд хуульчийн сонгон шалгаруулалтад орж хуульчийн гэрчилгээ авах, улмаар хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллах боломжийг дээрх хуульд тодорхой тооны этгээдэд олгохоор хуульд заасан нь тэдгээртэй адилтган үзэж болох ажил, албан тушаал эрхэлж буй бусад иргэдийг ялгаварлан гадуурхаж, тэгш бус байдал үүсгэж байна” гэж үзэн Үндсэн Хуулийн Цэцэд мэдээлэл гаргажээ. УИХ-ын гишүүн Н.Учрал УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувиар дээрх хуулийн маргаан бүхий зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага байгааг хүлээн зөвшөөрч хамтран ажиллахаар болсны үндсэн дээр мэдээлэл гаргагч иргэн Цэцэд ирүүлсэн мэдээллийн шаардлагаасаа бүхэлд нь татгалзсан тул маргааныг хэрэгсэхгүй болгосон байна.

ХЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээс гадна Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн хурлын 13 дугаар тогтоолын хавсралтаар “Хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох журам”-ыг баталсан. Уг журмын 3 дугаар зүйлд заасны дагуу “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө дараахь ажил, албан тушаалд хоёроос доошгүй жил ажилласан бол Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийг үндэслэн мэргэжлийн дадлагад тооцно гэсний дотор шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг хамруулахаар заасан байна.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан “Хуульчийн мэргэжлийн дадлага” гэдэгт шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалыг хамруулснаар хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх эрхтэй болох, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, улмаар хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллах боломж нээгдэнэ.

26 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг үүрэг 26.1.2.Хуульчдын холбооны гишүүн байж, гишүүний татвар төлөх;
--

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “хуульч” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг; мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй.”; мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-т “Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах нийтлэг үүрэг хүлээнэ: Хуульчдын холбооны гишүүн байж, гишүүний татвар төлөх;” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийснээр хуульчийн шалгалтанд орж, улмаар уг шалгалтад тэнцвэл МХХ-д хандан өргөдөл гаргасны дагуу тус холбоо хянан шийдвэрлэж гишүүнээр бүртгэснээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч **гишүүний татвар төлөх** үүргийг хүлээнэ.

МХХ-ны санхүүжилт нь гишүүдийн татвар, хандив, хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамж, сургалтын төлбөр, хэвлэн нийтлэлийн ашгаас бүрдэх ба тус хөрөнгөөр хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх, хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтад тэнцэж, өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, эрх авсан хуульч өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлнэ. Хуульч нь өмгөөлөгч болсноор Өмгөөллийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 14.1.15 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ **гишүүнчлэлийн хураамж төлөх** үүргийг хүлээнэ. Үүнээс үзвэл, иргэн тодорхой шаардлагыг хангаж хуульч болсноор Хуульчдын холбоонд гишүүнчлэлийн татвар төлөх, цаашлаад өмгөөлөгч болсноор Өмгөөлөгчдийн холбоонд гишүүнчлэлийн хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ. Ингэснээр өмгөөлөгч нь МХХ-ны гишүүнчлэлийн татвар болон МӨХ-ны гишүүнчлэлийн хураамжийн аль алиныг нь төлөх эрх зүйн орчин бий болсон.

2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль баталж, тус хуулийн 5 дугаар зүйлд “Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, Монголын Хуульчдын холбоо болон Өмгөөлөгчдийн Холбооны үйл ажиллагааг уялдуулах, чиг үүргийг оновчтой хуваарилах, **өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулж**, Монгол Улсын Их Хуралд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор өргөн мэдүүлнэ.” гэж заасан.

Гэвч дээрх журамд заасны дагуу өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийг өдий хүртэл (2024 оны 5 дугаар сар) батлаагүй байна. Өмгөөлөгчид ч энэ талаарх байр сууриа хуульчдын болон өмгөөлөгчдийн бүлгийн цахим хуудсанд нийтэлсэн байна.

Өмгөөлөгчдийн холбоо болон Хуульчдын холбоо нь гишүүдээ хөгжүүлэх, тэдний хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүргээ гүйцэтгэх үйл хэргийг дэмжих, хууль ёсны эрх ашгийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа явуулах зорилгоор гишүүдээс татвар, хураамж авах хэлбэрээр бас санхүүждэг байна. Татвар, хураамжийн хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Хуульч, өмгөөлөгчдийн төлж буй татвар, хураамж (2024 он)

Хуульч, өмгөөлөгчдийн төлж буй татвар, хураамж		
Татвар, хураамж	1 хүний татвар	МУ-ын хэмжээнд байх нийт тоо
Хуульчдын холбоонд төлөх татвар	20,000₮	2251
Өмгөөлөгчдийн холбоонд төлөх хураамж	30,000₮	1196
Өмгөөлөгчийн төлж буй нийт татвар, хураамж	50,000₮	

Ийнхүү Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөлөгч бүр хуульч байх шаардлагын улмаас өмгөөлөгч нь хоёр холбоонд давхар харьяалагдан гишүүнчлэлийн татвар, хураамж төлснөөр татварын “шударга байх, зайлшгүй байх” зарчим алдагдаж, Монгол Улсын нийт 1196 өмгөөлөгч хуульчийн эрх ашиг зөрчигдөж байна.

Иймд 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасныг хэрэгжүүлж, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байх зохицуулалтыг холбогдох хуульд тусгах шаардлагатай. Үүний хүрээнд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд Монголын Хуульчдын холбооны гишүүний татвар, Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүнчлэлийн хураамжийг давхардуулж авахгүй байх тухай зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

3.3.Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
---	---------------------------------	-------------------------------

1.	17 дугаар зүйл. Цагдаагийн албаны сургалтын байгууллага	Практикт нийцэж байгаа байдал
2.	17 дугаар зүйл. Цагдаагийн албаны сургалтын байгууллага	Зорилгод хүрсэн түвшин

3.3.1. Зорилгод хүрсэн түвшин

17 дугаар зүйл. Цагдаагийн албаны сургалтын байгууллага
 17.1."Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно".

2017 оны Цагдаагийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн зорилт нь “Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтооход оршино”¹². Цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалд цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, чадавхжуулах, ур чадвар эзэмшүүлэх асуудал онцгой чухал байр суурь эзэлдэг. Учир нь Цагдаагийн албан тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлт нь албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн болон ёс зүйн шаардлага, цагдаагийн албанд болон мэргэжлийн чиглэлээр ажилласан жил зэргээс бүрддэг.

Өөрөөр хэлбэл, цагдаагийн тушаалд тавигдах тусгайлсан шаардлага, шалгуур үзүүлэлтэд цагдаагийн ур чадвар багтдаг бөгөөд цагдааг албан тушаалд томилохдоо мөн л ур чадварыг харгалзан үздэг. Энэ ч утгаараа Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.4.6-д “Монгол цагдааг хөгжүүлэх, цагдаа иргэдтэйгээ хамтарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэж заасныг үндэслэн Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг баталжээ.¹³

Энэхүү хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах албан тушаалтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийх замаар үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлсон бодлогын баримт бичиг болгохоор зорьсон.

Хөтөлбөр хэрэгжсэнээр цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх сайжирч, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшилж, үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлэн, Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн гудамж, зам, талбайг камержуулах, хүний нүүр царайгаар таних чадвартай төхөөрөмж (facefinder)-ийг ашиглаж, хүн хүчийг хэмнэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, аюулгүйн бүсүүдийг бий болгох, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд бодит ахиц, үр дүн гарна гэж үзсэн.

¹² Цагдаагийн албаны тухай хууль, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

¹³ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор баталсан “Хөтөлбөр батлах тухай”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15324>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.16.

Түүнчлэн тус хөтөлбөрт зааснаар сургалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх буюу мэргэжлийн өндөр ур чадвартай, заах арга зүй эзэмшсэн сургагч багшийг бэлтгэж, ажиллуулахыг зорьжээ. Ингэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд суурилсан хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх ба Мэдлэг, мэргэжлийн ур чадвартай, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган, цахим мэдээллийн системийг хөгжүүлэх байдлаар албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Хууль зүйн үндэсний хүрээлэн 2023 онд “Цагдаагийн албанд тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал” сэдэвт харьцуулсан судалгаа хийсэн. Тус судалгааны дүгнэлтээс дурдвал:

- Монгол Улсад цагдаагийн алба хаагчийг сургах боловсрол, сургалтын тогтолцоог онцгой анхаарч Засгийн газраас үе шаттайгаар, тасралтгүй хөгжүүлэхээр бодлогын баримт бичгүүдэд тусгаж ирсэн ч хэрэгжилт хангалтгүй, сургалтын нэгдсэн тогтолцоог оновчтой тодорхойлоогүй байна.
- Холбогдох журмууд хоорондоо зөрчилтэйн улмаас тэдгээрийг дагалдуулж баталсан сургалтын хөтөлбөрүүд оновчгүй бөгөөд Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох журмаар тодорхойлоогүй сургалтын төрлүүдийг нэмж тусгасан, ЦАТХ-д заасан сургалтын төрлийг дагаж мөрдөөгүй зэргийг анхаарах шаардлагатай. Мөн холбогдох журмуудад чадавхжуулах, ур чадварын, мэдлэг, ур чадварын, мэргэшүүлэх, давтан, үргэлжилсэн, ажлын байрны, ажлын байран дахь албаны, ажлын байран дээрх албаны, албаны сургалт зэрэг хоорондоо авцалдаагүй, олон төрлийн сургалтыг тусгасан нь сургалтууд харилцан уялдаагүй байх, давхцах, хийдэл гарах зэрэг асуудлыг үүсгэжээ. Харин энэхүү судалгаанд хамрагдсан гадаад орнуудад цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо харьцангуй тогтсон хандлагатай, бүтэц, нэр томьёо, хөтөлбөр, агуулга тодорхой байгаа бөгөөд мэргэшүүлэх, дадлагажуулах, үргэлжилсэн зэрэг сургалтын тодорхой төрлийг тогтмол хэрэгжүүлж байна. Сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх журам болох 118 дугаар журамд нэлээд их алдаа, дутагдал илэрсэн. Тухайлбал, хүчингүй болсон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийг эш татан зохицуулсан байна. Мөн “Цагдаа-мэргэжлийн дээд боловсролын сургалт” гэсэн хуульд заагаагүй нэр томьёо хэрэглэснээс гадна “Цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт”-гэсэн ойлголтоос ялгахад хүндрэл үүсгэж байна. Эдгээр журам, хөтөлбөрт заасан сургалтууд болон хөтөлбөр, төлөвлөгөөний нэршлийг мөн Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэх эсхүл зохистой байдлаар шинэчлэн тусгахад анхаарах шаардлагатай юм.
- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам болох 118, 239 дүгээр журам зэргийг хангалттай шинэчилж, боловсронгуй болгоогүй байна. Тухайлбал, Сургалтын бодлого, боловсруулж хэрэгжүүлэх 118 дугаар журмыг 2022 онд шинэчлэн баталсан боловч Цагдаагийн ерөнхий газрын нэгжийн өөрчлөлттэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг өнөө хүртэл оруулаагүй байв. Үүний улмаас ЦЕГ-ын аль хэлтэс, нэгж ямар чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгаа нь тодорхой бус болсон зэрэг болно.¹⁴

¹⁴ ХЗҮХ, Цагдаагийн албанд тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал, харьцуулсан судалгаа, УБ, 2023, 37-38 дахь тал.

Энэхүү дүгнэлтэд үндэслэж мэргэшүүлэх сургалтыг холбогдох журмууд болон хөтөлбөртөө тусгайлан тусгасан байгаа хэдий ч гадаад орнуудын жишгийг харгалзан дотоодын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн үндсэн сургалтын төрөл болгож хуульчлах; Монгол Улсын цагдаагийн мэргэжлийн боловсролын сургалт олгох хугацаа, багц цагийг нэмэгдүүлэх; Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэс, Цагдаа, дотоодын цэргийн судалгааны нэгдсэн төв болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсийн үйл ажиллагааг уялдуулж бүтцийн хувьд нэгтгэх арга хэмжээ авах, ДХИС-ийн сургалтын чиг үүрэгтэй уялдуулж зохион байгуулалт хийх; Сургалтын агуулгад цагдаагийн алба хаагчийн бие даасан байдал болон монгол хэлний найруулга зүй, бичгийн ур чадварыг дээшлүүлэх хэл зүйн сургалтуудыг багтаах зэрэг зөвлөмж дэвшүүлжээ.¹⁵

Иймд холбогдох судалгааны дүгнэлт, саналд үндэслэн цагдаагийн албаны сургалтын тогтолцоог шинэчилж хуульчлах, тухайлбал цагдаагийн алба хаагч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах “ур чадварын сургалт”-ын төрлийг Цагдаагийн албаны тухай хуульд нэмж тусгах нь зүйтэй. Улмаар цагдаагийн албаны сургалттай холбоотой журам, хөтөлбөр, түүнд заасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын нэр, агуулга, хэлбэрийг Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг мөн анхаарах шаардлагатай.

3.3.2. Практикт нийцэж байгаа байдал

17 дугаар зүйл. Цагдаагийн албаны сургалтын байгууллага
17.1.”Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно”.

Цагдаа, дотоод хэргийн сургалтын нэгдсэн төвийн цахим хуудсанд¹⁶ албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг оруулжээ. Тодруулбал, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах тухай” Дугаар А/07 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”, хоёрдугаар хавсралтаар “албаны сургалт үлгэрчилсэн төлөвлөгөө”-г, гуравдугаар хавсралтаар “албаны сургалт зохион байгуулах төлөвлөгөө”-г, дөрөвдүгээр хавсралтаар “давтан мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө”-г тус тус баталжээ.¹⁷

Уг тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны албаны сургалт зохион байгуулах төлөвлөгөөнөөс үзвэл 6 чиглэлээр сургалт зохион байгуулахаар заажээ. Үүнд:

1. Цагдаа, иргэний харилцааны менежментийг сайжруулах нь;

¹⁵ Мөн тэнд 38 дахь тал

¹⁶Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн цахим хуудас, Холбоос: <https://surgalt.police.gov.mn/>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.16.

¹⁷Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн цахим хуудас, Холбоос: <https://surgalt.police.gov.mn/>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.16.

2. Дуудлага мэдээлэлд очих үед болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцах үед гарч буй алдаа дутагдлыг арилгах, алба хаагчдыг зааварчлах, дэмжин туслах чиглэлээр алба хаагчдад мэдлэг олгох, ур чадвар дээшлүүлэх, сургалтыг зохион байгуулах;
3. Алба хаагчийн ёс зүй, биеэ авч явах байдал, иргэнтэй харилцах ур чадвар олгох сургалт зохион байгуулах;
4. Цахим орчинд виртуал хөрөнгө ашиглах, үйлдэгдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарах асуудал, сэдэвт бүсчилсэн сургалт зохион байгуулах;
5. Алба хаагчдын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах бие бялдарын бэлтгэлжилтийг шалгах шалгуур үзүүлэлтийг хангах дасгал сургуулилт болон сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах шаталсан сургалтыг 10-аас доошгүй цаг төлөвлөсөн байх;
6. Алба хаагчдын харилцааны соёл, хандлагыг дээшлүүлэх хүний эрхийн мэдрэмжийг сайжруулах иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээллийн агуулга хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах сургалтыг 10-аас доошгүй цаг төлөвлөсөн байх зэрэг болно.

Үүнээс үзвэл, Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно" гэж заасан зохицуулалт практикт нийцэж байна. Харин тус хуульд заасан цагдаагийн алба хаагч, ажилтанд зориулсан сургалтын төрлийг шинэчлэн тогтоох, улмаар бусад холбогдох зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай.

3.4.Харилцаа холбооны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1	8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг	Зорилгод хүрсэн түвшин

3.4.1. Зорилгод хүрсэн түвшин

8 дугаар зүйл.Харилцаа холбооны зохицуулах хороо
8.3. Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно.

МУ-ын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Алсын хараа 2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын 5.2-т "Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна." гэж, мөн зорилтын II үе шат (2031-2040): "Иргэдийн эрх ашгийг дээдэлсэн, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжсэн цомхон бөгөөд үр ашигтай, үр нөлөөтэй бүтэц, зохион байгуулалтыг төрийн байгууллагуудын бүх түвшинд нэвтрүүлэх үе. 1.Төрийн захиргааны байгууллагын бүтэц цомхон, уян хатан, үр дүнтэй болж, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал арилсан байна." гэж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 4.2.30-

д “Мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, зөөлөн болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.” гэж, 5.3.4-т “Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөж, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн МУ-ын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4-т “Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ” гэж, 4.1.5-д “Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ.” гэж тусган, МУ-ын Засгийн газраас харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх зорилго бүхий “Цахим Үндэстэн 2022-2027” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг баталжээ.

Дэлхий нийтээрээ цахим шилжилтэд шилжиж буй энэ үед МУ-ын цахим хөгжил, харилцаа холбооны салбарын гол хууль болох Харилцаа холбооны тухай хуулийг /цаашид “ХХтХ” гэх/ МУ-ын Их Хурлаас 2001 оны 10 дугаар сарын 16-ны өдөр шинэчлэн баталсан бөгөөд тус хууль өдгөө 22 дахь жилдээ хүчин төгөлдөр үйлчилж, нийт 20 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

ХХтХ-ийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүнийг ашиглах, хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан.

Дээрх хуулийн зорилтод заасан зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих зорилтын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороо үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд, тус хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно гэсэн ХХтХ-ийн 8 дугаар зүйлийг 8.3 дахь хэсгийн зохицуулалт нь хуулийн зорилгод нийцсэн эсэхийг судалж үзье.

Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнээр анх 1997 онд элссэн бөгөөд худалдаатай холбоотой дотоодын 30 гаруй хууль тогтоомжийг тус байгууллагын зарчим, дүрэм, журамд нийцүүлэн шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь чөлөөт зах зээлийг хөгжүүлэх зорилгоор төрөөс хараат бус бие даасан зохицуулах байгууллагыг бий болгох явдал бөгөөд энэ нь одоогийн Харилцаа холбооны зохицуулах хороо үүсгэн байгуулагдах үндэс суурь болсон.

Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид “ХХЗГ” гэх/ нь хуульд заасан үндсэн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу шинэ дэвшилтэт техник, технологийг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт нэвтрүүлэх, иргэдэд төрийн болон мэдээлэл харилцаа холбооны төрөл бүрийн хэрэглээ, үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэх, тэдгээрийн хүртээмжийг сайжруулах, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажлыг хариуцан ажилладаг байгууллага юм. Гэтэл уг байгууллагын дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилно гэх ХХтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт нь хэт ерөнхий, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт байх боломжтой тул дараах хэдэн асуултын хүрээнд тодруулан авч үзэв.

- Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлсон эсэх?

ХХЗГ нь төрөөс хараат бус, бие даасан байгууллага бөгөөд олон улсын харилцаа холбооны салбарын чиг хандлагаар зохицуулах байгууллага нь бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулж чадаж байгаа эсэхээр тухайн орны зах зээлийг либералчлагдсан гэж үздэг буюу бие даасан, хараат бус байдал нь тухайн орны зах зээлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлт болсон байна.

МУ-ын Үндсэн хууль болон төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх зүйн үндсийг тодорхойлсон холбогдох хуулиудад, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдээр салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, захиргааны байгууллага, орон нутгийн байгууллага зэрэг этгээдүүдийг тодорхойлсон бөгөөд зохицуулах байгууллага, зохицуулах хороо гэсэн субъект тусгагдаагүй. Үүнээс үүдэн ХХЗГ-ыг төрийн байгууллага гэж үзэх боломжгүй, тус байгууллагын ажилчид нь төрийн хаагчид тооцогдохгүй гэх боловч төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг этгээд юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх зүйн байдлыг ХХТХ-ийн 8 дугаар зүйлд хуульчилж, 9 дүгээр зүйлд бүрэн эрхийг тогтоосон. Энэ нь ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд”-ийг захиргааны байгууллага гэж ойлгохоор хуульчилсны дагуу ХХЗГ-г захиргааны чиг үүргийг хуульд заасныг үндэслэн шилжүүлж авсан этгээд, захиргааны байгууллага гэж үзнэ. Иймд ХХЗХ нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны байгууллагын эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

- ХХТХ-ийн 8.3-т Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилохоор заасан нь МУ-ын Засгийн газрын тухай хуульд заасан Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах эсэх?

МУ-ын Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын бүрэн эрх Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно”, Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.” гэж заасан байдаг. Иймд Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээ нь МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрхлэх асуудлаар хязгаарлагдахгүй, хуулиар ЗГ-т олгогдсон бүх бүрэн эрх, чиг үүрэг нь Ерөнхий сайдтай шууд хамааралтай. Мөн МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажил эрхэлнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх үндсэн хүрээний ажлыг энэ хуулиар, тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна.”, мөн тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д “хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж МУ-ын Ерөнхий сайдын бүрэн эрхийг хуульчилсан ба уг зохицуулалтын дагуу ХХТХ-ийг ‘бусад хууль’ буюу ‘хууль тогтоомж’ гэж үзнэ. Иймд ХХТХ-ийн 8.3 дахь хэсэг нь МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4,19 дэх хэсгүүдтэй зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

- ХХТХ-ийн 8.3-т Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилохоор заасан нь эрх зүйн хийдэл бүхий зохицуулалт мөн эсэх?

Эрх зүйн хийдэл гэдэг нь хууль түүний хэм хэмжээнүүдээр шууд зохицуулагдах харилцаа нь хуульчлагдаж чадаагүйгээс эрх зүйн үйлчлэл дутагдаж, үр дагавар бий болгосон хууль зүйн онцгой нөхцөл байдал юм.¹⁸

Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох талаар заасан байх хэдий ч тэдгээрийг хэрхэн сонгох тухай процедурын асуудлыг орхигдуулсан байна. Өөрөөр хэлбэл уг зохицуулалт нь хэт ерөнхий, тодорхойгүй буюу шаардагдах харилцааг хуульчлан томьёолохдоо шийдвэрлэх асуудлыг бүрэн тодорхойлж чадаагүйн улмаас эрх зүйн хийдэл үүсгэж, практикт хэрэгжихэд төвөгтэй байдлыг бий болгожээ. Иймээс уг зохицуулалтыг илүү нарийвчлан дэлгэрүүлж, холбогдох албан тушаалтан, төлөөллөөс санал болгож буй нэр дэвшигчдээс сонгох байдлаар өөрчлөн найруулах шаардлагатай гэж үзэж байна.

3.5. Өмгөөлийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1	8.6 дугаар зүйлийн 8.6.3 дахь хэсэг	Зорилгод хүрсэн түвшин
2	14.1 дүгээр зүйлийн 14.1.15 дахь хэсэг	Практикт нийцэж байгаа байдал

3.5.1. Зорилгод хүрсэн түвшин

8.6. Хуульчийг дараах тохиолдолд өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзана: 8.6.3. энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;

Улсын Их Хурлаас 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр иргэдийн хууль зүйн туслалцаа авах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах, өмгөөлөгч, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоож, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Өмгөөллийн тухай хуулийг баталсан.

Тус хуулийн 8 дугаар зүйлд өмгөөлөгчийн шалгалтын талаарх зохицуулалтыг хуульчилж, мөн зүйлийн 8.6 дахь хэсэгт хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах үндэслэлийг тусгасан байна. Уг хэсгийн 8.6.3 дахь заалтад “энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;” буюу хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа, эсхүл улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахгүй байхаар хуульчилжээ.

Дээрх асуудлаар иргэн Э.Т Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж, үндэслэлдээ “тус зохицуулалт нь орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж буй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй иргэн өмгөөлөгчийн шалгалтад оролцохын тулд эрхэлж буй ажлаасаа чөлөөлөгдөх шаардлага үүсэхээр байна. Улмаар чөлөөлөгдөөд шалгалтад оролцоод тэнцвэл өмгөөлөгчийн эрх олж авна, шалгалтад

¹⁸ Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (УБ, 2023), 191 дэх тал.

тэнцээгүй тохиолдолд ажилгүй үлдэх нөхцөл байдал үүсэж байна. Мөн хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлаж, улмаар ажлаа чөлөөтэй сонгох эрхийг нь хязгаарласан гэж үзэж байна. Түүнчлэн өмгөөлөгч болох хүсэлтэй бөгөөд хуульд заасан шаардлагыг хангасан бүх хуульч өмгөөлөгчийн шалгалтад оролцох эрх нээлттэй бөгөөд гагцхүү өмгөөлөгчийн эрх авах үедээ хуулиар зөвшөөрөөгүй бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхгүй байх агуулгаар хуулийг батлах ёстой байсан. Шалгалтад тэнцсэн хуульч өмгөөлөгчийн эрх авч өмгөөллөөр ажиллах эсхүл эрхэлж буй ажлаа үргэлжлүүлэн ажиллах эсэхээ өөрөө сонгох эрхтэй байх ёстой. Хэрэв өмгөөллийн эрхээ авах бол өмнөх ажлаасаа чөлөөлөгдсөн байх талаар Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгүүдэд тус тус хуульчилжээ.” хэмээн үзжээ.

Иргэн Э.Т-ээс гаргасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж, 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Өмгөөллийн тухай хуулийн дээрх заалт нь тухайн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан тавьсан нийтлэг хязгаарлалт байх бөгөөд эрх зүйн байдлын хувьд адил тэгш этгээдүүдэд зүй бус ялгаварлал, алагчилсан байдал үүсгэсэн гэж үзэх үндэслэлгүй байна.” гэж дүгнэсэн.

Харин Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа иргэн Э.Т-ийн дээрх мэдээллийг үндэслэлтэй хэмээн үзэж, “Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай тул хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд уг асуудлыг засаж залруулах боломжтой гэж үзэж байна” гэжээ.

Үүнээс үзвэл Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтад "энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;" гэж заасан буюу хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа, эсхүл улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахгүй байх зохицуулалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлал үүсгэснийг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд залруулах боломжтой.

Иймд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болгох шаардлагатай. Ингэснээр хуульчдын өмгөөлөгчийн шалгалтад орох эрхийг хязгаарласан зөрчил арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хангагдана.

3.5.2. Практикт нийцэж байгаа байдал

14.1.Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах үүрэг хүлээнэ: 14.1.15.гишүүнчлэлийн хураамж төлөх;

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “хуульч” гэж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг; мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт “Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага

хийсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох эрхтэй.”; мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2-т “Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах нийтлэг үүрэг хүлээнэ: Хуульчдын холбооны гишүүн байж, гишүүний татвар төлөх;” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуулийг төгсөж, хоёроос доошгүй жил мэргэжлийн дадлага хийснээр хуульчийн шалгалтанд орж, улмаар уг шалгалтад тэнцвэл МХХ-д хандан өргөдөл гаргасны дагуу тус холбоо хянан шийдвэрлэж гишүүнээр бүртгэснээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч **гишүүний татвар төлөх** үүргийг хүлээнэ.

Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасны дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтад тэнцэж, өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, эрх авсан хуульч өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлнэ. Хуульч нь өмгөөлөгч болсноор Өмгөөллийн тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 14.1.15 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ **гишүүнчлэлийн хураамж төлөх** үүргийг хүлээнэ.

Үүнээс үзвэл, иргэн тодорхой шаардлагыг хангаж хуульч болсноор Хуульчдын холбоонд гишүүнчлэлийн татвар төлөх, цаашлаад өмгөөлөгч болсноор Өмгөөлөгчдийн холбоонд гишүүнчлэлийн хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ. Ингэснээр өмгөөлөгч нь МХХ-ны гишүүнчлэлийн татвар болон МӨХ-ны гишүүнчлэлийн хураамжийн аль алиныг нь төлөх нөхцөл бий болсон зохицуулалттай байна.

2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль баталж, тус хуулийн 5 дугаар зүйлд “Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, Монголын Хуульчдын холбоо болон Өмгөөлөгчдийн Холбооны үйл ажиллагааг уялдуулах, чиг үүргийг оновчтой хуваарилах, **өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулж**, Монгол Улсын Их Хуралд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор өргөн мэдүүлнэ.” гэж заасан. Гэвч дээрх журамд заасны дагуу өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийг өдий хүртэл (2024 оны 3 сар) батлаагүй байна. Өмгөөлөгчид ч энэ талаарх байр сууриа хуульчдын болон өмгөөлөгчдийн бүлгийн цахим хуудсанд нийтэлсэн байна.

Өмгөөлөгчдийн холбоо болон Хуульчдын холбоо нь гишүүдээ хөгжүүлэх, тэдний хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүргээ гүйцэтгэх үйл хэргийг дэмжих, хууль ёсны эрх ашгийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа явуулах зорилгоор гишүүдээс татвар, хураамж авах хэлбэрээр бас санхүүждэг байна. Татвар, хураамжийн хэмжээг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Хуульч, өмгөөлөгчдийн төлж буй татвар, хураамж (2024 он)

Хуульч, өмгөөлөгчдийн төлж буй татвар, хураамж		
Татвар, хураамж	1 хүний татвар	МУ-ын хэмжээнд байх нийт тоо
Хуульчдын холбоонд төлөх татвар	20,000₮	2251
Өмгөөлөгчдийн холбоонд төлөх хураамж	30,000₮	1196

Өмгөөлөгчийн төлж буй нийт татвар, хураамж	50,000₮
--	---------

Ийнхүү Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөлөгч бүр хуульч байх шаардлагын улмаас өмгөөлөгч нь хоёр холбоонд давхар харьяалагдан гишүүнчлэлийн татвар, хураамж төлснөөр татварын “шударга байх, зайлшгүй байх” зарчим алдагдаж, Монгол Улсын нийт 1196 өмгөөлөгч хуульчийн эрх ашиг зөрчигдөж байна.

Үүнийг шийдвэрлэхээр 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхтай холбоотой зохицуулалтыг Өмгөөллийн тухай хуульд, түүнчлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгах шаардлагатай.

3.6.Төрийн болон албаны нууцын тухай зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1	5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт	Зорилгод хүрсэн түвшин

3.6.1. Зорилгод хүрсэн түвшин

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
 5.1.2. “албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.4.3-т “Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан бүрдүүлж, Улсын Их Хурал, орон нутгийн иргэдийн төлөөллийн байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан иргэдийг үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудаар өргөн хүрээтэй мэдээллээр хангах механизмыг бий болгоно. Төрийн мэдээллийн нээлттэй нөөцийг бүрдүүлэх ажиллагааг эрчимжүүлж, тэдгээрийг цахим засгийн үйлчилгээнд үр нөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ” гэж, 3.6.4.4-т “Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана” гэж, 3.6.4.5-т “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх”-ээр тусгасан байна. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.8 дахь хэсэгт “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана” гэж, 4.1.6 дахь хэсэгт “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан,

хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тусгажээ.

Дээрх Үндсэн хуульд заасан нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангаж, төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах үүднээс 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг баталж, анх удаа төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндэс тавигдсан байна.

Төрийн нууцын тухай хуульд 2001, 2003, 2004 (2 удаа), 2014, 2015, 2017 онд нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бол, 1995 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг 2004 онд шинэчлэн найруулж, нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр хуулиуд нь Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдах хүртэл хэрэгжжээ.

Төрийн болон албаны нууцын тухай хууль /цаашид “ТБАНТХ” гэх/ нь 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 2020, 2021 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан. Уг зорилтод заасан ‘албаны нууц’ гэх нэр томъёог тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т тодорхойлсон бөгөөд энэ ойлголт нь хуулийн зорилгодоо нийцэж буй эсэхийг судалж үзье.

Мэдээллийг нууцад хамааруулахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчим анх 1995 оны Төрийн албаны нууцын тухай хуульд тусгагдаж, улмаар 2017 оны Төрийн болон албаны нууцын тухай хуульд уламжлагдан үлдсэн билээ.

“Албаны нууц” гэсэн нэр томъёоны тодорхойлолт:

1995 оны Төрийн нууцын тухай хуульд “албаны нууц” хэмээх ойлголт тусгагдаагүй бөгөөд 2016 оны ТБАНТХ-иар уг ойлголт анх бий болжээ. ТБАНТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д зааснаар “албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээлэл юм. Гэтэл “байгууллагын ашиг сонирхол” болон “салбарын ашиг сонирхол” гэх тодорхойгүй нэр томъёоноос үүдэн төрийн байгууллагын удирдлагууд өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг албаны нууцад хамааруулах явдал нийтлэг гарч, иргэний мэдэх эрхийг зөрчих явдал газар авсаар байна. Энэ нь “албаны нууц” гэх ойлголтын шалгуурыг хуульчилж өгөөгүйн улмаас төрийн байгууллага, агентлагийн дарга нар хэт өргөн хүрээний мэдээллийг албаны нууц гэх ангилалд хамруулж байгаатай холбоотой юм.

Мэдээллийг өргөнөөр хязгаарлаж нууцлах нь засаглалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг талаар судлаачид тэмдэглэсэн. Тодруулбал, мэдээллийг өргөнөөр нууцлах нь олон нийтийн төрд итгэх итгэлд нөлөөлж, мэдээлэлгүй, эсхүл дутуу, буруу мэдээлэл авснаас үүдэн төрийн үйл ажиллагаанд итгэхээ болих сөрөг үр дагаврыг үүсгэдэг. Иймд төрийн байгууллага, албан хаагч өөрийн шийдвэр, үйл ажиллагааны талаарх үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг олон нийттэй тогтмол хуваалцах нь төрд

итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх чухал ач холбогдолтой.¹⁹ Мөн хэт өргөнөөр мэдээллийг хязгаарлаж, нууцлах нь чухал мэдээллийн хамгаалалтыг сулруулахаас гадна төрийн үйл ажиллагааны зардлыг тодорхой хэмжээгээр ихэсгэдэг хэмээн онцолдог.

Сонгодог хандлагаар төрийн нууцыг задруулах асуудлыг, албан мэдээллийг олон нийтэд тараах гэсэн ойлголтоос ялган заагладаг байна. Төрийн байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэдийн мэдэхийг хүссэн мэдээлэл, төрийн байгууллагын зүгээс иргэд, олон нийтэд тайлагнадаг мэдээлэл зэрэг нь албан мэдээллийг тараах, түгээх гэсэн ойлголтод багтана.²⁰ Өөрөөр хэлбэл төрийн нууцын ойлголтод албаны мэдээллийг гаргаж өгөх, тараах асуудлыг хамааруулахгүй байх нь зүйтэй. Үүнээс үзвэл, төрийн нууцын тухай хууль тогтоомжоор албаны нууцтай холбоотой харилцааг зохицуулж буй өнөөгийн практикийг эргэн харах шаардлагатай юм.

Тухайлбал, 2022 оны 12 дугаар сард “нүүрсний хэрэг”-тэй холбоотойгоор үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулж Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай Засгийн газрын тогтоол баталсан. Уг тогтоолоор ҮАБЗ-ийн зөвлөмжийн дагуу нууцад хамааруулсан байсан дараах 9 гэрээг нууцаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн ЭТТ-2019/825, ТТЗ-Н19/01-01, ВІ-ТТGS-CONT-0002 тоот гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт,
2. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан Нүүрс нийлүүлэх ЭТТ-2019/784, ВІ-ТТGS-CONT-0003 тоот гэрээ, түүний нэмэлт, өөрчлөлт,
3. “Монголын төмөр зам” ТӨХК, ЗХЖШ-ын хооронд 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх АГГ-н/ 1901 н/ 387 тоот гэрээ,
4. “Монголын төмөр зам” ТӨХК, УБТЗ ХХН-ийн хооронд 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх АГГ-20/21-20/06 ОГ/20/042 тоот гэрээ,
5. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хооронд 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан Богдхан төмөр замын төслийн суурь, бүтцийн барилгын угсралтын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн МН-ЭТТ2022/497, ТТЗ-МН22/02 тоот гэрээ,
6. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөрзам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Богдхан төмөр зам төслийн туннел болон эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт

¹⁹ David Banisar, Comments on Moldovan Draft Law on State and Official Secrets, 2005, Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/3/7/16548.pdf> , Сүүлд үзсэн огноо: 2024.04.17.

²⁰ Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, (УБ, 2010).

барилгын санхүүжилтийн МН-ЭТТ/487, ТТЗ-МН22/01, ВI-BBR-CONT-0002 тоот гэрээ,

7. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Нүүрс нийлүүлэх МН-ЭТТ-2022/488, ВI-BBR-CONT-0003 тоот гэрээ,
8. “Эрдэнэс Тавантолгой ХК “Набсан” ХХК, “Тэргүүн инвест” ХХК “Эс энд Эй трэйд” ХХК, “Бридж констракшн” ХХК, “ЧММ” ХХК, “Сан” ХХК-ийн хооронд 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний уурхай хүртэлх усны хангамжийн шугам хоолойн барилга угсралтын ажлын ЭТТ-2022/34, ЭТТ-2022/35, ЭТТ-2022/36, ЭТТ-2022/37 тоот гэрээ,
9. “Эрдэнэс Тавантолгой ХК, “Элгэн” ХХК, “Литопр” ХХК, “Инженер геодези” ХХК, “Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа” ХХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан Тавантолгой ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх Н-ЭТТ-2022/946 тоот гэрээ зэрэг багтжээ.

Эдгээр гэрээг нууцалсан үндэслэлийг тодруулбал, ТБАНТХ-ийн 10.1.5 дахь хэсэгт “мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах” бүрэн эрх олгосны дагуу Засгийн газар тогтоол гаргасан байна. Гэвч дээрх тогтоолд уг мэдээллийг төрийн нууц, эсхүл албаны нууцад хамааруулсан нь тодорхой бус байгаагаас гадна ҮАБЗ-ийн шийдвэрээр аливаа мэдээллийг төрийн нууцад хамруулах талаарх зохицуулалт ТБАНТХ-д тусгагдаагүй байна.

“Албаны нууц” ба “төрийн нууц” гэх ойлголтын ялгааг бусад хууль тогтоомжоос тодруулж үзвэл, **2021 оны Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд** мэдээллийг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

- 7.1.Нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилна.
- 7.2.Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг **нээлттэй мэдээлэл** гэж үзнэ.
- 7.3.Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт **тогтоосон албаны нууц** болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг **хязгаарлалттай мэдээлэл** гэж үзнэ.
- 7.4.Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл **төрийн нууцад** хамаарах мэдээллийг **хаалттай мэдээлэл** гэж үзнэ.
- 9.1.Албаны нууцад хамаарах мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан үндэслэл, журамд заасны дагуу ашиглана.
- 9.2.Энэ хуулийн 7.3-т заасан хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:
 - 9.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл;
 - 9.2.2.төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл;
 - 9.2.3.нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл;
 - 9.2.4.хуульд заасан бусад

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7.5-д “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй” талаар заасан. Эндээс үзвэл, “албаны нууц” гэж төрийн нууцад хамаарах мэдээлэл болон нээлттэй байх мэдээллээс бусад мэдээллийг ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд “албаны нууц” ба “төрийн нууц” нь хоорондоо ялгамжтай байдлаар зохицуулагдсан. Гэвч энэхүү зохицуулалт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.2-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл "онц чухал нууц", "маш нууц", албаны нууцад хамаарах мэдээлэл "нууц" зэрэглэлтэй байна” гэж заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд дээрх 2 ойлголтыг тусад нь томъёолсон ч албаны нууц мэдээлэл нь төрийн “нууц” зэрэглэлд хамаарахаар зөрчилтэй зохицуулжээ.

Мөн төрийн болон албаны нууцыг хамгаалах харилцаанд нэг журам үйлчилдэг бөгөөд энэ нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам²¹ юм. Уг журмын зохицуулалтыг нарийвчилбал:

Хүснэгт 3. Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын зохицуулалт

№	Журмын зохицуулалт	Төрийн нууцад үйлчлэх эсэх	Албаны нууцад үйлчлэх эсэх
1.	Нууцад хамаарах мэдээллийг нууцлах	+	+
2.	Нууцын зэрэглэлийг тогтоох	+	+
3.	Нууцын зэрэглэлийг өөрчлөх	+	+
4.	Нууц баримт бичиг, бусад тээгчид тэмдэглэгээ тавих	+	+
5.	Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийг ил болгох, нууцлах хугацааг сунгах	+	+
6.	Иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгох	+	
7.	Иргэнд албаны нууцтай танилцах эрх олгох	+	+
8.	Нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт гаргах, өөрчлөх	+	+
9.	Нууцтай танилцах эрхийн түвшин	+	+
10.	Нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох	+	+

²¹ Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208025&showType=1> , Сүүлд үзсэн огноо: 2024.04.17.

11.	Хуулийн этгээдэд нууцад хамаарах мэдээлэл ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх эрх олгох	+	+
12.	Нууцын албан хэрэг хөтлөлт	+	+
13.	Нууц мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах систем, сүлжээ, техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах	+	+
14.	Хуулийн этгээд нууцад хамаарах мэдээлэл ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил, гүйцэтгэх үед нууц мэдээллийг хамгаалах	+	+
15.	Нууц баримт бичиг, бусад тээгчийг шилжүүлэх, хүлээлцэх	+	+
16.	Нууц мэдээллийг гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх	+	+
17.	Нууцын биет хамгаалалт	+	+
18.	Хаалттай хуралдаан зохион байгуулах	+	+
19.	Нууцын хамгаалалтад тавих хяналт	+	+
20.	Хариуцлага тооцох	+	+

Дээрхээс үзвэл, төрийн нууц болон албаны нууц нь мэдээллийн нууцлалын зэрэглэлээс гадна тэдгээр мэдээллийг хэрхэн олж авах процессын түвшинд ялгагдаж байна. Мэдээлэлтэй танилцах эрх авах процессыг дэлгэрүүлбэл:

4.1.Иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгох

4.1.1.тухайн байгууллагаас төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад орсон албан тушаалтан нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.1.2.хяналт шалгалт хийх, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, суралцах явцад тодорхой түвшинд төрийн нууцтай танилцах зайлшгүй шаардлагатай албан хаагч, иргэнд байгууллагын дарга төрийн нууцтай танилцах зөвшөөрөл (энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 1) олгоно. Энэ тохиолдолд тухайн албан хаагч, иргэн нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.1.3.тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасан иргэн, албан хаагчтай холбоотой баримт бичиг (иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, боловсролын гэрчилгээ, диплом... гэх зэрэг)-ийг бүрдүүлэн биечлэн тулгаж шалгасны дараа холбогдох материалыг нууц хамгаалах ажилтанд шилжүүлэн өгнө.

4.1.4.нууц хамгаалах ажилтан материалыг хянаж, албан бичгийн хамт дугтуйнд хийж битүүмжлэн аюулгүй байдлын шалгалт хийлгэхээр тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

4.1.5.тагнуулын байгууллага аюулгүй байдлын шалгалтыг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу явуулж, тухайн иргэн, албан хаагчид тодорхой түвшинд төрийн нууцтай танилцах эрх олгох эсэх талаар хүсэлт гаргасан байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

4.1.6.энэхүү журмын 4.1.5-д заасны дагуу тагнуулын байгууллагаас зохих хариу өгөөгүй байхад тухайн иргэн, албан хаагчийг төрийн нууцтай танилцах албан тушаалд томилох, эсхүл төрийн нууцтай танилцах эрх олгохыг хориглоно.

4.1.7.энэ журамд заасан шаардлагыг хангасан иргэнийг төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалд томилох, эсхүл төрийн нууцтай танилцах эрх олгох тухай байгууллагын даргын шийдвэр гаргахаас өмнө нууц хамгаалах ажилтан тухайн иргэнд төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийг судлуулж, нууцтай танилцахад түүний тодорхой эрх хязгаарлагдах, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд зохих хариуцлага хүлээх, тэдгээртэй холбоотой бусад үр дагавар үүсэх тухай тайлбарлаж, энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 2-т заасан нууц задруулахгүй байх баталгааг гаргуулан авна.

4.1.8.нууц хамгаалах ажилтнаар томилох тухай шийдвэрт тогтоосон журмын дагуу олгох цалингийн нэмэгдлийг тусгасан байна.

4.2.Иргэнд албаны нууцтай танилцах эрх олгох

4.2.1.албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан уг албан тушаалд томилогдохдоо нууц задруулахгүй байх баталгаа гаргана. Ийнхүү баталгаа гаргаагүй албан тушаалтанд албаны нууц танилцуулахыг хориглоно.

4.2.2.хяналт шалгалт хийх, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, суралцах явцад албаны нууцтай танилцах зайлшгүй шаардлагатай албан хаагч, **иргэнд байгууллагын дарга энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 1-д заасан албаны нууцтай танилцах зөвшөөрлийг олгоно.** Энэ тохиолдолд хүсэлт гаргасан албан хаагч, иргэн нууцын баталгаа гаргана.

Төрийн нууцтай танилцах эрх олгохдоо Тагнуулын байгууллагын саналыг үндэслэж, байгууллагын дарга зөвшөөрөл олгох бол, албаны нууцтай танилцах этгээдэд байгууллагын дарга зөвшөөрөл олгохоор байгаа юм.

Улс орнуудын нууцын холбогдолтой хууль тогтоомжийг судалж үзэхэд, пост социалист орнууд, тухайлбал Казакстан²², Киргизстан²³, Узбекстан²⁴ зэргээс бусад улс оронд “албаны нууц” хэмээх ойлголт байхгүй байна. Дээрх улсуудад албаны нууц буюу “**служебная тайна**” нь төрийн нууцад хамаарч байгаа юм. Өөрөөр хэлбэл, төрийн нууцыг онц чухал, маш нууц, нууц гэж ангилах бөгөөд албаны нууц нь төрийн нууцын “нууц” зэрэглэлд хамаардаг.

Бусад улс оронд дээрх ойлголт түгээмэл биш юм. Жишээ нь, Эстони Улсын Төрийн болон гадаад улсын нууцын тухай хуульд төрийн нууцыг ач холбогдлоор нь хязгаартай (restricted), нууц (confidential), маш нууц (secret), онц чухал нууц (top secret) зэргээр ангилсан боловч “албаны нууц” гэсэн ойлголт байхгүй.²⁵ Түүнчлэн Хонг конг, Их Британи, Малайзад “Official secrets act” гэж байгаа боловч тухайн актын хүрээ нь батлан хамгаалах, тагнуул, гадаад харилцаа зэрэгт хамаарах төрийн нууцын хүрээгээр хязгаарлагддаг байна. Герман Улсад “албан тушаалын нууц” гэх ойлголтыг 2006 оноос халж, захиргааны соёл, сэтгэлгээнд өөрчлөлт оруулсан байна.²⁶

Харин зарим улсын Нийтийн мэдээллийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичигт “албаны мэдээлэл” гэх ойлголт тусгагджээ. Төрийн байгууллагаас боловсруулсан, эсхүл түүнд шилжүүлсэн, түүний

²² Закон Республики Казахстан от 15 марта 1999 года № 349-І О государственных секретах, Холбоос: https://online.zakon.kz/Document/?doc_id=1012633&pos=60;-8#pos=60;-8, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

²³ Закон КР от 15 декабря 2017 года № 210 (15) “О защите государственных секретов Кыргызской Республики”, Холбоос: <https://cbd.minjust.gov.kg/111719/edition/1229912/ru>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

Статья 9. Степени секретности сведений, составляющих государственные секреты, грифы секретности носителей этих сведений

1. Государственные секреты Кыргызской Республики по степени важности составляющих их сведений подразделяются на две категории: государственную тайну (сведения, составляющие государственную тайну) и служебную тайну (сведения, составляющие служебную тайну).

2. Устанавливаются три степени секретности сведений, составляющих государственные секреты, и соответствующие этим степеням грифы секретности для носителей указанных сведений: “особой важности”, “совершенно секретно” и “секретно”.

3. Сведениям, составляющим государственную тайну, присваиваются грифы секретности “особой важности”, “совершенно секретно”.

4. Сведениям, составляющим служебную тайну, присваивается гриф секретности “секретно”. Служебная тайна имеет характер отдельных сведений, относящихся к государственной тайне, и не раскрывает их полностью.

²⁴ Закон Республики Узбекистан, от 07.05.1993 г. № 848-ХІІ

Статья 3. Категорий государственных секретов

Государственные секреты Республики Узбекистан подразделяются на государственную, военную и служебную тайну.

Государственную тайну составляют сведения, разглашение которых может оказать отрицательное воздействие на качественное состояние военно-экономического потенциала республики или повлечь другие тяжкие последствия для обороноспособности, государственной безопасности, экономических и политических интересов Республики Узбекистан. Военную тайну составляют сведения военного характера, разглашение которых может повлечь тяжкие последствия для обороноспособности, государственной безопасности и Вооруженных Сил Республики Узбекистан.

Служебную тайну составляют сведения в области науки, техники, производства и управления, разглашение которых может нанести ущерб интересам Республики Узбекистан.

²⁵ State Secrets and Classified Information of Foreign States Act, Холбоос: <https://www.riiqiteataja.ee/en/eli/521052020005/consolide>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.19.

²⁶ Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, (УБ, 2010), 38 дахь тал.

мэдэлд байгаа аливаа мэдээллийг албан мэдээлэл гэж үздэг боловч түүнийг нууцлах ойлголт яригддаггүй. Дээрх хууль тогтоомж нь албаны мэдээллийн ил тод байдлыг хангах, түүнтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах гол эх сурвалж болдог .

Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж, тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах байдлыг үгүйсгээгүй улс орнууд ч мөн бий бөгөөд ийнхүү хязгаарлах тохиолдлыг хуульд тухайлан заасан байгаагаас гадна хязгаарласан мэдээллийг “нууц” гэж томъёолоогүй байна.

Судлаачид “албаны нууц” хэмээх тусдаа ойлголт байх шаардлагагүйг тайлбарлахдаа, төрийн байгууллага нь төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг бөгөөд, төрийн нууц гэх ойлголтыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан байдаг тул үүн дээр дахин төрийн байгууллагын нууцын тухай ойлголтыг давхардуулах шаардлагагүй гэж үзжээ.²⁷

Байгууллагын нууцын тухай (одоогоор “албаны нууц”) ойлголтыг гол төлөв бизнесийн үйл ажиллагаанд хамааруулан шүүхийн практикаар хамрах хүрээг нь тодорхойлох хандлага нийтлэг бөгөөд дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байхыг шаарддаг байна. Үүнд:²⁸

1. Мэдээлэл нь тодорхой нэг хуулийн этгээд, ямар нэгэн бизнесийн байгууллагатай шууд холбоотой байх;
2. Тухайн мэдээлэл нь нээлттэй биш байх, өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал тооны этгээдүүд мэдэж байх;
3. Бизнесийн байгууллагын эзэмшигч нууц болгон хадгалах хүсэлт гаргасан байх;
4. Бизнесийн байгууллага ажилтантай гэрээ байгуулан байгууллагын нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээлгэн, зохицуулалт хийх зэргийг нэрлэж болно.

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийг шинэчлэхдээ Байгууллагын нууцын тухай хуулиас төрийн албаны буюу төрийн байгууллагын харилцааг салгаж, ТБАНТХ-иар төрийн нууц болон албаны нууцын харилцааг хамтад нь зохицуулж эхэлсэн. Дээрх шинэчлэл нь Байгууллагын нууцын тухай хуулийн хэрэглээнд эерэг нөлөө үзүүлсэн ч төрийн нууцын тухай хууль тогтоомжид зарчмын шинжтэй алдаа гаргахад хүргэжээ. Харин Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд томъёолсон “хязгаарлагдмал мэдээлэл”²⁹ нь албаны буюу төрийн байгууллагын нууцалбал зохих мэдээллийн хүрээтэй илүү нийцжээ.

Мөн “Салбарын болон байгууллагын ашиг сонирхол” гэх ойлголт нь хэт өргөн хүрээтэй бөгөөд албаны мэдээллийн мөн чанарт нийцэхгүй юм. Албан мэдээллийг нээлттэй мэдээлэхээс татгалзаж буй нь төрийн үйл ажиллагааны тасралтгүй, мэргэжлийн, үр нөлөөтэй байдлыг хангахад мөн чиглэх ёстой. Гэвч албаны мэдээллийг нууцад тооцохоор хуульчлах, ялангуяа төрийн нууцын тухай хуулиар хамтад нь

²⁷ Мөн тэнд, 36 дахь тал.

²⁸ Мөн тэнд, 37 дахь тал.

²⁹ НМИТБТХ-ийн 7.3.Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ.

зохицуулах нь “төрийн нууц”-ыг хамгаалах замаар үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тус хуулийн зорилго, мөн чанартай нийцэхгүй байгааг эргэн харах нь зүйтэй.

Албаны нууцад хамаарах мэдээллийг төрийн нууц хэмээх ойлголтоос юун түрүүнд салгах нь зүйтэй. Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.2-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл “онц чухал нууц”, “маш нууц”, албаны нууцад хамаарах мэдээлэл “нууц” зэрэглэлтэй байна” гэж заасныг өөрчлөх шаардлагатай. Мөн хуулиар нээлттэй байх ёстой мэдээлэл болон төрийн нууцаас бусад мэдээллийг “албаны мэдээлэл” гэж нэрлэх замаар нууц, түүний хамгаалалтын ойлголтоос салгах нь зүйтэй. Учир нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар аливаа мэдээллийг хуулиар нууцлах бөгөөд харин журмаар аливаа мэдээллийг нууцлах нь Үндсэн хуульд нийцэхгүй. Жишээ нь Молдав Улсад албаны мэдээллийг тогтоохоор хуулийн төсөл боловсруулж байсан ч тухайн хуулийн төсөл дэмжигдээгүйг анхаарах нь зүйтэй.

Төрийн байгууллагын нууцад хамаарах мэдээлэл нь бизнесийн байгууллагын ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн байдаг бол хамаарахгүй мэдээлэл нь гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэдэг гэжээ. Иймд байгууллагын нууц буюу албаны нууцад хамаарахгүй мэдээллийг тусгайлан заах нь төрийн байгууллага, албан тушаалтны дур зоргыг хязгаарлахад чухал ач холбогдолтой.

Мөн практикт ихэнх төрийн байгууллага албаны нууцын жагсаалтыг байгууллагын дотоод журмын хавсралтаар зөвхөн нэг удаа баталж байгаа нь албаны нууцын мэдээллийн жагсаалтыг давтамжтай хянах, шинэчлэх асуудал орхигдоход хүргэснийг анхаарвал зохино.

Энэхүү судалгааны хүрээнд ТБАНТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д заасан “албаны нууц” гэх нэр томъёоны зохицуулалт нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалах зорилгод нийцсэн эсэх талаар дараах дүгнэлтэнд хүрч байна. Үүнд:

1. ТБАНТХ дахь албаны нууцын тодорхойлолт нь хэт өргөн, тодорхойгүй бөгөөд ялгаа зааг, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс албаны нууцыг ангилахад хүндрэл учирч, төрийн байгууллагын удирдлагууд өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал үүсэж байгаа нь МУ-ын Үндсэн хуульд заасан иргэний төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих, нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчиж байх тул уг зохицуулалт нь ТБАНТХ-ийн зорилгод нийцээгүй гэж дүгнэлээ.

Албаны нууц гэх ойлголт гаднын улс орнуудад, тухайлбал Казакстан, Киргизстан, Узбекстан зэрэг пост социалист улсад (**служебная тайна**) байх боловч албаны нууц нь төрийн нууцын “нууц” ангилалд хамаардаг. Ийнхүү хуульчилсан нь Монгол Улстай адил боловч албаны нууцыг төрийн байгууллагын даргын тушаалаар тогтоодоггүй. Харин бусад улс орнуудын нийтийн мэдээллийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид “албан мэдээлэл” гэх ойлголт цөөнгүй тусгагджээ. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах боломжтой ч хязгаарласан мэдээллийг нууц гэж үздэггүй байна.

Иймд Төрийн нууцын хууль тогтоомж дахь “албаны нууц” гэх ойлголтыг халж, Нийтийн мэдээллийн тухай хуулиар үүнд холбогдох харилцааг зохицуулах, хязгаарлаж

болох албан мэдээллийн жагсаалтыг байгууллагын дотоод журмаар нэг удаа батлаад орхих бус жил бүр, эсхүл тодорхой давтамжтайгаар шинэчилж байх зохицуулалтыг тусгах шаардлагатай. Үүний зэрэгцээ төрийн байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтнуудын ойлголтыг нэгдмэл болгох тал дээр анхаарах нь зүйтэй. Байгууллагын дотоод журам, жагсаалт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн байх, хэрэв зөрчилдвөл уг хуулийн давуу байдлыг хангах зохицуулалтыг хуульчилбал өнөөгийн практикт тулгарч буй хууль хэрэглээний хүндрэлийг даван туулахад чухал ач холбогдолтой юм.

3.7. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	5 дугаар зүйл. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх	Зорилгод хүрсэн түвшин

3.7.1. Зорилгод хүрсэн түвшин

5 дугаар зүйл. Гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх

1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг дараахь үндэслэлээр дор дурдсан хугацаагаар түдгэлзүүлнэ:

1/гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл;

2/эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл;

3/хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан бол уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор;

4/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэрт заасан хугацаагаар;

5/хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлээр Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлахыг хориглоно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт цагдаагийн байгууллага хяналт тавина.

4. Гадаад улсад гамшиг, аюулт үзэгдэл болон аюул, онц болон дайны байдал бий болсны улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд аюул учирч болзошгүй нөхцөл буй болсон бол Засгийн газар уг улсад зорчих, цагаачлах иргэдэд энэ тухай урьдчилан мэдээлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” гэж заасан.

1994 онд баталсан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх буюу хилийн хоригтой холбоотой асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа тус хуульд үндэслэл, хугацааг тусгасан боловч хилийн хоригийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд эрх бүхий байгууллагуудын олон тусдаа шийдвэрээр баталсан журмууд хэрэгждэг, нэгдсэн бүртгэл байхгүй тул уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох шаардлага байсаар байна.

Иймээс хуульд тусгасан Монгол Улсын иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлдүүлэх үндэслэлийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлж өөрчлөн, найруулах нь зүйтэй. Ингэхдээ хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх зохицуулалт үйлчилж ирснийг халах шаардлагатай. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт цагдаагийн байгууллага хяналт тавих зохицуулалт хуулийн зорилгод нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагааг нарийвчлан хуульчлах, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, цуцалсан талаарх мэдээллийн нэгдсэн сан байгуулах, эрх бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам батлах эрхийг Засгийн газарт олгохоор хуульчлах боломжтой гэж үзэж байна.

3.8. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
4.1.27. "нөлөөллийн урьдчилсан үнэлгээ" гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг.	Зорилгод хүрсэн түвшин

3.8.1. Зорилгод хүрсэн түвшин

4.1.27. "нөлөөллийн урьдчилсан үнэлгээ" гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого,

төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино. Мөн тус хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хөгжүүлэх явцад иргэний өмчид халдах, албадан нүүлгэх үйл ажиллагаа явагддаг бөгөөд энэхүү ажиллагаанд хүний хувийн халдашгүй байдал буюу өмчийн халдашгүй байдал, орон байрны халдашгүй байх эрх хөндөгддөг.

Гэтэл нөлөөллийн урьдчилсан үнэлгээ нь тус бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг хийдэг боловч Үндсэн хуульд заасан хүний хувийн халдашгүй байдлын талаарх судалгааг хийдэггүй байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.27-д "нөлөөллийн урьдчилсан үнэлгээ" гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг ойлгохоор заажээ. Үүнд хөгжлийн төлөө төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ үүсч болох эрсдэл, хохирлыг бууруулах үүднээс хүний эрхийн чиглэлээр тооцоо, судалгаа хийх зохицуулалт орхигдсон байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн халдашгүй байдалтай холбоотой судалгаа хийж, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд тусгах шаардлагатай.

3.9.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	1.8 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал	Практикт нийцэж байгаа байдал
2.	4.5 дугаар зүйл. Эд зүйл, баримт бичиг хураан авах	Зорилгод хүрсэн түвшин

3.9.1. Зорилгод хүрсэн түвшин

4.5 дугаар зүйл.Эд зүйл, баримт бичиг хураан авах

8.Хэрэгт ач холбогдолтой цахим баримтыг хуулбарлан авах, эсхүл түүнийг устгах, нэвтрэх боломжийг хязгаарлах боломжгүй бол цахим төхөөрөмжийг хураан авч болно.

Зөрчлийн тухай хуулийн зорилго нь "...хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд орших..." бөгөөд үүнд цахим засаглалын хөгжил чухал ач холбогдолтой. Гэвч тус хуульд "цахим" гэдэг нэр томъёог 2 удаа хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл, цахим хэлбэрээр зөрчлийг бүртгэх, дугаар олгох, шалгах, шийдвэрлэх талаар шинэлэг

зохицуулалт тусгах хэрэгцээ, шаардлага бий. Энэ нь тухайн зөрчлийг орон зайнаас үл хамааран, шуурхай, зөрчил шалгах бүхий л зардлыг хэмнэсэн, цар тахлын нөхцөл байдлаас үл хамааран хууль хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн шийтгэл оногдуулсан шийдвэр, шийтгэлээс чөлөөлөх шийдвэрийн хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж, шийдвэр оногдуулах эрх зүйн орчин бүрдэх боломжтой.

Монгол Улс цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлд хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол бодлого, стратегийн хүрээнд Шинэ сэргэлтийн бодлого, Төрийн бүтээмжийн сэргэлт, “Цахим үндэстэн” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд дараах бодлогын баримт бичиг баталсан байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-т “Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.” гэж тусгагдсан ба 1-р үе шат буюу 2021-2030 онд хэрэгжүүлэх арга хэмжээг “2.Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болж хөгжинө.”; “3.Цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно.” гэж тодорхойлсон. Мөн “Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига үүсэх эрсдэлээс хамгаална.” гэж тус бодлогын баримт бичгийн 2 дугаар хавсралтаар батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний 5.3.21-т тусгажээ.

"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.2-т “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.”, 4.1.3-т “Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан “Цахим үндэстэн” баримтлах чиглэлийн 2.3.5 дахь хэсэгт “Иргэн, хуулийн этгээдийг мэдээллээр хангаж нээлттэй засаглал буюу төрд итгэх итгэл, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлж мэдээлэл хариуцагчаас шаардлагатай мэдээлэл, мэдэгдлийг нэгдсэн байдлаар хүргэх платформыг нэвтрүүлнэ” гэж тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2012 онд батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн гуравдугаар зорилтод “Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох;” гэж тусгасан ба 5.3.2-т “төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох зорилгоор гүйцэтгэлд тулгуурласан үнэлгээний мэдээллийн системийг нэвтрүүлэх;”, 5.3.3-т “эрэлт ихтэй, иргэдэд чирэгдэл учруулан ачааллыг үүсгэдэг төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх;” арга хэмжээг тусгажээ.

Монгол улсын Засгийн газрын 2005 онд батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрт “Төрийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо (Integrated system), мэдээллийн нэгдсэн санг байгуулж “Төрийн ой” (Government institutional memory)-г бий болгох” гэж тусгаж байв.

Мөн шүүхийн шинэчлэлийн хүрээнд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11-д "...шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх..." гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.6-д "...шүүхийг дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх..." гэж тус тус заасан бөгөөд дээрх зохицуулалтуудтай уялдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 332 дугаар тогтоолоор "Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого"-ыг баталсан.

Түүнчлэн Улсын ерөнхий прокурорын газраас Прокурорын байгууллагын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг Төрийн албаны тухай хууль, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан бөгөөд энэхүү стратеги төлөвлөгөөнд дараах 5 зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байна. Үүнд:

- Олон нийтэд прокурорын байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх;
- Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах;
- Прокурорын хяналтын ажлын чанар, үр нөлөөг сайжруулж, боловсронгуй болгох;
- Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг сайжруулах;
- Цахим шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх.

Энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд прокурорын байгууллага үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшил, инноваци нэвтрүүлэх, ажлын үр нөлөө, бүтээмжийг нэмэгдүүлэх, их өгөгдлийг бодлогын шийдвэр гаргахад ашиглах, зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, статистикийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зэрэг арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн хэрэг, цагдан хорих гэх мэт харилцаанд хамаарах асуудлыг цахимжуулах боломжтой. Гадаад орнуудын туршлагаас харахад процессын хуулиудад ерөнхий зохицуулалтыг тусгаж, нарийвчилсан зохицуулалтыг журам батлан хэрэгжүүлдэг туршлага нийтлэг байна. Манай улс хуульдаа цахимаар мэдүүлэх, цахим хавтаст хэрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгах нь шүүх болон бусад хуулийн байгууллагын цахимжилтад эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой юм.

3.9.2. Практикт нийцэж байгаа байдал

1.8 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна.

ЗШШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах чиглэлээр холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөрчил шалган шийдвэрлэх харьяалалтай холбоотой дараах саналыг ирүүлжээ³⁰:

³⁰ Эрх бүхий байгууллагуудаас ХЗДХЯ-нд ирүүлсэн санал. 2020 он.

- ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.10-т зааснаар мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг дангаараа шалгах харьяалалтай. Харин согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, түрээсэлсэн гэх зөрчлийг цагдаагийн байгууллагын алба хаагч эргүүл, хяналт, шалгалтын явцад илрүүлэн шалгаж шийдвэрлэх бүрэн боломжтой байх тул давхар харьяалалтай болгох;
- Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчилд зөвхөн торгох шийтгэл оногдуулах заасан тул шүүхээр шийдвэрлэх шаардлагагүй. Иймд тус зөрчлийг мэргэжлийн хяналтын улсан байцаагч харьяалан шийдвэрлэхээр ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалт болон 7 дахь хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тус тус өөрчлөлт оруулах;
- Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчлийг ахлах шийдвэр гүйцэтгэгчээс гадна хүүхдийн эрхийн улсын байцаагчид давхар харьяалуулсан нь оновчгүй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.26 дахь заалтад өөрчлөлт оруулах;
- Онцгой байдлын байгууллага галын аюулгүй байдлыг хангуулах чиг үүргийнхээ хүрээнд тусгай объектод ил гал гаргаж, утаат тамхи татаж буй зөрчилд хариуцлага тооцдог зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Иймд цагдаагийн байгууллагаас гадна гал түймрийн улсын хяналтын байцаагч нь “5.14 дүгээр зүйл, 7.9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, гэсний дараа “...6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг”-т заасан зөрчлийг давхар харьяалан шийдвэрлэхээр ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.17 дахь заалтад нэмэлт оруулах;
- Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулж ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтаас “10.19 дүгээр зүйл” гэснийг хасах, мөн тус зөрчлийн харьяалаллыг тогтоох;
- Гаалийн хяналтын байцаагч нь хяналт шалгалтынхаа хүрээнд гаалийн хилээр нэвтрүүлсэн оюуны өмчийн зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг илрүүлж, шийдвэрлэх боломжтой тул ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтап “Зөрчлийн тухай хуулийн 8.3, 8.4, 8.5 дугаар зүйлд заасан зөрчил”-ийг нэмэлтээр тусгах;
- Цагдаагийн байгууллагын бүтцэд шинээр бий болсон экологийн асуудал хариуцсан байцаагчийн шалгах зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэргийн харьяалал хуульд тусгагдаагүй байгаа нь маргаан үүсгэсээр байна. Иймд ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалтад Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалт, мөн хэсгийн 6 болон 7 дахь заалт, 7.12 дугаар зүйлийн 1 болон 4 дэх хэсэг, 7.13 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, 7.15 дугаар зүйлийн 3 болон 4 дэх хэсэг, 7.17 дугаар зүйлийн 2 дахь хэсгүүдийг тус тус нэмэх.

Үүнээс гадна зарим эрх бүхий байгууллага нь орон нутагт нэгж, ажилтан байхгүйгээс орон нутагт гарсан зөрчлийг хянан шийдвэрлэх боломжгүй байдаг, зарим байгууллагын хувьд улсын байцаагчийн эрхийг хяналт хариуцсан мэргэжилтэнд биш байгууллагын удирдлага, орон тооны бус зөвлөлийн гишүүдэд олгохоор хуульчилсны улмаас хуулиар харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэх боломжгүй болсон зэрэг асуудал ч хөндөгдөж байна.

Иймд эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг Зөрчлийн тухай хуулийн шинэчлэлд нийцүүлэн оновчтой тогтоох, улмаар хэрэгжих баталгааг бүрдүүлэх зорилгоор хүний нөөц, төсөв, зохион байгуулалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай байна.

3.10.Зөрчлийн тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	3.7 дугаар зүйл. Баривчлах шийтгэл	Практикт нийцэж байгаа байдал
2.	3.7 дугаар зүйл. Баривчлах шийтгэл	Зорилгод хүрсэн түвшин

3.10.1. Зорилгод хүрсэн түвшин

3.7 дугаар зүйл. Баривчлах шийтгэл

4.Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй.

Зөрчлийн тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөө, хувийн өмч зэрэг үнэт зүйлс, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг ялгамжтай оногдуулах, хууль зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор баталжээ. Уг хууль нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 230 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн³¹ анхны хууль болсон.

Шүүхээс сүүлийн 15 жилийн байдлаар шийдвэрлэсэн захиргааны зөрчлийг судлан үзвэл жилд дунджаар 10,000-20,000 орчим хэрэг шийдвэрлэн, 6000-8000 орчим хүнд баривчлах шийтгэл ногдуулдаг байна.³²

Зөрчлийн тухай хууль нь 240 орчим хуулиар хориглож, хязгаарласан 1800 орчим үйлдэл, эс үйлдэхүйг нэгтгэсэн Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг зөрчсөн тодорхой төрлийн захиргааны зөрчлүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн, зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг хуульчилж өгсөн.

Өөрөөр хэлбэл, зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино. Уг зорилгод хүрэхийн тулд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд 4 шийтгэлийн төрлийг оногдуулсан бөгөөд үүнийг нэг нь баривчлах

³¹ Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Холбоос: <http://forum.parliament.mn/projects/75>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

³²Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нар, Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Холбоос: <https://sudalгаа.gov.mn/download/barivchlahk-shiytgel-onogduulsan-shkhiyn-shiydveriyg-gytsetgekh-azhillaga-zbq>, 27 дахь тал, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

шийтгэл юм. Торгох, баривчлах шийтгэлийг үндсэн шийтгэлийн хэлбэрээр оногдуулдаг. Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдсэн тохиолдолд торгох, баривчлах, эрх хасах гэсэн шийтгэл оногдуулахаар зохицуулсан ба 931 торгох, 9 баривчлах, 16 эрх хасах, мөн торгох, баривчлах үндсэн шийтгэл дээр нэмэгдүүлэн эрх хасах шийтгэлийг оногдуулахаар заажээ. Гэвч баривчлах байрны алба хаагчаас авсан судалгаагаар судалгаанд оролцогчдын 52.3% нь баривчлах шийтгэлийн үндсэн зорилгыг буруу хариулсан байна.³³

Мөн тус судалгааны дүнг үзвэл, баривчлах төвд ажиллаж буй 41 алба хаагчаас баривчлах шийтгэлийн үр нөлөөг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад 31 алба хаагч буюу 75,6% баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай, 9 алба хаагч буюу 21,9% нь ямар ч үр нөлөө алга гэж хариулсан бол сайн үр нөлөөтэй гэж үзсэн алба хаагч байхгүй.

График 1. Баривчлах шийтгэлийн үр нөлөөний үнэлгээ




Баривчлах төвд ажиллаж буй албан хаагчдаас гадна баривчлагдсан 452 этгээдээс баривчлагдсан этгээдийн эрхийг хангах ажлыг хэрхэн дүгнэх вэ гэсэн асуултад 228 хүн буюу 50,4% нь сайжруулах шаардлагатай, 146 хүн буюу 32,3% нь муу, 78 хүн буюу 17,2% нь хангалттай сайн гэж хариулжээ.

Судалгаанд оролцсон 452 баривчлагдсан этгээд баривчлах байрны нөхцөл, журам таны хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу? гэсэн асуултанд 151 хүн буюу 33,4% нь муу, 78 хүн буюу 17,2% нь сайн, 223 хүн буюу 49,3% нь хангахгүй байна гэж хариулсан байна.

³³ Б.Алтангэрэл, М.Хүрэлбат нар, Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, Холбоос: <https://sudalгаа.gov.mn/download/barivchlakh-shiytgel-onogduulsan-shkhiyn-shiydveriyg-gytsetgekha-zhillaga-zbq>, 28 дахь тал, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

График 2. Баривчлах байрны нөхцөл, журам, хэрэгцээ шаардлага хангаж байгаа эсэх



Ийнхүү баривчлах байрны алба хаагчдын 52.3% нь баривчлах шийтгэлийн үндсэн зорилгыг буруу хариулсан, баривчлах төвд ажиллаж байгаа алба хаагчдын 75,6% нь баривчлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай, баривчлагдсан этгээдийн 50,4% нь баривчлагдсан этгээдийн эрхийг хангах ажлыг сайжруулах шаардлагатай, баривчлагдсан этгээдийн 83 хувь нь баривчлах байрны нөхцөл журмыг хангалтгүй гэж үзэж байна. Иймд дээрх үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн 3.7.4 дэх заалт мөн хуулийн зорилгод нийцэхгүй байна.

3.10.2. Практикт нийцэж байгаа байдал

3.7 дугаар зүйл. Баривчлах шийтгэл

4.Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй.

ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2016-2019 оны хооронд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдлүүлсэн хүний тоог авч үзвэл, 2016 онд-3031, 2017 онд-5159,2018 онд-4356, 2019 онд 7815 хүн шийтгэл эдэлсэн байна. Энэхүү статистик мэдээллээс үзвэл ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд 2016-2019 оны хооронд шүүхээс оногдуулсан баривчлах шийтгэл эдэлсэн хүний тоо тасралтгүй өссөн байна.

Харин Монгол Улсын шүүхийн тайланд зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд 2018 онд 11813, 2019 онд 16235³⁴, 2020 онд 17644³⁵, 2021 онд, 16865, 2022 онд 20164³⁶ хүнд баривчлах шийтгэл оногдуулсан байна. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхээс 2018 онд зөрчлийн 12981 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 91% хувьд, 2019 онд зөрчлийн 17656 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 92% хувьд, 2020 онд

³⁴Монгол Улсын шүүхийн тайлан, 2019 он, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, (УБ, 2020) Холбоос: https://docs.google.com/file/d/1KLjeW_olc35vsSPmhSTnas0z80UQsUc8/view, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

³⁵Монгол Улсын шүүхийн тайлан, 2021 он, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, (УБ, 2022) Холбоос: <https://drive.google.com/file/d/1idrOGcvKAIUwiu0FN-StVBBQOOTeWRpH/view>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

³⁶Монгол Улсын шүүхийн тайлан, 2022 он, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, (УБ, 2023) Холбоос: https://drive.google.com/file/d/18oxr2jarQc1JslTkXo_IIXOvAHcRx_Od/view, Сүүлд үзсэн огноо: 2024.04.18.

зөрчлийн 20922 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 84% хувьд, 2021 онд зөрчлийн 21162 хэрэг хүлээн авсан бөгөөд үүний 80% хувьд, 2022 онд 24162 хэргийг хүлээн авсан бөгөөд үүний 83% хувьд тус тус баривчлах шийтгэлийг оногдуулсан байна.

Дээрхээс дүгнэн үзвэл баривчлах шийтгэл оногдуулсан тоо жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 2022 онд 2018 оноос даруй 1.7 дахин их тоогоор баривчлах шийтгэл оногдуулсан байна. Мөн сүүлийн 5 жилийн хугацаанд анхан шатны шүүхээр шийдэгдэж буй зөрчлийн хэргийн 86 хувьд баривчлах шийтгэл оногдуулж байна.

Иймд анхан шатны шүүхээс баривчлах шийтгэл оногдуулах тоог багасгахын тулд Зөрчлийн тухай хуулийн 3.7.4 дэх заалтын хүрээг нэмэгдүүлэх буюу баривчлах шийтгэл оногдуулж болохгүй тохиолдлыг нэмж тусгах хувилбар зохистой гэж үзэж байна. Тухайлбал, тус заалтад арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг эх гэж оруулсан нь учир дутагдалтай байх тул арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх гэж өөрчлөн найруулах нь зүйтэй. Мөн бага насны хүүхэдтэй эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн гэх мэт субъектыг хүндэтгэн үзэж, баривчлах шийтгэл оногдуулахгүй байх тохиолдолд хамруулж хуульчлах нь зүйтэй. Мөн тухайн заалт дахь “баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн” гэснийг тодорхойлж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

3.11.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	5 дугаар зүйл. Хууль зүйн туслалцааны төрөл	Зорилгод хүрсэн түвшин
2.	6 дугаар зүйл. Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүн	Практикт нийцэж байгаа байдал

3.11.1. Зорилгод хүрсэн түвшин

5 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны төрөл
5.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан хууль зүйн туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хууль зүйн туслалцааны тухай хууль нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох зорилготой. Энэ ч утгаараа мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “...хууль зүйн туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж хуульчилсан.

Дээрх эрх олгосон заалтад үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/351 дугаар тушаалын хавсралтаар “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ыг баталсан.³⁷

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг сайд нарт даалгасан. Иймд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусган боловсруулах шаардлага бий болсон.

Иймд хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, мөн нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хуульд заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмаар зохицуулж байсан харилцааг Хууль зүйн туслалцааны тухай хуулиар зохицуулах, тус хуульд байгаа журамт батлах эрх олгосон заалтыг хүчингүй болгох шаардлагатай.

3.11.2. Практикт нийцэж байгаа байдал

6 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүн
6.1.Дор дурдсан хүн /цаашид "үйлчлүүлэгч" гэх/-д энэ хуульд заасан журмын дагуу өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлнэ:
6.4.Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх энэ хуулийн 6.1.4, 6.1.5-д заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа авч болно.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлд Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүнийг заасан байна. Тус хуулийн дагуу дор дурдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлнэ: Үүнд:

1. Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;
2. Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;
3. төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан;
4. хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;

³⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/351 дугаар тушаалаар баталсан “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532143313531> , Сүүлд үзсэн огноо: 2024.04.20.

5. үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол;
6. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэж тус тус хуульчилсан.

Олон улсын хүний эрхийн гэрээний дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, ялангуяа гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг төрөөс баталгаажуулах талаар олон улсын байгууллагаас байнга зөвлөсөөр ирсэн.

Иймд хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлж болох агуулгаар тусгасныг заавал үзүүлэхээр болгон өөрчилж, мөн хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрсэн хохирогч нь төлбөрийн чадваргүй тохиолдолд л туслалцаа үзүүлэхээр заасныг энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг заавал төлбөрийн чадваргүй байхыг шаардахгүй байхаар өөрчлөн хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээ хязгаарыг өргөжүүлж, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Мөн тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан “ахмад настан”, “хөдөлмөрийн чадвараа алдсан хүн”, “өрх толгойлсон эцэг эх”, “олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх” зэрэг нэр томъёоны тайлбарыг бусад хууль тогтоомжоос эшлэл байдлаар оруулах нь зүйтэй. Тодруулбал, Ахмад настны эрхийн тухай хуулийн 3.1-д “ахмад настан”-г “...60, түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээ дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн...”-ийг гэж³⁸, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8-д ““өрх толгойлсон эх /эцэг/” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг гэж³⁹, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6.4-т “олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх”-г 0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг улирал бүр тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна⁴⁰ гэж заасныг тус тус эшлэх байдлаар хуульд тусгах нь зүйтэй юм.

Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, мөн нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хуульд заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмаар зохицуулж байсан харилцааг Хууль зүйн туслалцааны тухай хуулиар зохицуулах, тус хуульд байгаа журамт батлах эрх олгосон заалтыг хүчингүй болгох шаардлагатай.

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлж болох агуулгаар тусгасныг заавал үзүүлэхээр болгон өөрчилж, мөн хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрсэн хохирогч нь төлбөрийн чадваргүй тохиолдолд л туслалцаа үзүүлэхээр заасныг энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг заавал төлбөрийн чадваргүй

³⁸Ахмад настны тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг.

³⁹Нийгмийн халамжийн тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь хэсэг.

⁴⁰Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг.

байхыг шаардахгүй байхаар өөрчлөн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээ хязгаарыг өргөжүүлж, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан “ахмад настан”, “хөдөлмөрийн чадвараа алдсан хүн”, “өрх толгойлсон эцэг эх”, “олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх” зэрэг нэр томъёоны тайлбарыг бусад хууль тогтоомжоос эшлэл байдлаар оруулах нь зүйтэй.

3.12. Дайчилгааны тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур
1	4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь заалт	Зорилгод хүрсэн түвшин

3.12.1. Зорилгод хүрсэн түвшин

4.5. Улсын дайчилгаа явуулахад дараах үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.5.8. хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах;

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орон болж, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ыг хүлээн зөвшөөрсөн. Мөн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элссэн билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.” гэж заасан.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой; а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” хэмээн хязгаарлалтыг нарийвчлан тодорхойлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж, мөн хуулийн арван зургаадугаар дугаар зүйлийн 16 дахь хэсэгт “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй...” гэж, мөн зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор

тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэж тус тус заасан. Үндсэн хуулийн эдгээр заалтад мэдээлэл түгээх эрхийн талаар үгчлэн оруулаагүй хэдий ч дээр дурдсан олон улсын гэрээний дагуу ‘хил хязгаарыг үл харгалзан’ мэдээлэл хайх, хүлээн авах болон түгээх эрх баталгаажсан гэж үздэг.

Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.3.2-т “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх, үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооноос үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд зайлшгүй бус, тохиромжгүй хязгаарлалт тогтоохгүй байхыг зөвлөдөг.⁴¹ Манай улсын хувьд Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө баталгаажуулах үүднээс 1988 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 3.1-д “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.” гэж, мөн хуулийн 3.2-т “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй.” гэж тус тус заажээ.

Гэтэл Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт улсын дайчилгаа явуулахад авч хэрэгжүүлэх үндсэн 10 арга хэмжээг заасны дотор хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээг багтаасан байна.

“Дайчилгаа” гэдэг нь шаардлагатай үед улс орны эдийн засаг, нийгмийг дайны бэлэн байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулахын тулд дайчилгааны бэлтгэл, нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилахтай холбогдсон төрөөс хэрэгжүүлж буй цогц арга хэмжээ юм.

Тус хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх бэлтгэл, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулах бэлэн байдлыг хангах, дайчилгаа явуулах үндэслэл, журам, энэ талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүлээх үүргийг тогтоож, дайчилгаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан. Уг зорилтын хүрээнд дайчилгаа явуулахад авч хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээнд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах арга хэмжээг оруулсан нь МУ-ын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний зарчим, хэм хэмжээ болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд заасан хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд төрөөс хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй гэсэн зохицуулалттай зөрчилдөж байна.

Иймд дайны нөхцөл байдал үүссэн үед хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг зөрчилдөөнгүй, нэгдмэл байлгах, холбогдох

⁴¹ НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, (УБ, 2022), 155 дахь тал.

хуулийн зорилгод нийцүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хангах үүднээс Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийг хүчингүй болгох нь зүйтэй гэж дүгнэлээ.

3.13. Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
7.4 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ	Практикт нийцэж байгаа байдал
13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох	Зорилгод хүрсэн түвшин
13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх	Практикт нийцэж байгаа байдал
21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах	Зорилгод хүрсэн түвшин

3.13.1. Зорилгод хүрсэн түвшин

13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох
 1. Хүнийг хууль бусаар хорьсон нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47/133 тоот тогтоолоор 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан “Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-д одоогийн байдлаар 98 улс гарын үсэг зурсан ба 72 улс нэгдэн орсон байна. Монгол Улсын хувьд тус олон улсын гэрээнд 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурлаас уг конвенцыг соёрхон батлах тухай хуулийг 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр баталсан юм.

Монгол Улсын Эрүүгийн хуульд хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг гэж **хүнийг хууль бусаар хорьсон** (шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй) гэмт хэргийг ойлгохоор заасан ба үүнийг 13 дугаар бүлэг буюу “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-т хамаарахаар заасан.

Монгол Улс “Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц”-ыг соёрхон баталснаас хойш анхдугаар илтгэлийг 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Хүчээр сураггүй алга болгохын эсрэг НҮБ-ын хороонд хүргүүлсэн билээ. Мөн энэхүү илтгэлийн хүрээнд тус хорооноос хариу болон зөвлөмжийг тус тус ирүүлсэн. Үүний хүрээнд тус хороо Монгол Улсад хүчээр сураггүй алга болгох үйлдлийг **гагцхүү хууль бусаар баривчилсан тохиолдолд хэмээн явцуу тодорхойлсныг анхаарах шаардлагатай** хэмээн үзжээ. Мөн цэрэг, иргэн, төрийн алба, шүүгч, прокурор зэрэг бусдын эрх чөлөөг хязгаарлах, баривчлах, саатуулахад оролцдог аливаа этгээд - хууль сахиулах, аюулгүй байдал, тусгай албадын бүх бие бүрэлдэхүүнд конвенцын зүйл заалтын талаар тусгай сургалт зохион байгуулахыг Монгол Улсад уриалсан байна.⁴²

Мөн Хүчээр сураггүй алга болгохын эсрэг НҮБ-ын хорооны 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн зөвлөмжид Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан

⁴² Хувь заяа нь тодорхойгүй байгаа хүчээр алга болсон хүн болон тэдгээрийн төрөл садны эрх зүйн байдал, сураггүй алга болсонд тооцох журам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, (УБ, 2023), 5 дахь тал.

хүчээр алга болгох гэмт хэрэг нь **Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцид заасан тодорхойлолтоос агуулгын хувьд ихээхэн зөрүүтэй** байгааг анхаарч, тодорхойлолтын конвенцид бүрэн нийцүүлэх чиглэлийг өгсөн байна.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд (Ромын дүрэм) хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж заасан байдаг⁴³.

1998 оны 7 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд заасны дагуу “хүмүүсийг хүчээр сураггүй алга болгох” гэж төрийн болон улс төрийн байгууллага, эсхүл тэдгээрийн зөвшөөрлөөр буюу дэмжлэгтэйгээр хүмүүсийг баривчлах, албадан саатуулах буюу хулгайлах, цаашдаа эрх чөлөөг нь тийнхүү хассаныг хүлээн зөвшөөрөхгүй буюу урт удаан хугацааны туршид хуулийн зүгээс хамгаалалтгүй орхих зорилгоор эдгээр хүний хувь заяа, эсхүл байгаа газрын талаар мэдээлэхээс татгалзахыг хэлнэ. Тус дүрмийн 7 дугаар зүйлийн 1(i) хэсэгт заасны дагуу хүмүүсийг хүчээр сураггүй алга болгох нь энгийн аливаа хүмүүст өргөн хүрээтэй буюу байнга халдах байдлаар санаатай үйлдэж байгаа хэрэг учир хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хамруулахаар заажээ.

Зорилгод хүрсэн түвшин:

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийн 2 дугаар зүйлд заасан конвенцийн зорилгод “хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаархи мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ гэж тодорхойлсон.

Тус гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын гэрээнд заасныг авч үзвэл:

Хүснэгт 4. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн

Конвенцид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг авч үзвэл:	
Объектив шинж: Хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаархи мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр	Объект: Хүн төрөлхтний аюулгүй байдал, эрх тайван
Субъектив шинж: Гэмт буруугийн санаатай хэлбэр.	Субъект: Төрийн төлөөлөгчид эсвэл төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд

Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд заасан “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг авч үзвэл:

⁴³ ICMP, Legal Frameworks and Rights, <https://www.icmp.int/the-missing/legal-frameworks-and-rights/>

Хүснэгт 5. Эрүүгийн хуульд заасан “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн бүрэлдэхүүн.

Эрүүгийн хуульд заасан “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг авч үзвэл:	
Объектив шинж: Хүнийг гадагч гарч явахыг хориглосон үйлдэл байна.	Объект: Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх.
Субъектив шинж: Гэмт буруугийн санаатай хэлбэр.	Субъект: 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай нийтлэг субъект.

Үүнээс үзвэл, 2015 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуульд заасан “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн бүрэлдэхүүн нь Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнээс объект, субъект, объектив шинжээр өөр байна. Тодруулбал, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн нь “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангахгүй буюу хүнийг хууль бусаар хорих гэмт хэргийн шинжийг тусдаа агуулж байна.

Иймд МУ-ын Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийг хуульчлахдаа Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийн зорилгод заасан “хүчээр алга болгох” ойлголтыг агуулаагүй байх тул хуулийн зорилгод хүрээгүй зохицуулалт байна гэж үзэв. Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг тодорхойлохдоо “хүнийг хууль бусаар хорьсон...” гэх үйлдлийг тусгасан байгааг гэмт хэргийн төрөл болгож Эрүүгийн хуульд нэмэлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах

1.Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн зорилгод тусгасны дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд хамаарахгүй.

Энэхүү конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид “Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан **аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэн тэй бүрэн нийцүүлэн тодорхойлох**” гэж зөвлөсөн. Үүнийг Эрүүгийн хуультай харьцуулбал:

Хүснэгт 6. Монгол улсын Эрүүгийн хууль болон НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжийг хангасан байдал

№	НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмж	Монгол Улсын Эрүүгийн Хуулийн 21.12 дугаар зүйлд тусгасан байдал	Хангагдсан байдал
1	аливаа байдлаар алагчилж,	... ялгаварлах зорилгоор...	✓
2	эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх	тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах гэснээр өөр агуулга байхгүй байна.	✗
3	гуравдагч этгээдэд хамааралтай байх	өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж	✓

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүхэд, 2020-2024.03 сар хүртэл хугацаанд Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл заалтаар зүйлчилсэн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 8 хэрэг байна. Үүнд цагдаагийн албан хаагч айлган сүрдүүлэх зорилгоор сэжигтний биед гэмтэл учруулсан хэрэг багтсаныг үзвэл Эрүүгийн хуулийн 21.12 дахь зүйлд хэдий "...айлган сүрдүүлэх зорилгоор" гэх тодотголыг хийгээгүй ч айлган сүрдүүлэх зорилгоор хүнийг эрүүдэн шүүсэн гэж үзэн үүгээр зүйлчилж байгааг илтгэнэ.

Гэхдээ хуулийн үг хэллэг нь нь энгийн, ойлгомжтой, тодорхой томъёологдсон байх шаардлагатай бөгөөд Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй гэсэн хууль ёсны зарчмыг баримтлах шаардлагатай. Иймд Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүүдэн шүүх гэмт хэргийн тодохойлолтод "ялгаварлах" гэдгийн араас "айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх" гэсэн агуулга нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

3.13.2. Практикт нийцэж байгаа байдал

7.4 дүгээр зүйл.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

- 1.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана.
- 2.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана.
- 3.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно.
- 4.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож ял оногдуулна.
- 5.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн хөөн хэлэлцэх хугацаанд эмчлэгдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан бол шүүхээс түүнд оногдуулсан ялаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцон хасаж үлдсэн ялыг эдлүүлнэ.
- 6.Хэрэг хариуцах чадвартай байхдаа ял шийтгүүлсэн ялтны сэтгэцийн эмгэгийг эмчлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд шүүх амбулаторийн албадан хяналтад, эсхүл сэтгэцийн эмгэг судлаачаар эмчлүүлэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно.

7.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно.

8.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх шийдвэрлэнэ.

9.Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дугаар илтгэлд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ба хүний эрхийн асуудал” сэдвээр тусгайлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан байна. Тус илтгэлд Монгол Улсад дараах зөвлөмжийг өгсөн байна.⁴⁴ Үүнд:

- **Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд хууль ёсны төлөөлөгчийн оролцоог хангах**

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй 144 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гарсан байх бөгөөд шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагааг үндэслэж 144 тохиолдлын 51 хүнд холбогдох (35.5%) эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль ёсны төлөөлөгчийг оролцуулаагүй бол 3 хүнд холбогдох хэргийг шийдвэрлэхдээ өмгөөлүүлэх эрхийг хангаж заавал өмгөөлөгч оролцоно гэсэн хуулийн заалтыг биелүүлээгүй байна.

Тохиолдол 1

...Шүүгдэгч О нь үлдэц шизофрени, хий үзэгдэл дэмийрлийн хам шинж сэтгэцийн эмгэгтэй байхдаа 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдөр төрсөн эх 68 настай Л-ийн толгой, нүүрэн тус газар олон удаа заазуурдаж, цээж, нуруу, гар хэсэгт олон удаа зүсэж, хутгалж онц харгис хэрцгийгээр, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж алсан гэмт хэрэг үйлдсэн. Шүүхээс О-д 8 жилийн хугацаагаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тусгай тасагт эмчлүүлэхээр тогтоосон. Шүүх хуралдаанд түүний хууль ёсны төлөөлөгч оролцоогүй, өмгөөлөгч оролцсон байна.

(Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 10 дугаар сарын 02-ны №1036 шийтгэх тогтоолоос)

- **Төрөл, дэглэм, хугацаа тогтоож буй байдал**

Судалгаанаас үзэхэд, цөөн тохиолдолд шинжээч эмч шүүхийн хэлэлцүүлэгт оролцож эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хугацааны талаар санал гаргасан байх ба ихэнх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар албадан эмчлэх хугацааг тогтоосон бол зарим шүүхийн шийдвэрт албадан эмчлэх хугацааг тогтоогоогүй байна. 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт 39 хүнд шүүхийн шийдвэрийн дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэн албадан эмчилж байгаа хэдий ч дээрх 39 хүний 13 буюу 33.3 хувьд нь ямар хугацаагаар албадан эмчлэхийг шүүх шийдвэртээ тусгаагүй бол 26 хүнд 1 сараас 8 жил хүртэл хугацаагаар уг арга хэмжээг хэрэглэхээр шүүхийн шийдвэрт тогтоожээ. Түүнчлэн шүүхийн шийдвэрээр тогтоосон хугацаанд сэтгэцийн байдал нь засрал сайжрал олоогүй, эдгэрээгүй бол

⁴⁴ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дугаар илтгэл, Хүний эрхийн үндэсний комисс, (УБ, 2023), Холбоос: https://www.uih.mn/upload/sudalqaa/files/256_1026708.pdf, Сүүлд үзсэн огноо: 2024.05.06.

тухайн этгээдэд хэрэглэсэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг хэрхэн тогтоож, ямар хугацаагаар сунгах нь тодорхойгүй байна. Тухайлбал: шүүхээс хугацааг тогтоогоогүй 13 хүнийг засрал сайжрал олоогүй үндэслэлээр 5-20 жилийн хугацаагаар тус байгууллагад үргэлжлүүлэн албадан эмчилж байна⁴⁵.

Монгол Улсын хэмжээнд, шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн хүнийг Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд албадан эмчилж байна. 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг... шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана”⁴⁶ гэж хуульчилсан.

Уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд, тухайлбал хэрэгжүүлэгч байгууллага, алба хаагчдын аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл байдалд хүндрэл, бэрхшээл нэлээд тулгамдаж байна. Тухайлбал, хүнд гэмт хэрэг үйлдсэн хүнийг ердийн тасагт, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгай тасагт албадан эмчлэхээр тогтоосон байх бөгөөд ямар үндэслэлээр ердийн болон тусгай тасагт албадан эмчлэхээр шийдвэрлэснийг шүүхийн шийдвэрт тусгадаггүй байна.

Цаашид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзаж ямар төрлийн эмнэлэгт эмчлэх талаарх зохицуулалтыг ЭХ, ЭХХШТХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нарийвчлан зохицуулах нь Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжийг хязгаарлах⁴⁷, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. Тухайлбал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгт байлгах арга хуульчилж байсан туршлага⁴⁸ бий⁴⁹.

⁴⁵ Дам ишлэв. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/564 дүгээр албан бичиг.

⁴⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он, www.legalinfo.mn

⁴⁷ Анхан шатны шүүхүүд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг өөр өөр нэр томъёо хэрэглэн тогтоож байна. Тухайлбал: анхан шатны зарим шүүх шийдвэртээ албадан эмчлэх байгууллагыг “Донтох эмгэгийн клиник”, “Сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлийн тасаг”, “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн энгийн дэглэмд”, “Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагын энгийн тасаг”, “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэц эмгэг судлалын ердийн эмнэлэг” гэж тус тус заажээ.

⁴⁸ 2002 оны Эрүүгийн хуулийн 66 дугаар зүйл 66.1 дэх хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно” гэж, мөн зүйлийн 2, 3 дахь хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгт байлгах арга хуульчилсан нь оновчтой зохицуулалт байсан.

⁴⁹ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дугаар илтгэл, Хүний эрхийн үндэсний комисс, (УБ, 2023), 58 дахь тал, Холбоос: https://www.uih.mn/upload/sudalгаа/files/256_1026708.pdf, Сүүлд үзсэн огноо: 2024.05.06.

- Орчин нөхцөл, стандарт

Монгол Улсын хэмжээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник нь шүүхийн шийдвэрээр хэрэг хариуцах чадваргүй хүнд авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэн, тусламж үйлчилгээг үзүүлдэг бөгөөд байрны хүртээмж, стандартын шаардлага хангасан өрөө, тасалгаагүйгээс албадан эмчлэгдэж буй хүний эрх зөрчигдөж байна.

Гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдэд авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт хэрэглэж байгаа бөгөөд харуул хамгаалалтыг ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны Баривчлах төвийн алба хаагчид хариуцан өдрийн цагаар 1 ахлах ажилтан, 2 алба хаагч, шөнийн цагт 2 алба хаагч хяналт тавин ажилладаг. Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт эмчлэгдэж байгаа хүний ихэнх нь хүнд гэмт хэрэг үйлдэн албадан эмчилж байгаа, мөн тус клиникт шүүгчийн захирамжаар Шүүх, сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийхэд тодорхой хугацаагаар хэвтүүлж, хяналтад байлгах, ажиглалт хийлгэхээр ирсэн шинжлүүлэгч мөн хэвтдэг. Албадан эмчлүүлж буй сэтгэцийн архаг даамжрах явц бүхий солиорох эмгэгтэй хүнд харилцааны өндөр ур чадвар, хурц сонор сэрэмж, тасралтгүй хараа хяналт шаардлагатай төдийгүй сэтгэцийн эмгэгийн тухай ерөнхий ойлголттой, туршлагатай албан хаагч хяналт тавих нь нэн чухал байдаг.

Албадан эмчлүүлэгч нарт эмч үзлэг хийх, эмчилгээ, шинжилгээнд гадагш авч явах, эмчлүүлэгч нарт эргэлт ирэх, тэднийг нийтэд нь хоолонд оруулах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, гадагш агаарт гаргах зэрэгт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид хүрэлцдэггүйгээс дээрх эмчлүүлэгчид бусдын биед халдах, өөртөө болон бусдад хохирол учруулах өндөр эрсдэлтэй байдаг тул хяналт тавих алба хаагчдыг чадавхжуулах, тэдний тоог нэмэгдүүлэх шаардлагатай болсон байна.

- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дараа үзүүлэх дэмжлэг

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиникт эмнэлгийн чанартай албадан арга хэмжээ хэрэглэх, эмчилгээний хугацаа дууссан хэдий ч гэр оронгүй, асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, асран хамгаалах хүнтэй боловч асрамждаа авах хүсэлт гаргаагүй зэрэг шалтгаанаар үргэлжлүүлэн эмчлэгдэж байгаа хүмүүс байна. Тус төвд албадан эмчлүүлж байгаа 39 хүний 5 нь үргэлжлүүлэн эмчлэх шаардлагагүй гэж шинжээч эмчийн дүгнэлт гаргаж, шүүхээс уг арга хэмжээг зогсоох шийдвэр гаргасан хэдий ч тус төвд үргэлжлүүлэн албадан эмчлэгдсээр байгаа юм.⁵⁰

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт “Асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй эмчлүүлэгчийг албадан эмчилгээ дууссаны дараа сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь холбогдох байгууллагад хүсэлтээ гарган асуудлыг шийдвэрлэж ажиллана” гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Тохиолдол 2

⁵⁰ Дам ишлэв. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/564 дүгээр албан бичиг.

...Албадан эмчлүүлэх хугацааг шүүхийн шийдвэрт заагаагүй, хугацаа заасан ч асран хамгаалах харгалзан дэмжих хүнгүй, холбогдох баримт материал дутуу гэх шалтгаанаар эмнэлгээс гаргахгүй байгаа асуудлыг СЭМҮТ дангаараа шийдвэрлэх боломжгүй, тогтолцооны шинжтэй, хүний эрхийн асуудал бөгөөд нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.

(ХЭҮК-ын гишүүний 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 3/46 дугаар шаардлагаас)

... 20-25 жил эмчлүүлж буй эмчлүүлэгчид мөн байлаа. Тэдэн дундаас эмнэлгээс гаргах боломжтой 120 хүн байгаа гэдгийг Ажлын хэсэг олж мэдсэн. Гэсэн хэдий ч нийгэм, хамт олонд түшиглэсэн тусламж үйлчилгээ байхгүй, мөн тэдгээр хүмүүсийг харж хандах, тусламж, дэмжлэг үзүүлэх гэр бүл, төрөл садан байхгүй учраас тус төвөөс хэзээ гарах нь тодорхойгүй байсаар байна. Цаашид үүнтэй адил асрамжийн үйлчилгээ болон нийгэм, хамт олонд түшиглэсэн тусламж үйлчилгээг илүү өргөжүүлж, Монгол Улсын 21 аймагт нэвтрүүлэхийг Ажлын хэсэг зөвлөж байна.

(НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн урьдчилсан дүгнэлтээс)

СЭМҮТийн зүгээс гэр бүл нь асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу татгалзсан эмчлүүлэгчийг асран хамгаалагчаар тогтоогдож, тэднийг асрамжийн болон боломжтой тохиолдолд гэр клиникт шилжүүлж, хэвийн нөхцөлд амьдрах боломжийг хангах, эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд санаачилгатай ажиллах, гэр бүлээс нь асран хамгаалах, харгалзан дэмжих хүсэлтээ илэрхийлсэн 10 эмчлүүлэгчийг гэр бүлд нь өгөхөд холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.⁵¹

Иймд Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд холбогдох 9 хэм хэмжээ нь хангалтгүй зохицуулалт байх тул эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацаа, төрөл, өөрчлөх, зогсоох байдал зэргийг нарийвчлан тусгах шаардлагатай.

13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх

1. Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Монгол Улсын 2021 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулийн 8 дугаар зүйлд албадан хөдөлмөрийг хориглосон байдаг⁵². Мөн 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 13.13-т албадан хөдөлмөрлүүлэхийг гэмт хэрэгт тооцож, торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заажээ.

Эрүүгийн хууль (2015)-ийн 13.13-т дээрх байдлаар зааж, цалин хөлсгүй гэдгийг албадан хөдөлмөрлүүлсэн гэмт хэргийг тодорхойлох нэг элемент болгосон нь конвенцийн 25 дугаар зүйл, протоколын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу эрүүгийн

⁵¹ Дам ишлэв. ХЭҮК-ын гишүүний 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 3/46 дугаар шаардлага.

⁵² Хөдөлмөрийн тухай хууль (2021), 8 дугаар зүйл.

хэрэг гэж үзэж, ял шийтгэвэл зохих хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хүрээг хэт явцууруулсан байна.⁵³

Монгол Улс ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29-р конвенцийг 2005 онд соёрхон баталсан бөгөөд үүнд албадан хөдөлмөрийг “ямар нэг торгууль шийтгэл ногдуулахаар заналхийлж аливаа иргэнээс өөрийгөө сайн дураар санал болгоогүй байхад шаардах аливаа ажил, үйлчилгээ” хэмээн тодорхойлсон байдаг. Энэхүү тодорхойлолтод хамаарахгүй тохиолдлууд:

- заавал хаах хугацаат цэргийн алба;
- иргэний ердийн үүрэг; шүүхээр ял шийтгэсэн;
- онцгой байдлын нөхцөлд;
- хамт олон, бүлгийн хэрэгцээний жижиг ажил, үйлчилгээ.

Учирч болзошгүй аюул заналхийлэл нь бие махбодь, сэтгэл санаа, санхүү болон бусад хэлбэрээр илэрч болох бөгөөд цалин хөлс олгохгүй байх, хөдөлгөөнийг хязгаарлах, бие махбодийн хүчирхийлэл хэрэглэх, хувь хүний эрх, боломжийг хясан боогдуулах, ажлын муу нөхцөлд шилжүүлэх болон хууль бус цагаачлагчдыг холбогдох байгууллагуудад мэдээлэх зэрэг олон арга хэлбэрээр илэрдэг.

Түүнчлэн, албадан хөдөлмөрийг сайн дурын үндсэн дээр ажиллахгүй байх, дарамт шахалт үзүүлэх, хуурч мэхлэх зэрэг шинжээр тодорхойлох нь хэт хязгаарлагдмал бөгөөд нарийн тодорхойлохын тулд илүү өргөн хүрээнд авч үзэхийг шаарддаг. Тухайлбал, өрөөр барьцаалах, ажилтны бичиг баримтыг барьцаалах зэрэг бусад хэлбэр хамаарна. Эдгээр нөхцөл нь ажилд ороход (хохилогч өөрийн хүсэл зоригийн эсрэг ажиллах), эсвэл явцын дунд (хохилогч ажлаасаа гарч чадахгүй, эсвэл тодорхой хугацаанд цалин, хангамж хүртэж чадахгүй байх) үүсч болно.⁵⁴

Иймд Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд цалин хөлсгүй гэдгийг албадан хөдөлмөрлүүлсэн гэмт хэргийг тодорхойлох нэг шинж болгосон нь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хүрээг хэт явцууруулсан байх тул “ямар нэг шийтгэл ногдуулахаар заналхийлэх; аливаа иргэний хүсэл зоригийн эсрэг гэх мэт шинжийг нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

3.14. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	13 дугаар зүйл. Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа	Зорилгод хүрсэн түвшин
2.	13 дугаар зүйл. Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа	Практикт нийцэж байгаа байдал

⁵³ ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай конвенц(1930)-ийн 2014 оны протоколд нэгдэн орох боломжийн талаарх танилцуулга, Холбоос: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/meetingdocument/wcms_750284.pdf, Сүүлд үзсэн огноо: 2024.04.22.

⁵⁴ Монгол Улсын бодлогын хураангуй: Албадан хөдөлмөр, (УБ, 2016), 2 дахь тал, Холбоос: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_508368.pdf, Сүүлд үзсэн огноо: 2024.04.22

3.14.1. Зорилгод хүрсэн түвшин

13 дугаар зүйл.Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа

13.4.Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.” гэж заасан. Уг заалт нь тус хуулийн 5.6 дугаар зүйлээс улбаатай бөгөөд 2000 оны зохицуулалтаас ялгаатай нь Комиссын даргын бүрэн эрхийн хугацаа нь өөрчлөгджээ.⁵⁵

2000 оны Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль	2020 оны Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль
5.6. Комиссын даргыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Комиссын гишүүдээс Улсын Их Хурал гурван жилийн хугацаагаар томилно.	13 дугаар зүйл.Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 13.4.Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.

Ийнхүү Комиссын даргыг Улсын Их Хурлын даргын саналаар томилох нь Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус байдалд нөлөөлөхөөр байна гэж үзэж байна. Учир нь Улсын Их Хурлын даргын зүгээс Комиссын даргыг Улсын Их Хуралд санал болгохдоо тус комиссын гишүүдийн боловсрол, ур чадвар зэргийг харгалзахгүйгээр, өөрийн үзэмжээр санал болгох нөхцөл бүрджээ.

Түүнчлэн, комиссын даргыг Улсын Их Хурлын даргын санаачилгаар буюу үзэмжээр томилох нь комиссын үйл ажиллагаанд баримтлах хараат бус, бие даасанбайх зарчимд харшилж байна. Тухайлбал, комиссын дарга нь Комисст ирсэн гомдол, мэдээллийг шийдвэрлүүлэхээр Комиссын гишүүдэд хуваарилах; Комиссын хуралдааныг товлож, удирдан хуралдуулах зэрэг эрх, үүрэгтэй бөгөөд эдгээр бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх нь Улсын Их Хурлын даргаас хамаарч болзошгүй байна.

Мөн Комиссын даргын бүрэн эрхийн хугацаа зургаан жил байгааг ажлын үр дүнгээс хамаарахаар тусган, бүрэн эрхийн үндсэн хугацааг 3 жил болгож, 3 жилээр сунгахаар зохицуулах нь зүйтэй.

Иймд, Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.” гэснийг Комиссын даргыг гишүүд дотроосоо нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар томилж, даргын ажлын тайланг үнэлсний үндсэн дээр бүрэн эрхийн хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх боломжтой.

3.14.2. Практикт нийцэж байгаа байдал

⁵⁵ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, 2000 он, (2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн хүчингүй болсон.)

13 дугаар зүйл. Комиссын дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа
13.6. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно.

Монгол Улсын Их Хурлаас Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр баталж, 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж дагаж мөрдөж эхэлснээр Монгол Улсад хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизм бий болсон. Комисс нь уг хуулийн хүрээнд хүний эрх хамгаалагчийг хамгаалах хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байна. Уг хуульд зааснаар Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсэн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо ажиллах бөгөөд Хороо нь даргаас гадна 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тус Хороог Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн даргаар ажиллахаар зохицуулсан.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт "Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн "Хүний эрх хамгаалагчийн хороо"-ны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана" гэж, 13.6 дахь хэсэгт "Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно" гэж тус тус заажээ.

Гэтэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт "Комиссын гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна: мөн зүйлийн 12.2.1-д "хууль зүйн өндөр мэргэшилтэй", мөн зүйлийн 12.2.2-д "хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай" гэсэн ерөнхий шаардлагыг хуульчилсан байна. Харин Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд дараах шаардлагыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ", мөн зүйлийн 11.1.1-д "хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай", мөн зүйлийн 11.1.2-т "хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм хэмжээний талаар мэдлэг, туршлагатай", мөн зүйлийн 11.1.3-т "сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй" гэж, мөн зүйлийн 11.6 дахь хэсэгт "Хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаасонгоно" гэж тусгай шаардлагыг хуульчилсан байдаг.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх" зарчим, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн зарчмыг хөндөж, хууль хоорондын зөрчлийг үүсгэж байна.

Ийнхүү Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсэн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны дарга, гишүүнд тавигдах шаардлагыг эрхэлсэн ажил, албан тушаал, мэдлэг туршлага, цаг хугацаагаар нь ялгамжтайгаар хуульчилсан нь иргэдийн төрдөө итгэх итгэлийг алдагдуулах төдийгүй хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж

болзошгүй юм. Иймд хууль хоорондын зөрчлийг арилгаж, уялдаа холбоог хангах шаардлага үүссэн болно.

Монгол Улс нь Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан Ази тивдээ анхны улс орон болсон гэдгээрээ онцлог бөгөөд уг хуулийн хэрэгжилтийг хангахад Комиссын нэг гишүүн мэргэшиж дагнан хариуцах нь шинэ механизм, бүтцийн үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдаж, бүс нутаг төдийгүй олон улсад сайн жишиг болох давуу талтай гэж үзэж байна.

3.15. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур
1	31 дүгээр зүйл. Аюулын зэргийн үнэлгээ	Зорилгод хүрсэн түвшин
2	31 дүгээр зүйл. Аюулын зэргийн үнэлгээ	Практикт нийцэж байгаа байдал

3.15.1. Зорилгод хүрсэн түвшин

31.1. Цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн..." гэж, Арван зургаадугаар зүйлд "...аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй", "Гэр бүл, эх, нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй." гэж тус тус заасан.

Үндсэн хуульд заасан хүний эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор анх 2004 онд Монгол Улсын Их Хурлаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай бие даасан хуулийг баталж, гэр бүлийн хүчирхийллийг хүний эрхийн зөрчилд тооцдог болсон. Тус хуулийн шинэчилсэн найруулга 2016 онд батлагдаж, 2017 оны 02 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлжээ. ГБХТХ-ийн шинэчлэлд хамаарах зарчмын томоохон өөрчлөлтүүдийн нэг нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх процессыг тодруулснаас гадна, гэр бүлийн хүчирхийллийг иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил болохыг хуульчилсан явдал юм.⁵⁶ Мөн гэр бүлийн гишүүд, хамтран амьдрагч, асран хамгаалагч, үрчлэн авсан хүүхэд, эцэг эх болон салсан хосууд зэргийг хуульд хамруулж, хүчирхийллийн

⁵⁶, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Хүний эрхийн тайлан, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв, УБ, 2014.

тодорхойлолтыг илүү өргөжүүлэн сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн хүчирхийллийг хуульд тусгасан гэдгээрээ өмнөх оны хуулиас онцлогтой.⁵⁷

2016 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /цаашид “ГБХТТХ” гэх/-ийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино” гэж заасан. Тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т заасны дагуу цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил, гэмт хэрэгт аюулын зэргийн үнэлгээ хийснээр хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан болон учирч болохуйц эрсдэлийн түвшинг үнэлж, аюулгүй байдлыг нь хамгаалах арга хэмжээ авах зорилготой тул уг зохицуулалт тус хуулийн зорилгод нийцсэн байна. Гэхдээ аюулын зэргийг үнэлэх ажиллагааг нарийвчлах, тухайлбал насанд хүрээгүй, монгол хэл, бичиг мэдэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээ шаардлагатай хүний тухайд аюулын зэргийг үнэлэхэд баримтлах зарчим, стандарт, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн бусад мэргэжилтнийг оролцуулах шаардлага зэргийг тусгах нь зүйтэй. Ингэснээр тус хуулийн зорилго дахь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоохын зэрэгцээ хүчирхийлэлд өртсөн этгээдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, улмаар урьдчилан сэргийлэх зэрэг цогц асуудлын эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

3.15.2. Практикт нийцэж байгаа байдал

31.1. Цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ.

ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим заавар, журмуудыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас батлан хэрэгжүүлж, хохирогчдыг хамгаалан байрлуулах, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх гэх мэт олон ахицтай алхмуудыг хэрэгжүүлсээр байгаа боловч зөрчил, гэмт хэргийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

Тодруулбал, 2015-2017 онд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо 26358 байсан бол, 2018-2020 онд 89487 болж, 29%-иар өссөн. Энэ тоо нь хүний эрүүл мэнд хохирсон гомдол, мэдээллээс 19253-аар илүү байна.⁵⁸ Мөн 2022 онд энэ төрлийн гомдол, мэдээлэл 1729 бүртгэгдэж, өмнөх оны үеэс 198 буюу 12.9%-иар өсжээ. Үүнээс нийт 1664 хүн хохирогчоор тогтоогдсон бөгөөд тэдгээрийн 1468 буюу 88.2% нь эмэгтэй, 177 буюу 10.6% нь хүүхэд ба уг гэмт хэргийн улмаас нийт 1915.1 сая төгрөгний хохирол учирсан байна.⁵⁹

⁵⁷ Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, Монголын Криминологичдын Холбоо, УБ, 2018, 6 дахь тал.

⁵⁸ Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, Цагдаагийн ерөнхий газар, УБ, 2021, 2 дахь тал.

⁵⁹ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022, Цагдаагийн ерөнхий газар, УБ, 2023, 27 дахь тал.

ГБХТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-т зааснаар цагдаагийн алба хаагч нь ирүүлсэн дуудлага, мэдээллийн дагуу хохирогчийн байгаа газарт очиж аюулын зэргийн үнэлгээ хийх бөгөөд тус үнэлгээнээс гадна хохирогчийн хүсэлт, нийгмийн ажилтны хийсэн нөхцөл байдлын үнэлгээ, хамтарсан багийн шийдвэр зэргийг үндэслэн хохирогчийг түр хамгаалах байранд байрлуулдаг. Өөрөөр хэлбэл аюулын зэргийн үнэлгээ нь тухайн хохирогч хүчирхийлэл үйлдэгчтэй хамт нэг орчинд байгаа нь түүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюултай эсэхийг тогтоох чухал ач холбогдолтой юм.

Аюулын зэргийн үнэлгээг дараах 3 түвшинд авч үздэг. Үүнд:

- *Бага түвшин* гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийн зөвшөөрөлгүй уулзах, харилцаа тогтоохыг оролдсон, сэтгэл санааны дарамтад оруулсан, хүүхдийн хүмүүжилд хохирол учруулсан, эдийн засгийн дарамтад оруулсан нөхцөл байдлыг ойлгоно.⁶⁰
- *Дунд түвшин* гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүдийг айлган сүрдүүлсэн, дарамталсан, дагаж мөшгисөн, ятгасан байдлыг ойлгоно.⁶¹
- *Өндөр түвшин* гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийн амь насанд бодитой заналхийлсэн, бие махбодид гэмтэл учруулсан, эсхүл учруулж болзошгүй, хүчирхийлэл даамжирсан, байнгын дарамтад байлгасан, хүчирхийлэл үйлдэгч нь гадны биет буюу галт зэвсэг хэрэглэдэг, эсхүл хэрэглэж болзошгүй болон ГБХТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлыг ойлгоно.⁶²

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх тусгайлсан журам”-ын дагуу цагдаагийн алба хаагч нь насанд хүрсэн хүн болон хүүхэд гэсэн ангиллын хүрээнд үнэлгээ хийх ба тус бүр 20 асуулт бүхий мэдээллийг, хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй хамт гараар бичиж, тэмдэглэл хөтлөн хохирогчоор гарын үсэг зуруулж, баталгаажуулдаг.

Аюулын зэргийн үнэлгээ хийсэн тэмдэглэлийн үр дүнд цагдаагийн алба хаагч тухайн хүчирхийлэлд өртөж, хохирсон иргэний эрсдэлийн түвшинг үнэлж, хохирогчид үзүүлэх үйлчилгээнд хамруулах, цаашлаад тус тэмдэглэлийг нотлох баримтад тооцох, үнэлэх боломжтой юм.

Дээрх журмын хэрэгжилттэй холбоотойгоор 2018 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт” мониторингийн тайлан судалгаа хийгдэж байсан бөгөөд цагдаагийн байгууллага, алба хаагч болон гэр бүлийн хүчирхийллийн дуудлагатай холбоотой тусгайлан бэлтгэгдсэн мэдээлэл цуглуулагчид оролцож, чанарын аргаар олж авсан анхдагч мэдээлэл болон энэ чиглэлээр өмнө хийгдэж судалгаа, бодлогын баримт бичигт анализ хийсэн хоёрдогч мэдээллүүдэд үндэслэн дараах дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

⁶⁰ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, 2.5 дахь заалт.

⁶¹ Мөн тэнд, 2.6 дахь заалт.

⁶² Мөн тэнд, 2.7 дахь заалт.

- Хууль хэрэгжиж эхлэхтэй зэрэгцүүлэн холбогдох журам, стандартыг батлан мөрдүүлсэн нь сайшаалтай хэдий ч зарим журмын зохицуулалт нь төдийлөн оновчтой бус, чухал зохицуулалтыг орхигдуулсан, хэрэгжүүлэн ажиллахад бэрхшээлтэй зэрэг дутагдал байна. Тухайлбал, Аюулын зэргийн үнэлгээ хийх журам.
- Цагдаагийн алба хаагчаас гэр бүлийн хүчирхийллийн дуудлагыг үл ойшоох, ноцтой гэж үзэхгүй байх, гомдлоо заавал бичгээр гаргахыг шаардах зэргээр хохирогчид чирэгдэл учруулах тохиолдол цөөнгүй бий болж байгаагаас гадна урьдчилан сэргийлэх, дахин давтагдах эрсдлийг бууруулах, эргэж хяналт тавих ажиллагаа хангалтгүй хийгдэж байна.⁶³
- Аюулын зэргийн үнэлгээг хуульд заасан үндсэн зорилгын дагуу биш нотолгооны хэрэгсэл буюу хүчирхийлэл үйлдэгдсэн эсэх, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох нотлох баримт болгон ашиглах болсон нь цагдаагийн байгууллагад цаг хугацаа, санхүүгийн нөөц, шуурхай ажиллах боломжид сөргөөр нөлөөлж байна.⁶⁴

2017 онд батлагдсан аюулын зэргийн үнэлгээ хийх журмыг 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн ХЗДХ-ийн сайдын А/58 тушаалаар өөрчлөн шинэчилсэн ба хэт нуршуу байхаас сэргийлэхийн тулд 20 асуулт байсныг 11 болгон өөрчилж, ноцтой гэх 3 асуултын аль нэгэнд нь 'тийм' гэж хариулсан бол хохирогчийг шууд хамгаалалтад авахаар заасан байна. Тус журам хэрэгжиж эхэлсэн 3 жилийн хугацаанд журмын хэрэгжилттэй холбоотой дараах судалгааны ажлууд хийгдсэн бөгөөд дор дурдсан үр дүн гарчээ. Тухайлбал,

1. “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь”, 2021 он

Уг судалгааны ажил нь гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой 'хохирогч төвтэй' хандлагыг хэрэгжүүлж буй байдалд үнэлгээ хийх, зөвлөмж гаргах зорилготой бөгөөд холбогдох хууль, журмууд дээр үндэслэн социологийн судалгаа хийх, түүвэрлэлтийн аргаар хавтаст хэргүүдийг цуглуулж, тэдгээрт дүгнэлт өгөх, статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тоо мэдээлэл цуглуулах гэх мэт аргуудыг ашиглан аюулын зэргийн үнэлгээтэй холбоотой дараах дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн ихэнх тохиолдолд хүний бие махбодид ноцтой гэмтэл учруулахыг таслан зогсоох үүднээс цагдаа дууддаг. Судалгаанд хамрагдсан хохирогчдын 83.3% нь цагдаагийн байгууллагыг гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийг хамгаалах эрх бүхий гол байгууллага гэж тодорхойлсон. Мөн гурван хохирогч тутмын нэг нь хууль хяналтын байгууллагад гаргасан гомдолоо бүрэн шийдвэрлүүлж эерэг нөлөөлөл мэдэрсэн бол дийлэнх хохирогчдийн хувьд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хэвээр буюу улам дордсон байна. Иймд цагдаагийн байгууллагын зүгээс гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хүлээн авах, гомдол хянан шийдвэрлэх байдал, аюулын зэргийн

⁶³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, УБ, 2018, 58 дахь тал.

⁶⁴ Мөн тэнд, 59 дахь тал.

үнэлгээ хийх, гомдлын дагуу мөрдөн шалгах, хохирогчтой харилцах байдал гэх мэт олон зүйлсүүдийг сайжруулах шаардлагатай байна.⁶⁵

- Дуудлагаар ирсэн цагдаагийн албан хаагч нь аюулын зэргийн үнэлгээ хийсний үндсэн дээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс цагдаагийн алба хаагчид хэргийн газарт аюулын зэргийн үнэлгээ хийсэн эсэх талаар асуухад ердөө 42.2% нь тийм гэж хариулсан байна.⁶⁶
- Мөн судалгаанд оролцогчдын 70 гаруй хувь нь цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа болон хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалж буй хандлагад 'сэтгэл хангалуун бус' гэж хариулсан бөгөөд тэдний нийгэм, эдийн засгийн байдал, хөрөнгө чинээг нь харж, ялгаварлан гадуурхдаг гэж үзжээ.

2. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ”, 2023 он

Судалгааны ажлын хүрээнд нийт 25 шалгуур үзүүлэлтийг тодорхойлж холбогдох статистик мэдээлэл, тайлан, судалгаа зэргийг цуглуулах байдлаар ГБХТХ-ийн 1-5 бүлгийн 44 зүйлийн 76 хэсэг, 162 заалтад үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.

ГБХТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3-т заасны дагуу 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн ХЗДХ-ийн сайдын А/58 тушаалаар аюулын зэргийн үнэлгээ хийх журмыг өөрчлөн шинэчилсэн. Дээрх судалгааны ажлын хүрээнд тус журмын хэрэгжилтийг судалж, аюулын зэргийн үнэлгээ хийхэд тулгамдаж буй асуудлыг тодруулахаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий 44 цагдаагийн алба хаагчаас асуумжийн дагуу судалгаа авчээ. Асуумжийн дүнг нэгтгэсэн хүснэгтийг дор үзүүлэв.

Хүснэгт 1. Аюулын зэргийн үнэлгээний талаарх Цагдаагийн алба хаагчдын оролцсон асуумжийн хариултыг нэгтгэсэн байдал

Асуумжийн асуултын талаар	Асуумж хэт урт, нуршуу, оновчтой биш
	Хэтэрхий хүнд асуулт байдаг учраас зарим иргэн хүчирхийлэлд огт өртөж байгаагүй мэт судлагддаг
	Үнэлгээний асуумж дутуу. Зөвхөн эмэгтэй хүнд зориулсан асуулттай
	Зарим асуулт нь тохиромжгүй байдаг
	Асуултууд оновчтой бус богино үгээр тодорхой байх яаралтай үед нуршсан асуулттай
	АЗҮ-ний Эхний 3 асуулт учир дутагдалтай, хүүхдэд хийх үнэлгээний маягт тусдаа байх шаардлагатай
	Насанд хүрсэн хүн, хүүхэд 2 маягт өөр байвал зүгээр санагдсан.

⁶⁵ Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь, Монгол улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл, УБ, 2021, 27 дахь тал.

⁶⁶ Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь, Монгол улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл, УБ, 2021, 28 дахь тал.

Асуумжийн дутагдалтай тал	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд АЗҮ хийхэд тохиромжгүй асуулттай. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд АЗҮ бөглөхөд арай өөр хэлбэрээр байвал зүгээр байна.
	Шүүх хуралдааны явцад бүрэн нотлох баримт болж чаддаггүй.
Сайжруулах талаар санал	Асуумжийн эхний хэсэгт төрсөн хүүхэд, дагавар хүүхдийн ялгамжийг оруулж өгөх хэрэгтэй.
	АЗҮ-г цахим санд бүртгэдэг болох
	Насанд хүрсэн, насанд хүрээгүй гэж 2 тусдаа салгаж асуулт асуух зарим асуулт нь хүүхдүүдээс асуухад хүүхэд ойлгохгүй хүнд хэцүү байдаг
	Бага насны хүүхэд хийхэд асран хамгаалагчгүй хийдэг болох
	АЗҮ хийх журмыг боловсронгуй болгох, одоо ашиглаж байгаа АЗҮ нотлох баримтын шаардлага хангахгүй байгаа.
	Маягтад тусгагдсан асуултуудад хүчирхийлэл үйлдэгдэж байсан хугацааг тусгаж өгөх.
	Дуудлагад хамгийн түрүүнд очсон алба хаагч газар дээр нь АЗҮ хийхэд ихэнхдээ хүндрэлтэй байдаг. Дийлэнх тохиолдолд холбогдогчийг тусгаарлах, саатуулах хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлага гардаг. Мөн АЗҮ хийнэ гээд зодуулсан хохирогчийг байлгаад байж болдоггүй, аль болох шуурхай хариу арга хэмжээ авах, холбон зуучлах /эмнэлэгт хүргэх/, бага насныхныг харгалзах хүнд хүлээлгэн өгөх зэрэг ажил нь чухал байдаг. Бас ГБХ-ийн хохирогч, холбогдогч нь заавал эхнэр нөхөр, хамтран амьдрагч байх албагүй тул дундаасаа хүүхэдтэй эсэх гэх мэт асуулт илүүц санагдана. АЗҮ-г үндэслэж ТХБ-ны үйлчилгээ шаардагддаг, АЗҮ нь шүүхэд нотлох баримт гэж үздэг тул хохирогчоор гарын үсэг зуруулж албажуулах шаардлагатай.
АЗҮ-ний өгөгдсөн асуултад тийм гэсэн тохиолдлуудыг тодруулж мэдүүлэг авах нь шийдвэрлэлтэд маш чухал ач холбогдолтой байдаг. Харин нөхцөл байдал, дүгнэлт санал, цаашид авах арга хэмжээ зэрэг бичвэр хэсгийг бөглөх гэж мэдүүлэг авах хэмжээний, цаг шаардсан ажил болдог тул эдгээр хэсгийг хариултыг нь зөвлөдөг /чеклэдэг/ асуумж хэлбэртэй болговол арай хялбар болно.	

Цагдаагийн алба хаагчдын өгсөн мэдээллээс үзэхэд аюулын зэргийн үнэлгээг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага, мэдээлэл бүрд хийх боломжгүй бөгөөд гэмт хэргийн нөхцөлөөс шалтгаалан дийлэнх тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах, саатуулах, хохирогчийг холбон зуучлах гэх мэт хойшлуулшгүй ажиллагаа хийх шаардлага гардаг тул аюулын зэргийн үнэлгээний зарим асуултыг шинэчилж, шаардлагагүй хэсгийг хасах, бага насны хүүхдээс асуухад тохиромжтой байхаар хялбаршуулах, ангилах шаардлагатай байгаа талаар дурдсан байна.

Мөн аюулын зэргийн үнэлгээг хуульд заасан урьдчилан сэргийлэх үндсэн зорилгын дагуу биш нотолгооны хэрэгсэл буюу хүчирхийлэл үйлдэгдсэн эсэх, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох нотлох баримт болгон ашиглаж байгаа нь цаг хугацаа, санхүүгийн нөөц, шуурхай ажиллах боломжид

сөргөөр нөлөөлж байгаагаас гадна хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байна⁶⁷ гэх судалгааны дүгнэлт гарчээ.

Ийнхүү цагдаагийн алба хаагчид гэмт хэргийн нөхцөлөөс шалтгаалан дийлэнх тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа хийх шаардлага гардаг тул аюулын зэргийн үнэлгээг гэмт хэргийн тохиолдол бүрд хийх боломжгүй байдаг. Тухайлбал, ХЗДХ-ийн сайдын 2020 оны А/58 дугаар тушаалаар баталсан аюулын зэргийн үнэлгээ хийх журмын дагуу 2021 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд хамрагдсан хүмүүсийн 42.2%-д аюулын зэргийн үнэлгээ хийсэн байна. Иймээс хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах, саатуулах, хохирогчийг холбон зуучлах гэх мэт хойшлуулшгүй ажиллагаа хийх болсон тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг хэрхэн хийх тухай зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгах, үнэлгээний зарим асуултыг шинэчлэх, хасах, бага насны хүүхдээс асуухад тохиромжтой байхаар хялбаршуулж, ангилах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нь ихэвчлэн далд хэлбэрээр үйлдэгддэг, нийгмийн аюулын шинж чанар болон хор уршиг нь ирээдүйд илрэх хандлагатай байдаг учир урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь хохирогчийн амь нас, эрүүл мэндийг илүү их аюулд өртөхөөс хамгаалах ач холбогдолтой юм. Иймээс ГБХТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг хуулийн зорилгод нийцүүлэхийн тулд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл бүрт аюулын зэргийн үнэлгээ хийж байхаар өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

3.16. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Практикт нийцэж байгаа байдал
2.	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Зорилгод хүрсэн түвшин

3.16.1. Зорилгод хүрсэн түвшин

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.1. "гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг;

Хохирогчийн эрхийн асуудал нь хүний эрхийн асуудал бөгөөд дэлхийн олон орнууд хүний эрх, түүний дотроос хохирогчийн эрхийн асуудлыг эртнээс анхаарч судлан хамгаалж ирсэн түүхтэй. Энэ ч утгаараа Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 8 сарын 24-ний өдрийн 346 дугаар тогтоолоор "Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан.⁶⁸ Мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 5.3.6-д "Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг

⁶⁷ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Судлаач нийгэм эрх зүйн бодлогын судалгааны хүрээлэн ТББ, УБ, 2023, 51 дэх тал.

⁶⁸ Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн тогтоолоор баталсан "Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр", Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/11387>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.21.

хамгаалах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгож гэрч, хохирогчийн хамгаалалтын цогц механизмыг бүрдүүлнэ” гэж, Засгийн гарын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.5-д “Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасан.⁶⁹

Өөрөөр хэлбэл, дээрх бодлогын баримт бичгүүд нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зорилт болох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Тус хуулийн 4.1.1-д “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг ойлгохоор хуульчилсан.⁷⁰ Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ”, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ” хэмээн хуульчилсан.⁷¹

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тодорхойлсон гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээн хүн буюу хохирогчийг хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар 3 дугаар зүйлийн 3.1.2-т "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсэн хүнийг ойлгоно гэж тайлбарлан хуульчилжээ.⁷²

Харин Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар тодорхойлсон хохирогчийн тодорхойлолт нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтын гадна үлдэж, хууль хэрэглээний төөрөгдөл үүсгэж болзошгүй байна. Иймд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт нь тус хуулийн зорилгод бүрэн нийцэхгүй байна.

3.16.2. Практикт нийцэж байгаа байдал

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.1."гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг;

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан

⁶⁹Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/15586>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.21.

⁷⁰Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг.

⁷¹Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх хэсэг.

⁷²Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэг.

эрх олгосон заалтын судалгааны дүнгээр цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцээд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгосон заалтыг 2 дахин багасгах чиглэл өгсөн.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд “Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ”-г 9 байхаар хуульчилсан. Эдгээр 9 арга хэмжээг Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан журмаар нарийвчлан зохицуулжээ. Тухайлбал, Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Дугаар А/204 тушаалаар “Биечилсэн хамгаалалтын журам”⁷³, Хууль зүйн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Дугаар МН/101 тушаалаар “Нүүлгэн шилжүүлэх журам”⁷⁴ зэргийг дурдаж болно.

Иймд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгосон заалтыг 2 дахин багасгах чиглэлийн дагуу Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан “Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд хамаарах Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний батлах журмыг хуульчлан зохицуулах нь зүйтэй. Улмаар тус хуулийн 7 дугаар зүйлд Хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний холбогдох журам батлах эрхийг хүчингүй болгох шаардлагатай.

3.17. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур
1	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	Зорилгод хүрсэн түвшин

3.17.1. Зорилгод хүрсэн түвшин

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

МУ-ын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэж тус тус заасан.

⁷³ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дугаар А/204 тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/claw/10750/1617671035393657>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.22.

⁷⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн дугаар МН/101 тушаалаар баталсан “Нүүлгэн шилжүүлэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/claw/16468684833861/1652952742477235>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.22.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” нь Бүгд Найрамдах Итали Улсын Палермо хотноо 2000 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, уг Конвенц болон түүний нэмэлт “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”-д Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон.⁷⁵

Дээрх конвенцод нэгдэн орсноор манай улс дотоодын холбогдох хууль тогтоомжуудыг олон улсын стандартад хүргэх ажлыг үе шаттайгаар хийж эхлүүлсэн бөгөөд 2008, 2015 онуудад тус Палермогийн протоколын үндсэн зорилгод нийцүүлэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг /цаашид “ХХТХ” гэх/ баталжээ.

ХХТХ нь 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлагдаж, 2012, 2013, 2015, 2016, 2017, 2018, 2019, 2020, 2021, 2022 болон 2023 онд тус бүр нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заажээ. Уг хуулийн зорилт хэсэгт заасан хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг тус хуулиар хэрхэн зохицуулсан талаар, мөн тэдгээр зохицуулалт нь хуулийн зорилгод нийцэж буй эсэхийг авч үзье.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголтын хувьд:

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон улсын гол тулгуур баримт бичиг болох Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 3 дугаар зүйлд⁷⁶ ‘хүн худалдаалах гэмт хэргийг’ тодорхойлохдоо:

(а) “Хүн худалдаалах гэмт хэрэг” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрөлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтэнийг нь авах үйлдлийг ойлгоно.⁷⁷

(b) Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

⁷⁵ Монгол Улсын хууль, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай, 2008 он.

⁷⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын цахим хуудас, Холбоос: <https://www.unodc.org/> , Сүүлд үзсэн огноо: 2024.04.23.

⁷⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны цахим хуудас, Холбоос: <https://www.unodc.org/e4j/en/tip-> , Сүүлд үзсэн огноо: 2024.04.23.

(с) Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэжээ.

Монгол Улсын эрх зүйн орчны хүрээнд хүн худалдаалах гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал:

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар “Хүн худалдаалах” гэж хүний биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ.

Эрүүгийн хуульд “Хүн худалдаалах” гэж биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

Мөн Улсын Дээд шүүхээс 2008 онд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор тайлбаргаргасан байна. Уг тайлбарт: “Хүн худалдаалах” гэдэг нь тодорхой төлбөртэйгөөр /мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солих гэх мэт/ эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож /өр, зээлэнд өгөх гэх мэт/ хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүрмөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно гэж тодорхойлсон.

Эдгээр тодорхойлолтуудаас үзвэл Монгол олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, үндэсний хууль тогтоомждоо хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголтыг агуулгын хувьд зөрүүгүй тодорхойлжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн тухай ойлголтын хувьд:

МУ-ын холбогдох хууль тогтоомжид “хохирогч”- ийг дараах байдлаар тодорхойлсныг авч үзье.

Хүснэгт 7. Хохирогчийг тодорхойлсон тодорхойлолтууд

Холбогдох хуулиуд	Тодорхойлолт
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015 он	8.1. гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 2012 он	3.1.2 “хохи­рогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ.
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013 он	4.1.1. “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгоно.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2017 он	5.1.2. “гэр бүлийн хүчирхийллийн хохирогч” гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он	3.2. Зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.

Үүнээс үзвэл хүн худалдаалах гэмт хэргийн “хохи­рогч” гэх ойлголтыг ХХТХ-иар илүү өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд цагдаа, шүүхийн байгууллага тухайн этгээдийг хохирогч гэж тогтоосон эсэхээс үл хамаарч, холбогдох үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандан тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн гэдгээрээ бусад хуулиас онцлог байна.

Харин Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар **хохи­рогчоор тогтоогдсон** (шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн) хүн хамаарагдахаар заасан. Энэ нь хохирогч хууль хяналтын байгууллагад хандаагүй тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон гэрчийг хамгаалах тухай хуульд заасан хамгааллын үйлчилгээг авах боломжгүйг харуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хохи­рогч” гэдэгт гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно гэж заасан. Энэ нь хохирогчийг тодорхойлсон хуулийн заалт хооронд агуулгын зөрүү буюу хийдэл, хэм хэмжээний өрсөлдөөн байгааг харуулах ба үүний нөлөөгөөр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон олон хүн хуулийн дагуу шаардлагатай хамгааллын туслалцаа авч чадахгүй нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй. Тухайлбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээг авахын тулд зайлшгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдсон байхаар заасан нь хохирогч хуулийн байгууллагад хандаж тусламж, дэмжлэг авч чадахгүйд хүргэж байгаа юм.

Хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг ХХТХ-иар зохицуулсан байдал:

ХХТХ нь 4 бүлэг 18 зүйлтэй, хуулийн 10 дугаар зүйлд хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах тухай зохицуулсан бол, 12 дугаар зүйлд халамж, үйлчилгээний талаар зохицуулжээ.

Тус хуулийн 10 дугаар зүйлд хохирогчийн болон түүний эцэг эхийн нэр, оршин суух хаяг, хувийн байдал гэх мэт мэдээллийг хамгаалж, бусдад тараахыг хориоглоно гэж заасан боловч хамгаалахын тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар зохицуулаагүй байна.

Мөн хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний тухай ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд дор дурдсан журмуудыг батлан хэрэгжүүлж байгаа боловч эдгээр журамтай холбоотой хохирогч, хамгааллын үйлчилгээний хэрэгжилтийн үр дүнг дүгнэсэн мэдээ, тайлан байхгүй байгаагаас гадна хохирогчдод нэн тэргүүнд шаардлагатай тусламж дэмжлэг болох хамгаалах байр, хоол, хүнс, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ зэрэг анхан шатны үйлчилгээг хэн хэрхэн, ямар санхүүжилтээр үзүүлэх, мөн эдгээр үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой төсвийн талаарх нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Журмууд:

- Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам⁷⁸
- Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам⁷⁹
- Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам⁸⁰
- Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам⁸¹
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам
- ХНХЯ-аас гаргасан Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, үйлчилгээ үзүүлэх журам⁸²
- Гадаад улсад ХХГХ-т өртсөн хохирогчийг эх нутагт нь буцаан авчрах үйлчилгээний журам

Мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх үйлчилгээнд тавих наад захын шаардлагыг тогтоох зорилгоор 2013 онд Монгол Улсын Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 58-р тогтоолоор “ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн

⁷⁸ Эрүүл мэндийн сайд, Хууль зүй зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн дугаар 356, А/182 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/10733>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.23.

⁷⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231177100401>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.23

⁸⁰ Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/10464>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.23.

⁸¹ Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/10465>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.23.

⁸² Хөдөлмөрийн сайдын 2015 оны 07 дугаар 09-ний өдрийн А/135 дугаар тушаалаар баталсан “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, үйлчилгээ үзүүлэх журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail/11340>, Сүүлд үзсэн огноо: 2024.04.23.

үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013) баталсан. Тус стандартаар хохирогчийг хүлээн авах, тодорхойлох, яаралтай анхан шатны үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө боловсруулах, хохирогчийн түүхийг хаах, хохирогчоос утсаар мэдээлэл авах, зөвлөгөө өгөхөд анхаарах асуудал зэрэг суурь шаардлагыг тодорхойлсон.

Гэвч уг стандартын хэрэгжилтэд хяналт тавих механизм бүрдээгүйгээс уг стандарт хохирогч хамгааллын үйлчилгээнд бүрэн мөрдөгдөж буй эсэх, үзүүлж буй үйлчилгээний чанарыг үнэлж дүгнэх боломж хязгаарлагдмал байна. Иймд цаашид уг стандартын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх хэрэгцээ байгаа нь ажиглагдав.

Мөн хуулийг дагаж гарах шаардлагатай журмуудаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам” батлагдаагүй байна. Өнөөдрийн байдлаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дийлэнх нь ОУБ-ын дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа үзүүлж байгаа хэдий ч энэ нь тогтвортой үргэлжлэх нөхцөл хангагдахгүй байгаагаас үзвэл дээрх журмыг яаралтай батлах хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Ийнхүү ХХТХ-ийн зорилт хэсэгт заасан хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой харилцааг тус хуулиар хэрхэн зохицуулсан тухай, мөн тэдгээр зохицуулалт нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх талаар дараах дүгнэлтэнд хүрч байна.

1. Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”-д нийцүүлэн, агуулгын хувьд ямар нэгэн зөрүүгүйгээр холбогдох хуулиудад тодорхойлсон байх боловч уг гэмт хэргийн хохирогчийн талаарх ойлголтыг ялгаатай байдлаар зохицуулсан нь агуулгын зөрүү, эрх зүйн хийдэл, хэм хэмжээний өрсөлдөөнийг бий болгож, практикт олон хүн хуулийн дагуу шаардлагатай хамгааллын туслалцаа авч чадахгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, ХХТХ-иар тухайн этгээд цагдаа, шүүхийн байгууллагаар хохирогч гэж тогтоогдсон эсэхээс үл хамааран үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж тусламж, үйлчилгээ авах эрхтэй бол ГХХТХ-иар зөвхөн хохирогч гэж тогтоогдсон тохиолдолд л уг эрхийг хэрэгжүүлэх боломжтой байгаа юм. Иймээс “хохирогч”-ийн тодорхойлолтыг холбогдох хуулиудад нэг мөр болгох шаардлагатай байна.

2. ХХТХ-ийн 10, 12 дугаар зүйлд хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх талаар зохицуулсан байх хэдий ч үүнтэй холбоотой ямар ажиллагаа явуулах талаар зохицуулалгүй орхисон нь эрх зүйн хийдлийг бий болгожээ.

3. Мөн хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний тухай ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 7 журам батлагдан хэрэгжиж байгаа боловч эдгээр журамтай холбоотой хохирогч, хамгааллын үйлчилгээний хэрэгжилтийн үр дүнг дүгнэсэн мэдээ, тайлан байхгүй байгаагаас гадна хохирогчдод нэн тэргүүнд шаардлагатай тусламж дэмжлэг болох хамгаалах байр, хоол, хүнс, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ зэрэг анхан шатны үйлчилгээг хэн хэрхэн, ямар санхүүжилтээр үзүүлэх, мөн эдгээр үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой төсвийн талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Эдгээрээс үзэхэд ХХТХ-ийн хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон зохицуулалтууд нь хуулийн зорилгод нийцээгүй, эрх зүйн хийдэл бүхий байх тул холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан дэлгэрүүлж, боловсронгуй болгох шаардлагатай

3.18. Агаарын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагавар

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт
1.	6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх	Зорилгод хүрсэн түвшин
2.	15 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүс	Зорилгод хүрсэн түвшин
3.	9 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг	Зорилгод хүрсэн түвшин

3.18.1. Зорилгод хүрсэн түвшин

6.1.4. агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнах;

9.1.5. аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх;

15.7. Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна.

Агаарын тухай хуулийн зорилт нь “...хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино...” гэжээ. Уг зорилтыг биелүүлэхэд тус хуулийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ба түүний гүйцэтгэл чухал ач холбогдолтой.

Өөрөөр хэлбэл, Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 15 дугаар зүйлийн 15.7 дахь заалтаар агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилт, агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг эрх бүхий байгууллагад тайлагнахаар хуульчилсан бөгөөд иргэд дээрх мэдээлэлтэй танилцах боломж хязгаарлагдмал байна. Тухайлбал, Агаарын тухай хуулийн 6.1.4-т агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнахаар заажээ. Угтаа хэрэгжилтийн тайланг гагцхүү УИХ-д тайлагнах биш иргэдэд бас энэхүү төлөвлөгөө нь ямар хэрэгжилттэй байгаа талаар мэдээлэл өгөх нь чухал.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 19 дүгээр хуралдааны 10 дугаар ерөнхий тайлбарт төрийн байгууллагад байгаа мэдээллийг олж авах эрхийг хөхиүлэн дэмжинэ. Хадгалж буй арга хэлбэр, эх сурвалж, мэдээлэл үүссэн цаг хугацаанаас үл хамааран төрийн байгууллагад авагдсан бүх төрлийн баримтыг энэ төрийн мэдээлэл гэж үзнэ. Төрийн байгууллага гэдэгт төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг мөн оруулж ойлгоно. Мэдээлэл авах эрхийг хангахын тулд улс нийтийн ашиг

сонирхолд хамаарах өөрт байгаа мэдээллийг өөрийн санаачлагаар ил болгож, олон нийт хялбар, шуурхай, үр дүнтэй, бодитой танилцах боломжийг бүрдүүлнэ. Мэдээлэл өгөхгүй бол мэдээлэл өгөхөөс татгалзсан шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлах үүрэгтэй байхаар тайлбарласан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 7 дахь хэсэгт төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй байхаар заасан. Түүнчлэн Улсын Их Хурлаас 2021 онд хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилго бүхий Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг батлан хэрэгжиж байна. Иймд дээрх хуульд нийцүүлэн Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэгт тус тус өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг нь хуулийн үндсэн зорилгод нийцэхгүй байх тул нэмэлт, өөрчлөлт оруулж тусгах нь зүйтэй. Ингэхдээ иргэдийн мэлээлэл авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах шаардлагын дагуу Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнах, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх үүргийг хүлээхээс гадна дээрх тайлан мэдээг олон нийтэд заавал мэдээлэх агуулгыг тусгах нь зүйтэй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээнд нийцүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолд заасан анхаарах асуудал, авч хэрэгжүүлэх арга хэмжээнд хамаарах багц хууль тогтоомжийн холбогдох зохицуулалтын хэрэгжилтийг судалж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв. Үүний үр дүнд тулгуурлан дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа:

1. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 1.1-д “Тус хуулийн зорилт нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэжээ. Гэвч тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Хоригдсон этгээдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянана...” гэж хуульчилсан нь хүний захидал, харилцааны нууцад шууд халдсан буюу хүний хувийн нууцад шалтгаангүй халдах нөхцлийг бүрдүүлсэн байна. Иймд сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “... заавал хянана” гэж хатуу заасныг өөрчлөн, шаардлагатай тохиолдолд хянаж болох агуулгаар тусгах нь зүйтэй.

2. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

- Хуульчийн сургалтын тухайд:

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 55 дугаар зүйлийн хүрээг “Хуульчийн сургалт зохион байгуулах хугацаа” хэмээн хумьж, 55.1-д зөвхөн сургалтын хугацааг заасан нь хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах ерөнхий чиглэлийг тусгаагүй, сургалтын агуулгыг тодорхойлоогүй байдлыг үүсгэсэн байна. Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 55 дугаар зүйлийг зөвхөн сургалтын хугацаа гэж хязгаарлалгүй, “Хуульчийн сургалт” эсхүл “Хуульчийн сургалт зохион байгуулах” хэмээн ерөнхий байдлаар томъёолж, Хуульчдын Холбооны зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журамд заасан сургалтын төрөл, зорилго, сургалтын ерөнхий агуулгыг тус хуулийн 55 дугаар зүйлд хуульчлах, улмаар тухайн сургалтыг зохион байгуулах давтамж, тоо хэмжээг тусгах нь зүйтэй.

- Хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох тухайд:

Шүүгчийн туслах. 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулиар шүүгчийн туслахын албан тушаалд хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрөл авсан этгээд ажиллах шинэ зохицуулалт орсон ч 2023 оны байдлаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй буюу эрх зүйч шүүгчийн туслах практикт олон

байгаа бөгөөд ажлаас чөлөөлсөн тохиолдолд шүүхэд уг албан тушаалын хүний нөөцийн хомсдол үүсэж, улмаар шүүн таслах ажиллагааны хэвийн нөхцөл алдагдахад хүрэхээр байгаа өнөөгийн практик; хууль зүйн үр дагавар шууд үүсгэх мэргэжлийн үйл ажиллагааг явуулахаас илүүтэйгээр шүүхийн тогтолцооны хүрээнд захиргааны шинжтэй ажил эрхэлж, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гэж үзэн шүүгчийн туслахыг хуульчийн мэргэжлийн хүрээнд оруулдаггүй гадаад орны туршлага зэргийг харгалзан энэхүү албан тушаалд заавал хуульч байх шаардлагыг тавихгүй байж болох юм.

Иймд дээр дурдсан өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан шүүгчийн туслахын албан тушаалд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардахгүй байх, улмаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан “Хуульчийн мэргэжлийн дадлага”-д хамаарах албан тушаалд нь тооцох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан Шүүхийн тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль зэрэг хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга. Холбогдох УДШ-ийн тайлбар, ҮХЦ-ийн дүгнэлт, МХХ-ны журамд тусгасныг үзвэл шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар ажилласныг хуульчийн мэргэжлээр ажилласанд тооцож байсан түүх байна. Гэтэл хуульчийн мэргэжлийн тогтолцооны шинэчлэлээр, ХЭЗБТХ-ийн 11.1 дүгээр зүйлд заасны дагуу шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаал “хуульчийн мэргэжлийн дадлага”-д ч хамаарахгүй болсон нь хууль, эрх зүйн зөрчил, хийдэл болон тодорхойгүй байдлыг үүсгэж байна. Түүнчлэн Хууль зүйн их, дээд сургууль төгссөн хүн хоёр жил мэргэжлээрээ ажилласан тохиолдолд хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, улмаар хуульчаар буюу шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчаар болон бусад хуульчаар ажиллах боломжийг хязгаарлан ХЭЗБТХ-д тодорхой тооны этгээдэд олгохоор хуульд заасан нь тэдгээртэй адилтган үзэж болох ажил, албан тушаал эрхэлж буй бусад иргэдийг ялгаварлан гадуурхаж, тэгш бус байдал үүсгэж байна гэж үзсэн иргэдтэй хууль тогтоох байгууллагын итгэмжилсэн төлөөлөл санал нийлж, уг хуулийн маргаан бүхий зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн байна.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан “Хуульчийн мэргэжлийн дадлага” гэдэгт шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалыг хамруулснаар хуульчийн мэргэжлийн шалгалт өгөх эрхтэй болох, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, улмаар хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажиллах боломж нээгдэнэ.

- Хуульчдын холбооны татварын тухайд:

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөлөгч бүр хуульч байх шаардлагын улмаас өмгөөлөгч нь хоёр холбоонд давхар харьяалагдан гишүүнчлэлийн татвар, хураамж төлснөөр татварын “шударга байх, зайлшгүй байх” зарчим алдагдаж, Монгол Улсын нийт 1196 өмгөөлөгч хуульчийн эрх ашиг зөрчигдөж байна.

Иймд 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасныг хэрэгжүүлж, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байх зохицуулалтыг холбогдох хуульд тусгах шаардлагатай. Үүний хүрээнд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд Монголын Хуульчдын холбооны гишүүний татвар, Монголын Өмгөөлөгчдийн холбооны

гишүүнчлэлийн хураамжийг давхардуулж авахгүй байх тухай зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Цагдаагийн албаны тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Цагдаагийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно" гэж заасны улмаас "мэргэжлийн бэлтгэл", "давтан" болон "албаны" гэсэн сургалтын төрлүүдийг зөвхөн хуульчилж, цагдаагийн албаны хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч хууль сахиулагчийг бэлтгэх, холбогдох бодлогын баримт бичигт тусгасан нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлж цагдаагийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн, тухайлбал цагдаагийн алба хаагч, ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлийн сургалт явуулахтай холбоотой эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

Иймд холбогдох судалгааны дүгнэлт, саналд үндэслэн Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн албаны сургалтын тогтолцоо, тухайлбал тус албанд шаардлагатай сургалтын төрлүүдийг зохистой бүрдүүлэх, жишээлбэл цагдаагийн алба хаагч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах "ур чадварын сургалт"-ын төрлийг Цагдаагийн албаны тухай хуульд нэмж тусгах, бусад холбогдох харилцааг зохицуулах шаардлагатай. Улмаар цагдаагийн албаны сургалттай холбоотой журам, хөтөлбөр, түүнд заасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын нэр, агуулга, хэлбэрийг Цагдаагийн албаны тухай хуульд нийцүүлэх шаардлагатай.

Цагдаагийн албаны тухай хуульд сургалт явуулах сургалтын төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно гэж заасан зохицуулалт практикт нийцэж байгаа хэдий ч сургалтын тогтолцоо, зохистой сургалтын төрөл, хэлбэрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг мөн анхаарах шаардлагатай.

4. Харилцаа холбооны тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан зохицуулалт нь хэт ерөнхий, тодорхойгүй буюу эрх зүйн зохицуулалтад шаардагдах харилцааг хуульчлан томъёолохдоо шийдвэрлэх асуудлыг бүрэн тодорхойлж чадаагүйн улмаас эрх зүйн хийдэл үүсгэж, практикт хэрэгжихэд төвөгтэй байдлыг үүсгэсэн байна. Иймд уг зохицуулалтыг илүү нарийвчлан дэлгэрүүлж, холбогдох албан тушаалтан, төлөөллөөс санал болгож буй нэр дэвшигчдээс сонгох байдлаар өөрчлөн найруулах шаардлагатай.

5. Өмгөөллийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтад "энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;" гэж заасан буюу хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа, эсхүл улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахгүй байх зохицуулалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг

хязгаарласан байх магадлал үүсгэснийг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд залруулах боломжтой. Иймд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болгох шаардлагатай. Ингэснээр хуульчдын өмгөөлөгчийн шалгалтад орох эрхийг хязгаарласан зөрчил арилж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хангагдана.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу өмгөөлөгч бүр хуульч байх шаардлагын улмаас өмгөөлөгч нь хоёр холбоонд давхар харьяалагдан гишүүнчлэлийн татвар, хураамж төлснөөр татварын “шударга байх, зайлшгүй байх” зарчим алдагдаж, Монгол Улсын нийт 1196 өмгөөлөгч хуульчийн эрх ашиг зөрчигдөж байна. Үүнийг шийдвэрлэхээр 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхтай холбоотой зохицуулалтыг Өмгөөллийн тухай хуульд, түүнчлэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгах шаардлагатай.

6. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Төрийн болон албаны нууцын тухай хууль дахь “албаны нууц”-ын тодорхойлолт нь хэт өргөн, тодорхойгүй бөгөөд ялгаа зааг, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс албаны нууцыг ангилалд хүндрэл учирч, төрийн байгууллагын удирдлагууд өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал үүсэж байгаа нь МУ-ын Үндсэн хуульд заасан иргэний төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих, нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчиж байх тул уг зохицуулалт нь ТБАНТХ-ийн зорилгод нийцээгүй байна.

“Албаны нууц” гэх ойлголт гаднын улс оронд, тухайлбал Казакстан, Киргизстан, Узбекистан зэрэг пост социалист улсад (служебная тайна) байх боловч албаны нууц нь төрийн нууцын “нууц” ангилалд хамаардаг. Ийнхүү хуульчилсан нь Монгол Улстай адил боловч албаны нууцыг төрийн байгууллагын даргын тушаалаар тогтоодоггүй. Харин бусад улс орнуудын нийтийн мэдээллийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид “албан мэдээлэл” гэх ойлголт цөөнгүй тусгагджээ. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах боломжтой ч хязгаарласан мэдээллийг нууц гэж үздэггүй байна.

Иймд Төрийн нууцын хууль тогтоомж дахь “албаны нууц” гэх ойлголтыг халж, Нийтийн мэдээллийн тухай хуулиар үүнд холбогдох харилцааг зохицуулах, хязгаарлаж болох албан мэдээллийн жагсаалтыг байгууллагын дотоод журмаар нэг удаа батлаад орхих бус жил бүр, эсхүл тодорхой давтамжтайгаар шинэчилж байх зохицуулалтыг тусгаж, төрийн байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтнуудын ойлголтыг нэгдмэл болгох шаардлагатай. Байгууллагын дотоод журам, жагсаалт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн байх, хэрэв зөрчилдвөл уг хуулийн давуу байдлыг хангах зохицуулалтыг хуульчилбал өнөөгийн практикт тулгарч буй хууль хэрэглээний хүндрэлийг даван туулахад чухал ач холбогдолтой юм.

7. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хуульд тусгасан Монгол Улсын иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлдүүлэх үндэслэлийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлж өөрчлөн, найруулах нь зүйтэй. Ингэхдээ хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх зохицуулалт үйлчилж ирснийг халах шаардлагатай. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт цагдаагийн байгууллага хяналт тавих зохицуулалт хуулийн зорилгод нийцэхгүй байна. Иймд Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагааг нарийвчлан хуульчлах, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, цуцалсан талаарх мэдээллийн нэгдсэн сан байгуулах, эрх бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам батлах эрхийг Засгийн газарт олгохоор хуульчлах боломжтой гэж үзэж байна.

8. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.27-д "нөлөөллийн урьдчилсан үнэлгээ" гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг ойлгохоор заажээ. Үүнд хөгжлийн төлөө төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ үүсч болох эрсдэл, хохирлыг бууруулах үүднээс хүний эрхийн чиглэлээр тооцоо, судалгаа хийх зохицуулалт орхигдсон байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн халдашгүй байдалтай холбоотой судалгаа хийж, нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд тусгах шаардлагатай.

9. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Монгол Улс цахим засаглалыг хөгжүүлэх чиглэлд хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийтийн мэдээллийн ил байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бол бодлого, стратегийн хүрээнд Шинэ сэргэлтийн бодлого, Төрийн бүтээмжийн сэргэлт, "Цахим үндэстэн" дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд цөөнгүй бодлогын баримт бичиг батлагдсан байна. Гэвч зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд цахимжуулах, мэдээллийн нэгдсэн сантай холбоотой эрх зүй орчин байхгүй. Иймд зөрчил шалган шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн цахим сангийн эрх зүйн зохицуулалтыг нэмэх нь зүйтэй.

Мөн эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг Зөрчлийн тухай хуулийн шинэчлэлд нийцүүлэн оновчтой тогтоох, улмаар хэрэгжих баталгааг бүрдүүлэх зорилгоор хүний нөөц, төсөв, зохион байгуулалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай.

10. Зөрчлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Зөрчлийн тухай хуулийн 3.7.4 дахь заалтын үйлчлэх хүрээ хязгаарлагдмал бөгөөд үүнээс үүдэн анхан шатны шүүхээр шийдэгдэж буй зөрчлийн хэрэгт баривчлах шийтгэл оногдуулах нь элбэг байна. Иймд анхан шатны шүүхээс баривчлах шийтгэл оногдуулах тоог багасгахын тулд Зөрчлийн тухай хуулийн 3.7.4 дэх заалтын хүрээг нэмэгдүүлэх буюу баривчлах шийтгэл оногдуулж болохгүй тохиолдлыг нэмж тусгах хувилбар зохистой гэж үзэж байна. Тухайлбал, тус заалтад арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг эх гэж оруулсан нь учир дутагдалтай байх тул арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх гэж өөрчлөн найруулах нь зүйтэй. Мөн бага насны хүүхэдтэй эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн гэх мэт субъектыг хүндэтгэн үзэж, баривчлах шийтгэл оногдуулахгүй байх тохиолдолд хамруулж хуульчлах нь зүйтэй. Мөн тухайн заалт дахь “баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн” гэснийг тодорхойлж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд тус хуулийн 3.4.7 дахь заалтын үйлчлэх хүрээг 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх, арван зургаа насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн гэх мэт субъектыг баривчлах шийтгэл оногдуулахгүй байх тохиолдолд хамруулж хуульчлах нь зүйтэй.

11. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, мөн нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хуульд заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмаар зохицуулж байсан харилцааг Хууль зүйн туслалцааны тухай хуулиар зохицуулах, тус хуульд байгаа журамт батлах эрх олгосон заалтыг хүчингүй болгох шаардлагатай.

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлж болох агуулгаар тусгасныг заавал үзүүлэхээр болгон өөрчилж, мөн хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрсэн хохирогч нь төлбөрийн чадваргүй тохиолдолд л туслалцаа үзүүлэхээр заасныг энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг заавал төлбөрийн чадваргүй байхыг шаардахгүй байхаар өөрчлөн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээ хязгаарыг өргөжүүлж, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт заасан “ахмад настан”, “хөдөлмөрийн чадвараа алдсан хүн”, “өрх толгойлсон эцэг эх”, “олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх” зэрэг нэр томъёоны тайлбарыг бусад холбогдох хууль тогтоомжоос эшлэл байдлаар оруулж уялдаа холбоог хангах нь зүйтэй.

12. Дайчилгааны тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлд улсын дайчилгаа явуулахад авч хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг хуульчлахдаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа зохицуулах тухай заалт оруулсан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгасан хүний эрхийн зарчим, хэм хэмжээтэй зөрчилдөж байна. Мө[1]н 1988 онд Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө баталгаажуулах үүднээс батлагдсан Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн “хэвлэл

мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд төрөөс хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэх заалтад халдсан зохицуулалт болжээ. Иймд Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8-д хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа зохицуулах” гэж заасныг хасах нь зүйтэй.

13. Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

МУ-ын Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийг хуульчлахдаа Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийн зорилгод заасан “хүчээр алга болгох” ойлголтыг агуулаагүй байх тул хуулийн зорилгод хүрээгүй зохицуулалт байна гэж үзэв. Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийг тодорхойлохдоо “хүнийг хууль бусаар хорьсон...” гэх үйлдлийг тусгасан байгааг гэмт хэргийн төрөл болгож Эрүүгийн хуульд нэмэлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан эрүүдэн шүүх гэмт хэргийн тодохойлолтод “ялгаварлах” гэдгийн араас “айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх” гэсэн агуулга нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнд холбогдох 9 хэм хэмжээ нь хангалтгүй зохицуулалт байх тул эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацаа, төрөл, өөрчлөх, зогсоох байдал зэргийг нарийвчлан тусгах шаардлагатай.

Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд цалин хөлсгүй гэдгийг албадан хөдөлмөрлүүлсэн гэмт хэргийг тодорхойлох нэг шинж болгосон нь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хүрээг хэт явцууруулсан байх тул ямар нэг шийтгэл ногдуулахаар заналхийлэх; аливаа иргэний хүсэл зоригийн эсрэг гэх мэт шинжийг нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

14. Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу Комиссын даргыг Улсын Их Хурлын даргын саналаар томилох нь Хүний эрхийн Үндэсний Комиссын хараат бус байдалд нөлөөлөхөөр байна гэж үзэж байна. Учир нь Улсын Их Хурлын даргын зүгээс Комиссын даргыг Улсын Их Хуралд санал болгохдоо тус комиссын гишүүдийн боловсрол, ур чадвар зэргийг харгалзахгүйгээр, өөрийн үзэмжээр санал болгох нөхцөл бүрджээ. Ийнхүү комиссын даргыг Улсын Их Хурлын даргын санаачилгаар буюу үзэмжээр томилох нь комиссын үйл ажиллагаанд баримтлах хараат бус, бие даасанбайх зарчимд харшилж байна.

Иймд, Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Комиссын даргыг гишүүдийн дотроос Улсын Их Хурлын даргын санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.” гэснийг Комиссын даргыг гишүүд дотроосоо нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар томилж, даргын ажлын тайланг үнэлсний үндсэн дээр бүрэн эрхийн хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх боломжтой.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны дарга, гишүүнд тавигдах шаардлагыг эрхэлсэн ажил, албан тушаал, мэдлэг туршлага, цаг хугацаагаар нь ялгамжтайгаар хуульчилсан нь иргэдийн төрдөө итгэх итгэлийг алдагдуулах төдийгүй хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Иймд хууль хоорондын зөрчлийг арилгаж, уялдаа холбоог хангах шаардлагатай.

15. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т заасны дагуу цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил, гэмт хэрэгт аюулын зэргийн үнэлгээ хийснээр хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан болон учирч болохуйц эрсдэлийн түвшинг үнэлж, аюулгүй байдлыг нь хамгаалах арга хэмжээ авах зорилготой тул уг зохицуулалт тус хуулийн зорилгод нийцсэн байна. Гэхдээ аюулын зэргийг үнэлэх ажиллагааг нарийвчлах, тухайлбал насанд хүрээгүй, монгол хэл, бичиг мэдэхгүй, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээ шаардлагатай хүний тухайд аюулын зэргийг үнэлэхэд баримтлах зарчим, стандарт, тэдгээрийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн бусад мэргэжилтнийг оролцуулах шаардлага зэргийг тусгах нь зүйтэй. Ингэснээр тус хуулийн зорилго дахь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоохын зэрэгцээ хүчирхийлэлд өртсөн этгээдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, улмаар урьдчилан сэргийлэх зэрэг цогц асуудлын эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

Цагдаагийн алба хаагчид гэмт хэргийн нөхцөлөөс шалтгаалан дийлэнх тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа хийх шаардлага гардаг тул аюулын зэргийн үнэлгээг гэмт хэргийн тохиолдол бүрд хийх боломжгүй байдаг. Иймээс хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах, саатуулах, хохирогчийг холбон зуучлах гэх мэт хойшлуулшгүй ажиллагаа хийх болсон тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг хэрхэн хийх тухай зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгах, үнэлгээний зарим асуултыг шинэчлэх, хасах, бага насны хүүхдээс асуухад тохиромжтой байхаар хялбаршуулж, ангилах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг нь ихэвчлэн далд хэлбэрээр үйлдэгддэг, нийгмийн аюулын шинж чанар болон хор уршиг нь ирээдүйд илрэх хандлагатай байдаг учир урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь хохирогчийн амь нас, эрүүл мэндийг илүү их аюулд өртөхөөс хамгаалах ач холбогдолтой юм. Иймээс ГБХТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийг хуулийн зорилгод нийцүүлэхийн тулд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэл бүрт аюулын зэргийн үнэлгээ хийж байхаар өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.

16. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.1-д “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгатын тухай хуульд заасан гэрчийг ойлгохоор хуульчилсан. Гэвч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар хохирогчийг тодорхойлохдоо Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтын гадна үлдээж, хууль хэрэглээний

төөрөгдөл үүсгэж байна. Иймд гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийг нэмж хуульчлах нь зүйтэй.

Мөн Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгосон заалтыг 2 дахин багасгах чиглэлийн дагуу Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд хамаарах Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулж буй харилцааг хуульд тусгажоруулах, үүнтэй холбогдуулан Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний холбогдох журам батлах эрхийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэж байна.

17. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг судалсан энэхүү судалгаа болон бусад судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

- Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”-д нийцүүлэн, агуулгын хувьд ямар нэгэн зөрүүгүйгээр холбогдох хуулиудад тодорхойлсон байх боловч уг гэмт хэргийн хохирогчийн талаарх ойлголтыг ялгаатай байдлаар зохицуулсан нь агуулгын зөрүү, эрх зүйн хийдэл, хэм хэмжээний өрсөлдөөнийг бий болгож, практикт олон хүн хуулийн дагуу шаардлагатай хамгааллын туслалцаа авч чадахгүй нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, ХХТХ-иар тухайн этгээд цагдаа, шүүхийн байгууллагаар хохирогч гэж тогтоогдсон эсэхээс үл хамааран үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж тусламж, үйлчилгээ авах эрхтэй бол ГХХТХ-иар зөвхөн хохирогч гэж тогтоогдсон тохиолдолд л уг эрхийг хэрэгжүүлэх боломжтой байгаа юм. Иймээс “хохирогч”-ийн тодорхойлолтыг холбогдох хуулиудад нэг мөр болгох шаардлагатай байна.

- ХХТХ-ийн 10 дугаар зүйл, 12 дугаар зүйлд хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх талаар зохицуулсан байх хэдий ч үүнтэй холбоотой ямар ажиллагаа явуулах талаар зохицуулалгүй орхисон нь эрх зүйн хийдлийг бий болгожээ.

- Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний тухай ХХТХ-ийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 7 журам батлагдан хэрэгжиж байгаа боловч эдгээр журамтай холбоотой хохирогч, хамгааллын үйлчилгээний хэрэгжилтийн үр дүнг дүгнэсэн мэдээ, тайлан байхгүй байгаагаас гадна хохирогчдод нэн тэргүүнд шаардлагатай тусламж дэмжлэг болох хамгаалах байр, хоол, хүнс, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ зэрэг анхан шатны үйлчилгээг хэн хэрхэн, ямар санхүүжилтээр үзүүлэх, мөн эдгээр үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой төсвийн талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Дээрх судалгаа, шинжилгээний дүгнэлтэд тулгуурлан ХХТХ-ийн хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон зохицуулалтууд нь хуулийн зорилгод нийцээгүй, эрх зүйн хийдэл үүсгэсэн шинжтэй байх тул холбогдох зохицуулалтуудыг нарийвчлан дэлгэрүүлж, боловсронгуй болгох шаардлагатай.

18. Агаарын тухай хуулийн холбогдох зохицуулалтын хувьд

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэгт заасан зохицуулалт нь тус хуулийн үндсэн зорилгод нийцэхгүй байх тул өөрчлөх нь зүйтэй. Ингэхдээ иргэдийн мэлээлэл авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах шаардлагаар Агаарын ухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнах, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх үүргийг хүлээхээс гадна дээрх тайлан мэдээг олон нийтэд заавал мэдээлэх агуулгыг тусгах нь зүйтэй.

ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ

I. Монгол Улсын хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн Хууль, (1992 он).
2. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр цагаачлах тухай хууль, (1993 он).
2. Дайчилгааны тухай хууль, (1998 он).
3. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, (1998 он).
4. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, (1999 он).
5. Харилцаа холбооны тухай хууль, (2001 он).
6. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, (2012 он).
7. Нийгмийн халамжийн тухай хууль, (2012 он).
8. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, (2012 он).
9. Агаарын тухай хууль, (2012 он).
10. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, (2013 он).
11. Эрүүгийн хууль, (2015 он).
12. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, (2016 он).
13. Төрийн болон албаны нууцийн тухай хууль, (2016 он).
14. Цагдаагийн албаны тухай хууль, (2017 он).
15. Эцэг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, (2017 он).
16. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, (2017 он).
17. Зөрчлийн тухай хууль, (2017 он).
18. Ахмад настны тухай хууль, (2017 он).
19. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, (2017 он).
20. Өмгөөллийн тухай хууль, (2019 он).
21. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, (2020 он).
22. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, (2020 он).
23. Хөдөлмөрийн тухай хууль, (2021 он).
24. Хууль зүйн туслалцааны тухай хууль, (2022 он).

II. Хэм хэмжээний акт

1. Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/91 дугаар тушаалаар баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”.
- 2.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дугаар А/204 тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”.
- 3.Эрүүл мэндийн сайд, Хууль зүй зүйн сайдын хамтарсан 2014 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн дугаар 356, А/182 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”.
- 4.Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”.
- 5.Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”.
- 6.Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн тогтоолоор баталсан “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”.
- 7.Хөдөлмөрийн сайдын 2015 оны 07 дугаар 09-ний өдрийн А/135 дугаар тушаалаар баталсан “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, үйлчилгээ үзүүлэх журам”.
- 8.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”.
- 9.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн дугаар МН/101 тушаалаар баталсан “Нүүлгэн шилжүүлэх журам”.
- 10.Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”.
- 11.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/37 дугаар тушаалаар баталсан “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”.
- 12.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоолоор баталсан “Хөтөлбөр батлах тухай”.
- 13.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”.
- 14.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/351 дугаар тушаалаар баталсан “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”.
- 15.Монголын Хуульчдын Холбооны зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 06 дугаар тогтоолоор баталсан “Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тогтоох журам”.

16.Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”.

III. Монгол хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, судалгааны тайлан, эмхэтгэл

- 1.Х.Эрдэнэбат, Хувь хүний халдашгүй эрх, (УБ, 2002).
- 2.С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг, (анхны хэвлэл), (УБ, 2007).
- 3.Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, (УБ, 2010).
- 4.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Хүний эрхийн тайлан, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв, (УБ, 2014).
- 5.ОУХБ-ын Албадан хөдөлмөрийн тухай конвенц (1930)-ийн 2014 оны протоколд нэгдэн орох боломжийн талаарх танилцуулга.
- 6.Монгол Улсын бодлогын хураангуй: Албадан хөдөлмөр, (УБ, 2016).
- 7.Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, Монголын Криминологичдын Холбоо, (УБ, 2018).
- 8.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар цагдаагийн алба хаагчид хүлээлгэсэн үүргийн хэрэгжилт, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, (УБ, 2018).
- 9.Монгол Улсын шүүхийн тайлан, 2019 он, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, (УБ, 2020).
- 10.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь, Монгол улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх төсөл, (УБ, 2021).
- 11.Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, Цагдаагийн ерөнхий газар, (УБ, 2021).
- 12.Монгол Улсын шүүхийн тайлан, 2021 он, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, (УБ, 2022).
- 13.НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, (УБ, 2022).
- 14.Д.Баярсайхан, Эрх зүйн онол, (УБ, 2023).
- 15.Монгол Улсын шүүхийн тайлан, 2022 он, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, (УБ, 2023).
- 16.Хувь заяа нь тодорхойгүй байгаа хүчээр алга болсон хүн болон тэдгээрийн төрөл садны эрх зүйн байдал, сураггүй алга болсонд тооцох журам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, (УБ, 2023).
- 17.Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном, 2022 он, Цагдаагийн ерөнхий газар, (УБ, 2023).

18. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Цагдаагийн албанд тулгамдаж буй эрх зүйн зарим асуудал, харьцуулсан судалгаа, (УБ, 2023).

III. Гадаад улсын хууль тогтоомж

- 1.State Secrets and Classified Information of Foreign States Act of Estonia.
- 2.Закон Республики Казахстан от 15 марта 1999 года № 349-І О государственных секретах.
- 3.Закон КР от 15 декабря 2017 года № 210 (15) “О защите государственных секретов Кыргызской Республики”.
- 4.Закон Республики Узбекистан, от 07.05.1993 г. № 848-ХІІ.

IV. Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, судалгааны тайлан, эмхэтгэл

- 1.David Banisar, Comments on Moldovan Draft Law on State and Official Secrets, 2005, <https://www.osce.org/files/f/documents/3/7/16548.pdf> .

V. Монгол цахим эх сурвалж

- 1.Эрх зүй мэдээллийн нэгдсэн сан <https://legalinfo.mn/mn> .
- 2.Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн цахим хуудас <https://surgalt.police.gov.mn/> .

VI. Гадаад цахим эх сурвалж

- 1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын цахим хуудас <https://www.unodc.org/> .
- 2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны цахим хуудас <https://www.unodc.org/e4j/en/tip-> .
- 3.ICMP, Legal Frameworks and Rights <https://www.icmp.int/the-missing/legal-frameworks-and-rights/>,